



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA



БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ

Улаанбаатар 2020

Агуулга

Товчилсон үгс.....	4
Нэр томъёо.....	5
ТАНИЛЦУУЛГА	6
1.1 Зорилт.....	6
1.2 Компакт гэрээ болон хөтөлбөрийн тухай	8
1.3 Төслийн тухай	9
1.4 “Байгаль орчин, нийгмийн менежментийн систем” баримт бичгийн бүрдэл.....	10
БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН БОДЛОГО БА ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ.....	12
2.1 Монголын Мянганы Сорилтын Сангийн баримталж буй бодлого	12
2.2 Төслийн байгаль орчны ангилал.....	13
2.3 Олон улсын Санхүүгийн корпорацын Гүйцэтгэлийн стандарт.....	14
2.4 Монголын Байгаль орчин, нийгмийн тухай хууль тогтоомж.....	16
ЭРСДЭЛ НӨЛӨӨЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ.....	18
3.1 Төслийн боломжит нөлөөлөл.....	19
3.1.1 Хүлээгдэж буй эерэг нөлөөлөл.....	19
3.1.2 Боломжит эрсдэл ба нөлөөлөл.....	20
3.1.3 Зураг төслийн үе шатны нөлөөлөл.....	20
3.1.4 Барилгын ажлын үеийн нөлөөлөл.....	21
3.1.5 Хуримтлагдах нөлөөлөл.....	22
3.1.6 Байгаль орчин, нийгмийн нөлөөллөөс зайлсхийх, багасгах арга хэмжээ.....	22
БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭ.....	23
4.1 Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээний тойм	23
4.2 Байгаль орчин, нийгмийн менежментийн үе шатууд.....	30
4.2.1 1-р үе шат - Үнэлгээ.....	31
4.2.2 2-р үе шат – Байгаль орчны бичиг баримт боловсруулах	32
4.2.3 3-р үе шат – Барилгын ажлын үеийн сөрөг нөлөөллийг бууруулах.....	33
4.2.4 4-р үе шат – Мониторинг үнэлгээ.....	34
4.2.5 5-р үе шат– Төслийн хаалт	34
4.3 Төслийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө.....	34
4.4 Оролцогч талуудын оролцоог хангах.....	34
4.4.1 Төслийн нөлөөлөлд өртсөн иргэдтэй уулзах.....	35
4.4.2 Эмзэг бүлгийн иргэд болон эмэгтэйчүүдийн мэдлэгийг дээшлүүлэх.....	35
4.4.3 Мэдээллэх	Error! Bookmark not defined.
4.4.4 Хэлэлцүүлэг хийх.....	35
4.4.5 Оролцооны арга хэрэглэх.....	35
4.5 Санал, гомдол барагдуулах механизм.....	36
4.5.1 Гомдол хүлээн авах.....	36
4.5.2 Гомдол саналд хариу өгөх.....	36

4.5.3	Гомдол, саналыг хаах	37
4.6	Гамшгийн болон онцгой байдлын үед авах арга хэмжээ	37
4.7	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон Хог хаягдлын менежмент	38
4.8	Хаалтын төлөвлөгөө	41
БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЧАДАМЖ		43
5.1	Монголын МСС болон Байгаль орчин, нийгмийн асуудал	43
5.1.1	Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн үүрэг хариуцлага.....	43
5.2	Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн оролцоо	44
5.2.1	Төслийн үйл ажиллагаа	44
5.3	Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн баг	44
5.4	Сургалт.....	45
5.4.1	Ажилчдад зориулсан байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт	45
5.4.2	Суурилуулсан тоног төхөөрөжийн ашиглалт, засвар үйлчилгээний талаар үзүүлэх сургалт	46
МОНИТОРИНГ ҮНЭЛГЭЭ ХИЙХ		46
6.1	Байгаль орчин, нийгмийн шаардлагын нийцлийг шалгах	46
6.2	Байгаль орчин, нийгмийн мониторинг хийж гүйцэтгэх этгээд	46
6.3	Тайлагнах шаардлага	47
6.4	МСК болон Монголын МСС-гийн удирдлагад хагас жилээр болон жилийн эцсээр тайлагнах	47
БОНМС-ИЙГ ШИНЭЧЛЭН САЙЖРУУЛАХ		47
Хавсралт 1 – Монгол Улсын хууль тогтоомж, ОУСК-ын Гүйцэтгэлийн стандартын харьцуулалт		49
Хавсралт 2—Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө		51
Хүснэгт 3-- Нүүлгэн шилжүүлэх, амьжиргааг сэргээх бодлогын хүрээ.....		54
Хавсралт 4 -- Онцгой байдал, гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөний төсөл.....		54
Хавсралт 5 – Археологийн болон соёлын өвийн журам		57
Хавсралт 6 – Талуудын оролцоог хангах төлөвлөгөө		58

Хүснэгт

Хүснэгт 1: Уг баримт бичиг нь үндсэн 7 бүлэг, 6 хавсралтаас бүрдэнэ.	10
Хүснэгт 2: Төслийн байгаль орчны ангилал.....	14
Хүснэгт 3: Гүйцэтгэлийн стандартыг төслүүдийн үйл ажиллагаанд тохируулах нь	15
Хүснэгт 4: Байгаль орчин, нийгмийн удирдлагын үйл ажиллагаа.....	24
Хүснэгт 5: Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үйл ажиллагаа.....	31
Хүснэгт 6: Монгол Улсын хууль тогтоомж, ОУСК-ын Гүйцэтгэлийн стандартын харьцуулах нь	49
Хүснэгт 7: Монголын МСС-гийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө.....	51
Хүснэгт 8: Гол оролцогч талуудын оролцооны төрөл болон харилцах төлөвлөгөө	61

Зураг

Зураг 1: Монголын МСС-гийн БОНМС-ийн бүтэц, Эх сурвалж: ОУСК, БОНМС-ийн гарын авлага.....	8
Зураг 2: Хог хаягдлын менежментийн шатлал.....	41
Зураг 3: Монголын Мянганы Сорилтын Сангийн бүтэц.....	43
Зураг 4: Онцгой байдлын нөхцөл байдал үүсгэж болзошгүй эрсдэл болон аюулууд.....	56
Зураг 5: Талуудын оролцоог хангах үйл явц.....	60
Зураг 6: Талуудын оролцооны хүрээ, Эх сурвалж: Олон нийтийн оролцооны олон улсын холбоо.....	61
Зураг 7: Гомдол барагдуулах үе шат.....	62

Товчилсон үгс

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АЖД	Ажлын даалгавар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОЕУ	Байгаль орчны ерөнхий үнэлгээ
БОНМС	Байгаль орчин, нийгмийн менежментийн систем
БОНМТ	Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө
БОНМХ	Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ
БОННУ1	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
БОННУ2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
БОНСС	Байгаль орчин, нийгмийн суурь судалгаа
БОНУАТ	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө
БОУ	Байгаль орчны үнэлгээ
БОХАБЭАМ	Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
БХТ	Барилгын хөгжлийн төв
ГС	Гүйцэтгэлийн стандарт
ДТБУЦБ	Дэвшилтэт технологи бүхий ус цэвэршүүлэх байгууламж
ДЦС-3	3-р дулааны цахилгаан станц
ДЦС-4	4-р дулааны цахилгаан станц
ЖНТ	Жендэр, нийгмийн төлөвлөгөө
ЖҮХ	Жендэрийн үндэсний хороо
МУИС	Монгол улсын их сургууль
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
Монголын МСС	Монголын Мянганы сорилтын сан
МСК	Мянганы Сорилтын Корпорац
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НЖҮ	Нийгэм, жендэрийн үнэлгээ
НШБХ	Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ
НШНМ	Нүүлгэн шилжүүлэлт, нийгмийн мэргэжилтэн
НШТ	Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө
ОБГТ	Онцгой байдал, гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөө
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОСНААУГ	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар
ОУСК	Олон улсын санхүүгийн корпорац
СХДЗДТГ	Сонгинохайрхан дүүргийн засаг даргын тамгын газар

ТГСГЗ	Туул голын сав газрын захиргаа
ТНӨИ	Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд
ТЦБ	Төв Цэвэрлэх байгууламж
УСУГ	Ус сувгийн удирдах газар
УН	Урьдач нөхцөл
УНЗ	Усны нөөцийн зөвлөл
УТБ	Ус түгээх байр
УСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХА	Үндэсний хөгжлийн агентлаг
ХАБЭАМТ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн төлөвлөгөө
ХОСБ	Харилцан ойлголцлын санамж бичиг
ХСУХАТАҮЗЗ	Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөмж
ХУДБТ	Хаягдал ус дахин боловсруулах төсөл
ХУДЗДТГ	Хан-Уул дүүргийн засаг даргын тамгын газар
ХХ	Хүн худалдаалах
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХМТ	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
ХХМХ	Хог хаягдлын менежментийн хүрээ
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ЭкЦА	Экологийн цагдаагийн алба
ЭХЯ	Эрчим хүчний яам

Нэр томъёо

Төслийн ажиллагаа	үйл	Том үсгээр бичихдээ Компакт гэрээний гурван төслийг дурдана
АЕКОМ		Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн зураг төслийн зөвлөх
ЖЕМР		Төслийн нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулж буй дэд гэрээлэгч
ПМС		Төслийн менежментийн зөвлөх

ТАНИЛЦУУЛГА

1.1 Зорилт

АНУ-ын Мянганы сорилтын корпорац (МСК)-ын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд байгаль орчин, нийгэм, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх шаардлага тавигддаг ба тус корпорацаас батлан мөрдүүлж буй Байгаль орчны удирдамж, Олон улсын санхүүгийн корпорацын Гүйцэтгэлийн стандартад заасны дагуу “Байгаль орчин, нийгмийн менежментийн систем”-ийг төсөл хэрэгжүүлэх бүхий л үе шатанд нэвтрүүлэх үүргийг хүлээсэн байдаг.

Энэхүү баримт бичигт (хавсралтын хамт) нь Компакт гэрээний төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг удирдах зорилго бүхий Монголын Мянганы Сорилтын Сан (Монголын МСС)-гийн Байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС) юм. БОНМС буюу удирдлагын тогтолцоог Монгол Улсад мөрдөгдөж буй Байгаль орчны болон нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомжууд, МСК-ын Байгаль орчны удирдамж, ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт (2012 оны баримт бичиг), МСК-ын Жендэрийн бодлого, удирдамж болон Хүн худалдаалахтай тэмцэх бодлого, Бэлгийн дарамттай холбоотой зөвлөмж, Нийгэм, жендерийн төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулсан ба Монголын МСС-гийн зүгээс дараах зүйлийг баримталж ажиллана. Үүнд:

- (i) Бүх төсөл /тэдгээрийн үйл ажиллагаа/ дэд төслийг МСК-ын Байгаль орчны удирдамжид заасны дагуу дараах зарчмыг зөрчиж буйг нягтлах.
 - а) МСК нь Байгаль орчин, хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд ихээхэн хэмжээний хохирол учруулж болзошгүй төслүүдийг санхүүжүүлэхийг хориглодог ба энэ зарчимтай нийцэж буй эсэх (“МСК-ын категорийн хориг¹”);
 - б) Байгаль орчин, нийгэмд нөлөөлөхүйц төслүүд /тэдгээрийн үйл ажиллагаа/ нь МСК-ын Байгаль орчны удирдамж, жендэрийн бодлого, ОУСК-ын Гүйцэтгэлийн стандартад нийцэж буй эсэхийг хянах, үнэлэх;
- (ii) Бүх төсөл /тэдгээрийн үйл ажиллагаа/ дэд төслүүдийг байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал, албадан нүүлгэн шилжүүлэлт, газар эзэмших эрх, жендэрийн тэгш байдал, нутгийн уугуул иргэд, соёлын биет нөөцийн талаарх Монгол Улсын болон орон нутгийн хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг зөрчиж байгаа эсэхийг нягталж үзэх.

1 МСК-ын Санхүүжилтийн хориг нь дараах төслүүдэд хамаатай:

- (а) төслөөс үүдэн гарах сөрөг нөлөөллийг багасгах арга замыг зөв зохистой хэрэглэж байгаа ч хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулах бодис, нөхцөл байдал бий болсон, болох магадлалтай тохиолдолд;
- (б) төсөл нь дараах зүйлийг үйлдвэрлэх, худалдан авах эсвэл зориудаар тараах үйл ажиллагаатай холбоотой бол:
 - АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлаг (USEPA) дэлхийн нийтийг хамгийн их санаа зовоож буй гэж тодорхойлсон байнгын органик бохирдуулагч бодис (POP);
 - АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлаг нь урьдчилан мэдэгэх зөвшөөрөл (PIC) хөтөлбөрийн хүрээнд "хориглосон" эсвэл "хатуу хязгаарласан" гэж жагсаасан аливаа төрлийн пестицид, үйлдвэрлэлийн болон хэрэглээний химийн бодис;
 - хүрээлэн буй орчинд хортой нөлөө нь хүний эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байгаа АНУ-д хориглосон эсвэл хуулиар хатуу зохицуулдаг бүтээгдэхүүн (ялгаруулалт, байгальд хаягддаг хаягдал усыг оруулаад); эсвэл
- (с) уг төслийг байгаль орчныг цацраг идэвхт бодисоос хамгаалах зорилгоор АНУ-ын Холбооны хуулиар хориглосон буюу хатуу зохицуулдаг, хэрэв МСК нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг харгалзан байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой аюул учруулахгүй тухай эцсийн шийдвэр гаргаагүй бол.

БОНМС нь Компакт гэрээний хүрээнд хэрэгжих төслүүд, үйл ажиллагааны зураг төслийг боловсруулах, хэрэгжүүлэхэд байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй аливаа эрсдэл, нөлөөллөөс зайлсхийх, багасгах ба/буюу бууруулах арга хэмжээг тодорхойлоход тусална. Энэхүү баримт бичиг нь төсөл, үйл ажиллагаа, дэд төслүүдийг боловсруулах шатанд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн талаарх баримт бичгийг боловсруулахад дагаж мөрдөх гарын авлага болно. Тухайлбал,

төслийн байгаль орчин, нийгмийн баримт бичигт сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар нарийвчилсан мэдээлэл бүхий Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) боловсруулах, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах талаар тодорхой тусгаж өгсөн. Монголын МСС-

ийн ажилтан, алба хаагчид, гэрээт зөвлөх, гүйцэтгэгчид, төслийн шууд нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, эмэгтэйчүүд зэрэг бүх оролцогч талуудыг энэхүү БОНМС-ийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд харуулан ажиллах тасралтгүй үргэлжлэх процесс юм.


Бизнесийн менежментэд ашигладаг ТӨЛӨВЛӨХ-ХЭРЭГЖҮҮЛЭХ-ХЯНАХ-САЙЖРУУЛАХ гэсэн 4 үйл ажиллагааны хүрээний аргачлалыг энэхүү БОНМС-д мөн тусгаж байгаль орчин, нийгмийн эрсдэл², нөлөөллийг бууруулах³ үзүүлэлтийг тасралтгүй байнга сайжруулж байх нөхцөлийг бүрдүүлэн ажилладаг⁴.

Зураг 1-т Монголын МСС-гийн Байгаль орчин, нийгмийн менежментийн системийн бүтцийг харуулав.

² ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт (ГС) 1 нь "байгаль орчин ба нийгмийн эрсдэлийг" тодорхой аюул тохиолдох магадлал ба тухайн үзэгдлийн үр дагаврын ноцтой зэрэг гэж тодорхойлдог.

³ ГС 1 нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийг (i) физик, байгалийн, соёлын орчин, (ii) бизнесийн үйл ажиллагааны үр дүнд орон нутгийн иргэд, ажилчдад үзүүлэх аливаа өөрчлөлт, боломжит буюу бодит нөлөөлөл гэж тодорхойлдог. МСК-ын зааварчилгаанд нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээллийг оруулсан байдаг.

⁴ ГС 1 нь төслийг хэрэгжүүлэхэд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн удирдлага буюу менежментийн ач холбогдлыг бий болгодог.



Зураг 1: Монголын МСС-гийн БОНМС-ийн бүтэц, Эх сурвалж: ОУСК, БОНМС-ийн гарын авлага

1.2 Компакт гэрээ болон хөтөлбөрийн тухай

Монгол Улсын Мянганы сорилтын анхны Компакт гэрээ 2013 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр дуусгавар болсон. Талууд уг Компакт гэрээнд 2007 оны 10 дугаар сарын 22-ны өдөр гарын үсэг зурж, Компакт гэрээ 2008 оны 9 дүгээр сарын 17-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон бөгөөд хөрөнгийн эрх, эрүүл мэнд, мэргэжлийн боловсрол, эрчим хүч, байгаль орчин, зам тээврийн салбарт хэрэгжсэн. МСК нь 2015 оны санхүүгийн жилийн Үнэлгээний карт дахь Монгол Улсын үзүүлэлтүүдийг харгалзан, 2014 оны 12 дугаар сард Монгол Улсыг хоёр дахь удаагаа Компакт гэрээ боловсруулах боломжтой орноор шалгаруулсан. Улмаар Засгийн газраас Үндэсний зохицуулагч томилж, МСК-тай байгуулах хоёр дахь Компакт гэрээг боловсруулах үүрэг бүхий Үндэсний ажлын алба (“Үндэсний ажлын алба” гэх)-ыг Гадаад харилцааны яамны дэргэд байгуулсан болно. Үндэсний ажлын алба нь МСК-тай хамтран Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийн судалгааг гүйцэтгэсэн бөгөөд “ус хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний өртөг өндөр” байгаа нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хамгийн ихээр хязгаарлаж буй хүчин зүйлсийн нэг хэмээн тогтоосон. Монгол Улсын нийт хүн амын тал хувь нь нийслэл Улаанбаатар хотод оршин суудаг бөгөөд улсын хэмжээнд бүртгэлтэй нийт аж ахуй нэгжийн дөрөвний гурав нь нийслэлд үйл ажиллагаа явуулж, Монгол Улсын эдийн засгийн гуравны хоёрыг дангаараа бүрдүүлдэг. Улаанбаатар хот сүүлийн хорь гаруй жилийн турш хурдтай тэлсний улмаас ойрын ирээдүйд буюу 2021 он гэхэд ундны ахуйн усны хомстолд орохоор байгаа бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлтийг сааруулж, оршин суугчдын амьдралын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй юм. МСК болон Үндэсний ажлын алба хамтран 2016-2018 онуудад нарийвчилсан судалгаа хийсний дүнд газрын доорх усны баруун шинэ эх үүсвэр байгуулах, хаягдал усыг дахин боловсруулж, ашиглах, усны салбарын урт хугацааны тогтвортой байдлыг хангах гэсэн чиглэлээр хөрөнгө оруулахаар тогтсон. Хөрөнгө оруулалтын

эдгээр чиглэл нь усны салбарын засаглалыг илүү төвлөрсөн, үр ашигтай хэлбэрт оруулах Засгийн газрын байр суурьтай нийцэж байгаа болно.

1.3 Төслийн тухай

Ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд төслийн зорилтыг биелүүлэхэд чиглэсэн стратегийн ач холбогдол бүхий дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд: (i) Газрын доорх усны баруун эх үүсвэр буюу Улаанбаатар хотын баруун доод хэсэг (Биокомбинат, Шувуун фабрик орчим)-т орших эх үүсвэрийг шинээр байгуулах; (ii) Хаягдал ус дахин боловсруулах; (iii) Усны салбарын тогтвортой байдлыг хангах гэсэн үйл ажиллагаа багтана.

(i) Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа

Улаанбаатар хотын баруун доод хэсэгт орших Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн шинэ эх үүсвэр байгуулна. МСК-ын санхүүжилтийг дараах ажлыг гүйцэтгэхэд зарцуулна. Үүнд: (i) хоёр шинэ эх үүсвэрт нийт 30 гүний худаг байгуулах, (ii) шахуурга, эх үүсвэр дотор ус цуглуулах шугам хоолой, тохируулгын усан сан болон усыг эх үүсвэрийн талбайгаас дамжуулах шугам хоолойг суурилуулах, (iii) усны бохирдлыг (газрын доорх усанд агуулагдаж болзошгүй патоген эмгэг үүсгэгч, дэгдэмхий органик нэгдэл, хүнд металл, бусад бохирдуулагч бодисыг олон шатлалаар цэвэршүүлэх) гүн цэвэршүүлэх дэвшилтэт технологи бүхий байгууламжийг Улаанбаатар хотын баруун доод хэсэгт байгуулах, (iv) нөөцийн сан, шахуургын станц, усыг гүн цэвэршүүлэх байгууламжаас Улаанбаатар хотын одоогийн ус хангамжийн төвлөрсөн шугам сүлжээнд дамжуулахад шаардлагатай шугам хоолойг татах зэрэг багтана.

(ii) Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагаа.

Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагааны хүрээнд Төв цэвэрлэх байгууламж (ТЦБ)-аас гарах их хэмжээний цэвэрлэсэн хаягдал усыг дахин боловсруулж, ашиглана. Энэхүү үйл ажиллагаанд зориулсан МСК-ын санхүүжилтийг дараах ажлыг гүйцэтгэхэд зарцуулна. Үүнд: (i) ТЦБ-аас гарах цэвэршүүлсэн бохир усны тодорхой хэсгийг дахин боловсруулах үйлдвэрийг ТЦБ-ийн хажууд байрлах нийтийн эзэмшлийн талбайд байгуулах, (ii) дахин боловсруулсан усыг гурав болон дөрөвдүгээр Дулааны цахилгаан станц (ДЦС) (тус тус “ДЦС-3,” “ДЦС-4” гэх)-ын дэргэдэх усны нөөцийн сав руу дамжуулах шугам хоолой, шахуургын станц байгуулах, (iii) ДЦС-3 болон ДЦС-4-ийн зарим үйл ажиллагаанд дахин боловсруулсан усыг ашиглахад шаардлагатай хяналтын систем, дотоод шугам хоолой, нөөцийн савыг байгуулах барилга угсралтын ажил багтана.

(iii) Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа.

Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа нь бодлого, зохицуулалт, хууль эрх зүйн орчин, институтын асуудлыг хамарсан таван дэд үйл ажиллагаанаас бүрдэх бөгөөд Улаанбаатар хотын ус хангамжийн урт хугацааны тогтвортой байдлыг сайжруулахад чиглэгдэнэ.

(А) ***“Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаа”***-ны хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд техникийн туслалцаа үзүүлэх бөгөөд ингэхдээ ус хангамжийн сайжруулсан үйлчилгээнд УСУГ-ын хэрэглэгчдийн төлөх төлбөрийн чадвар, төлбөр төлөх эрмэлзлийг нарийвчлан үнэлж, уг үнэлгээнд тулгуурлан цэвэр, бохир усны тарифын бүтцийг нарийвчлан судална. Түүнчлэн, энэхүү дэд үйл ажиллагааны хүрээнд үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, элэгдэл хорогдлын зардлыг бүрэн нөхөх чадварыг бий болгох тарифын хувилбаруудыг хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулахад УСУГ-т туслалцаа үзүүлнэ.

(Б) ***“Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагаа”***-ны хүрээнд Улаанбаатар хотын гэр хороололд ус түгээх байраар дамжуулан ус хангамжийн үйлчилгээг хүргэхэд УСУГ-аас зарцуулж буй өндөр зардлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэ дэд үйл ажиллагааны хүрээнд ус хангамжийн үйлчилгээг хүргэх, борлуулахтай холбоотой гардаг шууд зардлыг

бууруулах зорилго бүхий, цар хүрээний хувьд харьцангуй бага ажлуудыг гүйцэтгэнэ. Энэхүү дэд үйл ажиллагааны хүрээнд Ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулж, цагийг уртасгах үүднээс энгийн ус түгээх байрыг «ухаалаг» буюу автомат ажиллагаанд шилжүүлэх, зөөврийн ус хангамж бүхий ус түгээх байруудыг байнгын/төвлөрсөн ус хангамжийн сүлжээнд холбох зорилгоор ус хангамжийн шугам сүлжээг өргөтгөх, УСУГ-ын зөөврийн ус хангамжийн машины ус түгээхэд зарцуулдаг хугацаа, туулдаг зайг багасгах зорилгоор ачилтын худаг нэмж барих зэрэг ажлууд багтана. Түүнчлэн, нийслэлийн хэмжээнд ус хангамжийн дэд бүтцийг өргөжүүлж, хөгжүүлэх асуудлаар УСУГ болон нийслэл, дүүргийн харьяа байгууллагууд хоорондын мэдээлэл солилцоо, төлөвлөлт, уялдаа холбоог сайжруулахад туслалцаа үзүүлнэ.

(В) **“Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих дэд үйл ажиллагаа”** нь ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, харьцуулалт хийхэд зориулж Олон улсын усны нийгэмлэгээс боловсруулсан олон улсын “AquaRating” үнэлгээний аргачлалыг ашиглан УСУГ-ын үйл ажиллагааны чадавхыг тодорхой чиглэлүүдээр сайжруулах зорилготой. Энэ хүрээнд, УСУГ-ыг үйл ажиллагааны хувьд ижил төстэй, нийтлэг бэрхшээл бүхий, хөгжингүй орны, өндөр туршлагатай ус ашиглалтын байгууллагатай иж бүрэн түншлэлийн харилцаа тогтооход шаардлагатай санхүүгийн туслалцааг үзүүлнэ. Түүнчлэн, УСУГ-ын хөрөнгийн удирдлагын чадавхыг бэхжүүлэхийн зэрэгцээ (тухайлбал, төлөвлөх, захиран зарцуулах, ашиглалттай холбоотой засвар үйлчилгээг гүйцэтгэх зэрэг) хэрэглэгчдийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх, үр дүнг оновчтойгоор ашиглах чадварыг сайжруулахад чиглэсэн тодорхой тусламжийг үзүүлнэ.

(Г) **“Үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх, бохирдлыг хянах дэд үйл ажиллагаа”** нь шинэ төв цэвэрлэх байгууламж баригдаж, ашиглалтад орохоос урьтаж нийслэлийн хаягдал ус татан зайлуулах систем дэх үйлдвэрийн бохирдлын түвшинг бууруулах хүчин чармайлтыг дэмжих зорилготой. Энэхүү дэд үйл ажиллагаанд үйлдвэрийн хаягдал усны эх үүсвэрийг тодорхойлох, түүнд шаардлагатай загварчлалыг боловсруулах, хаягдал усны стандартыг сайжруулах, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, бохирдлыг хянах дүрэм журмыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээ багтана. Түүнчлэн, Улаанбаатар хотын хэмжээнд усны бохирдолд хяналт тавих, илрүүлэх, ус бохирдуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Засгийн газрын болон нийслэлийн харьяа байгууллагуудад техникийн туслалцаа үзүүлж, лабораторийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангана.

(Д) **“Олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх дэд үйл ажиллагаа”**-ны хүрээнд Улаанбаатар хотод нүүрлэж буй усны нөөцийн хомсдолын талаар болон байгаль орчинд ээлтэй, нийгмийн эрх ашигт нийцсэн байдлаар ус олборлох, ашиглахтай холбоотой бодит өртгийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах зорилгоор холбогдох талууд, олон нийтийн харилцаа, хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

1.4 “Байгаль орчин, нийгмийн менежментийн систем” баримт бичгийн бүтэц

Хүснэгт 1: Монголын МСС-гийн байгаль орчин, нийгмийн менежментийн системийн бүтэц

Бүлэг	Агуулга
1	Компакт гэрээ болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсөл тус бүрийн ерөнхий хураангуй
2	Монголын МСС-гийн хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагаа, төслүүдийн байгаль орчин, нийгмийн талаарх тодорхойлолт.ОУСК-ын Гүйцэтгэлийн

	стандарт, Монгол Улсын хууль тогтоомж Компактын хүрээнд хэрэгжиж буй төслүүдтэй хэрхэн холбогдож буй талаарх товч тойм
3	Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй болзошгүй эрсдэл ба нөлөөлөл, эдгээр нөлөөллийг төлөвлөлтийн бүхий л шатанд хэрхэн бууруулах талаарх удирдамж
4	Болзошгүй эрсдэл, нөлөөллүүд болон гүйцэтгэгчид тавигддаг стандарт шаардлагуудыг тодорхойлох байгаль орчин, нийгмийн менежментийн дүрэм журам
5	БОНМС-ийг хэрэгжүүлэхэд оролцож буй талууд, байгууллагын зохион байгуулалт нь хуваарилагдсан ажлуудад тохирсон, мэргэшсэн байхын тулд чадавхыг бэхжүүлэх, сургалтын арга хэмжээг тодорхойлно
6	Төслийн менежментийн үйл явцыг янз бүрийн шатанд оролцогч талуудын байгаль орчин, нийгмийн асуудлыг хянах, тайлагнах
7	Монголын МСС-гийн БОНМС-ийн хэрэгжилтийг хянах, сайжруулах үйл явц

Энэхүү баримт бичиг нь БОНМС-ийн шаардлагыг бүрэн хангахын тулд Монголын МСС, түүний гэрээлэгч, болон туслан гүйцэтгэгчдийн хэрэгжүүлэх шаардлагатай нарийвчилсан болон дэлгэрэнгүй арга хэмжээг агуулсан хэд хэдэн хавсралтуудыг багтаасан болно.

- **Хавсралт 1: Монгол Улсын хууль тогтоомж ба ОУСК-ын Гүйцэтгэлийн Стандартын харьцуулалт**
- **Хавсралт 2: Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө**
- **Хавсралт 3: Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны хүрээ** Төслийн үйл ажиллагааны нөлөөллөөс улбаатай газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт (газар, орон байраа алдсанаас шалтгаалан өөр газарт нүүх г.м.) болон эдийн засгийн хувьд алдагдалд орж (эд хөрөнгөө шууд алдах, эдийн засгийн хохирол амсах эсвэл амьжиргааны түвшин буурах г.м.) амьжиргаа нь дордож болзошгүй хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагад учрах сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, алдагдлыг нь нөхөхийг мөрдлөг болгохын хажуугаар хүрээлэн буй орчин, нийгэм, санхүүгийн зардал, үр ашгийг тэнцвэржүүлэх замаар ядуу, эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх нөлөөлөлд онцгой анхаарал хандуулах зарчмыг баримтална. Мөн төслийн талбар дахь Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулах үндсэн удирдамж болно..
- **Хавсралт 4: Онцгой байдлын үеийн бэлэн байдлын төлөвлөгөө**
Төслийг хэрэгжүүлэх үе шатанд гарч болзошгүй аюул, осол гэнэтийн нөхцөл байдлыг тодорхойлж, онцгой байдлын төлөвлөлт, бэлэн байдлын талаарх ерөнхий удирдамж өгөх зорилготой.
- **Хавсралт 5: Олдвор байх магадлалын журам**
Төслийн үйл ажиллагаатай холбоотой газар ухах үйл ажиллагааны үеэр археологийн олдвор болон бусад илэрц газарт ил гарах боломжийг тооцон, археологийн олдвор олдсон тохиолдолд дагаж мөрдөх удирдамж өгөх зорилготой.
- **Хавсралт 6: Оролцогч талуудтай харилцах, зөвлөлдөх төлөвлөгөө болон гомдол барагдуулах механизм**

Төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн бүлэг иргэд болон төслийн үйл явцыг сонирхогч бүхий л оролцогч талуудтай харилцах журам, арга зам болон талуудаас ирүүлсэн гомдол саналыг хэрхэн зохицуулах талаар тусгасан төлөвлөгөө юм.

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН БОДЛОГО БА ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ

2.1 Монголын Мянганы Сорилтын Сангийн баримталж буй бодлого

Монголын МСС-гийн Байгаль орчин, нийгмийн талаар баримтлах бодлогыг энэхүү баримт бичигт тусган боловсруулж, 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн Удирдах Зөвлөлийн хуралд танилцуулж, Гүйцэтгэх захирал гарын үсэг зуран баталсан.

Монголын МСС нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах, сайн засаглалыг бэхжүүлэх, эдийн засгийн эрх чөлөөг хангах, хүний хөгжилд хөрөнгө оруулах зорилго бүхий хоёр дахь Компакт гэрээг хэрэгжүүлэхээр болсон ба Улаанбаатар хотын газрын доорх усны шинэ нөөц, дэвшилтэт технологи бүхий ус цэвэршүүлэх байгууламж байгуулах, хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр байгуулах, усны салбарын тогтвортой байдлыг хангах замаар ус хангамжийн үйлчилгээг сайжруулах юм. Энэхүү хөтөлбөр нь орон сууцны хэрэглэгч, арилжааны болон үйлдвэрлэлийн хэрэглэгчдийн хэрэгцээг хангахын тулд чанарын шаардлага хангасан усны нөөцийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Монголын МСС нь төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны ашиг тус, байгалийн баялгийн менежмент, хамгаалалтыг нэмэгдүүлэх, ялангуяа нийгмийн эмзэг бүлэг, эмэгтэйчүүдэд онцгой анхаарал хандуулах замаар эдийн засгийн тогтвортой хөгжилд хүрэхийг зорьж байна.

Компакт гэрээний үе шат тус бүрд дээр дурдсан бодлого, зарчмыг хэрэгжүүлснээр байгаль орчин, нийгмийн урт удаан хугацааны тогтвортой байдлыг хангах системийг бий болгох ач холбогдолтой юм. Монголын МСС нь байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг бууруулах, ашиг тусыг нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн менежментийг сайжруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалахыг зорин ажиллахдаа МСК-ын Байгаль орчны удирдамж, Жендэрийн бодлого, Нүүлгэн шилжүүлэлтийн хүрээ, Олон улсын санхүүгийн корпорацын Гүйцэтгэлийн стандарт болон Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн ажиллахыг зорьж байна. Иймд Монголын МСС нь үйл ажиллагаа, төслүүдийг хэрэгжүүлэх явцад оролцогч бүхий л талууд буюу Монгол Улсын засгийн газар, Монголын МСС, зөвлөхүүд, гэрээт гүйцэтгэгчид болон төслийн үр шимийг хүртэгчдийг үйл ажиллагааг Компактын байгаль орчин нийгмийн гүйцэтгэлийн шаардлагад нийцүүлэхийн тулд энэхүү Байгаль орчны менежментийн систем (БОМС)-ийг боловсруулсан.

Компакт гэрээний хэрэгжилтийн бүх үе шатанд Байгаль орчин, нийгмийн бодлого, зарчмуудыг тууштай хэрэгжүүлэх замаар байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг хангах үр дүнтэй хөтөлбөр, практикийг бий болгохын чухлыг онцлон тэмдэглэхийн тулд Монголын МСС нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- *Байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС)-ийг бий болгох, хэрэгжилтийг хэвшүүлэх;*
- *Төсөл ба дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох, үнэлэх;*
- *Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нөлөөлөлд өртөгсдөд үзүүлж болзошгүй эрсдэл нөлөөллийг урьдчилан таамаглах, зайлсхийх, зайлсхийх боломжгүй бол багасгах, нөхөн төлбөр олгох/дүйцүүлэн хамгаалах зорилгоор нөлөөллийг бууруулах шатлалыг бий болгох;*

- Эрсдэл, нөлөөллийг арилгах, байгаль орчин, нийгмийн эерэг үр ашгийг нэмэгдүүлэх менежментийн зохих төлөвлөгөөнүүдийг боловсруулах;
- Байгалийн нөөцийг тогтвортой, үр ашигтай ашиглахыг дэмжиж, төсөл болон дэд төслийн зураг төсөлд эрчим хүч, ус хэмнэх ногоон технологийг ашиглах боломжийг нэмэгдүүлэх;
- Байгаль орчин, нийгмийн менежментийн системийг үр дүнтэй ашиглах, институцийн чадавхыг бэхжүүлэх замаар байгаль орчин, нийгмийн менежментийг сайжруулах;
- Монголын МСС-гийн төсөл, тэдгээрийн үйл ажиллагаатай холбоотой гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх механизмыг боловсруулж, төслийн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн санал гомдол, хөндлөнгийн оролцоо, бусад оролцогч талуудын харилцаа холбоог зохих ёсоор хангаж, зохицуулах;
- Төсөл хэрэгжих явцад нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд болон засаг захиргааны байгууллагууд, оролцогч талуудад төслийн үйл ажиллагаа, эерэг үр нөлөө, хүртэх ашиг тус, үр өгөөжийг танилцуулах, байгаль орчин, нийгмийн талаар баримтлах бодлогыг сурталчлах, үнэн зөв мэдээллээр хангах, иргэдийн санал бодлыг тусгах, засаг захиргааны нэгжээс зөвшөөрөл авах зорилгоор оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө боловсруулна;
- Бүх үйл ажиллагаа, оролцогчид байгаль орчин, нийгмийн эерэг нөлөөлөл, үр өгөөжийг ухамсартайгаар зураг төсөлдөө тусгах, дэмжих;
- Төслийн үйл явцын хяналт, тайлагнах зохих системийг бүрдүүлж, шаардлагатай бол залруулах арга хэмжээ авах;
- Байгаль орчин, нийгмийн бодлого, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам зарчмуудыг дагаж мөрдөх, хянах, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, нөөцийг ажилтнуудад эзэмшүүлэх зэрэг болно.

Монголын МСС-гийн төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны чиглэл нь байгаль орчин, нийгмийн бодлогод нийцэх ёстой бөгөөд Монголын МСС-гийн Гүйцэтгэх захирал бүх хариуцлагыг хүлээх үүрэгтэй. Монголын МСС-гийн байгаль орчин, нийгмийн талаар авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл нь Удирдах Зөвлөлийн тайланд тусгагдах ба энэхүү бодлого нь Монголын МСС-гийн бүх ажилтан, албан хаагч, зөвлөх, гэрээт компани, хамтран ажиллах бүхий л байгууллагуудад хамааралтай болно.

2.2 Төслийн байгаль орчны ангилал

МСК-ын хийсэн анхан шатны үнэлгээгээр Компактын хүрээнд хэрэгжих гурван төслүүдийг байгаль орчин, нийгмийн нөлөөллийн байдлаар нь ангилсныг хүснэгт 2-т харуулав. Анхан шатны үнэлгээг Компактыг боловсруулах үеийн Төслүүд болон тэдгээрийн үр нөлөөг сайтар ойлгосны үндсэн дээр байгаль орчин, нийгмийн үнэлгээний мэргэжлийн хүмүүс боловсруулсан.

МСК-ын Байгаль орчны зааварчилгааны дагуу төслүүд дараах ангилалд багтана:

- А категори: хэрэв төсөл нь эмзэг, олон талт эсвэл таамаглах боломжгүй байгаль орчин, нийгэмд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болзошгүй бол. Эдгээр нөлөөлөл нь барилга байгууламжийн бодит талбайгаас илүү өргөн талбайд нөлөөлж болзошгүй бол.
- ,
- Б категори: байгаль орчин, нийгэмд учирч болзошгүй нөлөөлөл нь А ангиллын төслүүдээс бага сөрөг нөлөө үзүүлбэл. Ерөнхийдөө эдгээр нөлөөлөл нь тухайн

төслийн талбайгаар хязгаарлагддаг, зайлшгүй нөлөөллийн хэмжээ бага бөгөөд нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд нь илүү хялбар байдаг.

- В категори: төсөл нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх мэдэгдэхүйц сөрөг нөлөө бага байвал,
- Г категори: байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөө үзүүлэхүйц дэд төслүүдийг МСК-ын санхүүжилтээр хэрэгжүүлэх түр зуурын байгууламжуудыг дээрх ангилалд тус тус хамруулж ойлгоно.

Хүснэгт 2: Компактын төслүүдийн байгаль орчны ангилал

Төсөл	МСК-ын байгаль орчны удирдамжийн дагуу
Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл	А
Хаягдал ус дахин боловсруулах төсөл	Б
Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл	В

Компакт гэрээгээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд ирээдүйд хийх аливаа өөрчлөлт, засварыг (түүний дотор томоохон нэмэлт, өргөтгөлүүдийг багтаан) МСК-ын Байгаль орчны зааварчилгаа болон дараагийн хэсэгт тайлбарласантай ижил аргаар үнэлэн шалгаж, ангилна.

2.3 Олон улсын Санхүүгийн корпорацийн Гүйцэтгэлийн стандарт

Гүйцэтгэлийн стандарт (ГС) нь хөгжлийн төслүүдийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг зохицуулах олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүрээ бөгөөд МСК-ын эрсдэлийн удирдлагын арга барил болон Байгаль орчны зааварчилгааг үйл ажиллагааны түвшинд хэрэгжүүлэхэд хамгийн чухал хэсэг юм. Гүйцэтгэлийн стандартууд нь МСК-ын Байгаль орчны удирдамжийг иж бүрдүүл болгон, компактаас санхүүжүүлсэн үйл ажиллагааны байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн шаардлагад нийцсэн стандартыг зааж өгсөн. Монголын МСС нь доор дурдсан ОУСК-ын Гүйцэтгэлийн Стандартын⁵ шаардлагад нийцэж ажиллах үүрэгтэй.

ГС-1: Байгаль орчин нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ ба удирдлага – Байгаль орчин, нийгмийн менежментийн системийг төсөл (үнэлгээ, удирдлагад хамаарах аливаа Компактын арга хэмжээ) хэрэгжих хугацааны туршид ашиглах замаар нийгэм ба байгаль орчны гүйцэтгэлийг удирдахын ач холбогдлыг цохон тэмдэглэдэг. БОНМС нь Монголын МСС-гийн ажилтнууд, зөвлөхүүд, гэрээт компаниуд, төслийн нөлөөлөлд өртсөн иргэд хоорондын оролцоо удирдлагаас бүрдсэн идэвхтэй, тасралтгүй үйл явц юм.

ГС-2: Ажиллах хүч ба ажлын байрны нөхцөл – Эдийн засгийн хөгжил нь ажилтнуудын эрхтэй тохирч байх ёстойг чухалчилдаг. Энэхүү стандарт нь ажилтнуудын менежментийн харилцааг бий болгох, хадгалах, сайжруулах, ажилтнуудад тэгш боломж олгох, хөдөлмөрийн болон хөдөлмөр эрхлэлтийн тухай тухайн улсын хууль дүрэм, журамтай нийцүүлэх, хүүхдийн хүч болон албадан хөдөлмөр эрхлэлтийг шийдвэрлэх замаар эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох зорилго тавьдаг байна.

⁵ Гүйцэтгэлийн стандарт ба удирдамжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоос авна уу. https://www.ifc.org/wps/wcm/connect/24e6bfc3-5de3-444d-be9b-226188c95454/PS_English_2012_Full-Documents.pdf?MOD=AJPERES&CVID=jkV-X6h and https://www.ifc.org/wps/wcm/connect/9fc3aaef-14c3-4489-acf1-a1c43d7f86ec/GN_English_2012_Full-Documents_updated_June-27-2019.pdf?MOD=AJPERES&CVID=mRQmrEJ

ГС-3: Нөөцийг үр ашигтай ашиглаж, бохирдлоос сэргийлэх – Бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилготой бөгөөд төслийн үйл ажиллагаанаас шууд гарч буй бохирдлоос хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж болохуйц аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх эсвэл зайлсхийх боломжгүй тохиолдолд бууруулах боломжтой юм.

ГС-4: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, - Төсөл хэрэгжих хугацаанд орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд учрах эрсдэл, нөлөөллөөс зайлсхийх, багасгах бөгөөд иргэн, эд хөрөнгийг хамгаалах нь олон нийтийн аюулгүй байдал, аюулгүй байдалд учирч болох эрсдэлээс зайлсхийх эсвэл багасгах боломжийг баталгаажуулах зорилготой.

ГС-5: Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт – Төлөвлөлтийн шатнаас эхлэн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтээс аль болох зайлсхийх, зайлшгүй тохиолдолд хамгийн бага нөлөөтэй байхаар төслийн хувилбар эсхүл дэд төслүүдийг судлах. Ингэхдээ нүүлгэн шилжүүлэх (орон байраа алдах) болон эдийн засгийн хохирол (амьжиргааны эх үүсвэрээ алдах) аль алинд нь хамаарах буюу нүүсэн болон эдийн засгийн хувьд хохирол амссан иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, сэргээх зорилготой.

ГС-6: Биологийн олон янз байдлын хамгаалал, амьд байгалийн нөөцийн тогтвортой удирдлага - Төсөл хэрэгжих хугацаанд тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, тэдгээр зүйлүүдийн байгалийн болон чухал амьдрах орчны эрсдэл, нөлөөллийг бууруулах, багасгах зорилготой.

ГС-7: Нутгийн уугуул иргэд - Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн уугуул иргэдэд үзүүлэх эрсдэл, нөлөөллийг бууруулах, багасгах зорилготой бөгөөд Компактын хүрээнд хэрэгжих төслүүдэд хамааралгүй болно.

ГС-8: Соёлын өв – эд өлгийн зүйлс, хиргисүүр, бунхан, шашны дурсгалт газар зүйлс зэрэг соёлын өвд учруулах эрсдэл, нөлөөллөөс зайлсхийх, багасгах зорилготой.

Компактын хүрээнд хэрэгжих төслүүд болон тэдгээрийн үйл ажиллагаанаас үүдэн гарах нөлөөллүүдийг хэрхэн БОНМС-ээр зохицуулах, ГС-уудыг үйл ажиллагаандаа тохируулан хэрэглэх зэргийг хүснэгт 3-аар харуулсан ба энэхүү хүснэгт нь төслүүдийн үйл ажиллагаатай холбогдон шинэчлэгдэж болох юм. Үйл ажиллагааны нарийвчилсан хүснэгт, тэдгээрийн менежментийн горимыг БОНМС-ийн 4 дүгээр бүлгээс харна уу.

Хүснэгт 3: Гүйцэтгэлийн стандартыг төслүүдийн үйл ажиллагаанд тохируулах нь

Төсөл/Үйл ажиллагаа	Холбогдох Гүйцэтгэлийн стандарт
Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл, Хаягдал ус дахин боловсруулах төсөл	Энэ үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн элементүүдийг багтаасан дараах стандартууд хамаарна. ГС-1: Төслийн талбай, барилгажилт, төлөвлөлтийн болон ашиглалтын үеийн Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөлөл ГС-2: Хил дамнуулан хүн наймаалах, ажилтнуудын ажлын байран дахь нөхцөл зэрэг ажиллах хүчинтэй холбоотой асуудлууд ГС-3: Барилгын ажилтай холбоотой аюултай хог хаягдлын менежментийг удирдах ГС-4: Барилгын болон ашиглалтад оруулах үеийн орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал ГС-5: Түр болон бүр мөсөн газар чөлөөлөх болон нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой асуудал ГС-6: Биологийн олон янз байдлыг хамгаалах, амьд байгалийн нөөцийн удирдлага ГС-8: Газар шорооны ажлын үед соёлын өвийн буюу археологийн ач холбогдол бүхий байршил, санамсаргүйгээр олдвор олох зэргийг зохицуулна

Төсөл/Үйл ажиллагаа	Холбогдох Гүйцэтгэлийн стандарт
Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл	<p>ГС-1: Энэхүү үйл ажиллагаанд институтийн шинэчлэл болон олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа багтаж байгаа ба оролцогч талуудын оролцоо маш чухал үүрэгтэй юм. Зураг төсөл болон барилгын ажил энэ төслийн үйл ажиллагаанд хамаарахгүй учраас бусад ГС төдийлөн хамааралгүй.</p> <p>ГС-2: Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагааны хүрээнд энгийн ус түгээх байрыг «ухаалаг» буюу автомат горимд шилжүүлэх замаар шууд зардлыг бууруулах олон ажлууд хийгдэх ба УСУГ нь ажилтнуудаа халахгүй байх бодлогыг тусгасан төлөвлөгөө боловсруулах үүрэг хүлээсэн. Тухайн ажилтны эрх, үүрэг, хөдөлмөрийн нөхцөлийг ГС-2-оор зохицуулна.</p>

2.4 Байгаль орчин, нийгмийн тухай Монголын Улсын хууль тогтоомж

Энэ бүлэгт Компактын хүрээнд төслийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх байгаль орчны болон нийгмийн тухай холбогдох үндсэн хууль тогтоомж, түүнчлэн стандарт, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын талаар тоймлосон.

Байгаль хамгаалах тухай хууль (1995, 2012) - Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. Уг хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчны унаган төрхийг хадгалах, түүний тэнцэл алдагдахаас сэргийлэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, байгалийн баялгийн ашиглалтыг зохицуулах зорилгоор байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тус тус хийх шаардлагатай юм. Мөн тодорхой шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны үнэлгээ хийх эрх олгоно хэмээн нарийн заасан байдаг. Түүнчлэн 10 дугаар зүйлд хүрээлэн буй орчны төлөв байдал, түүний өөрчлөлтийн талаарх байгаль орчны хяналт шинжилгээг хийх талаар тусгасан болно.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль (2012) - Энэхүү хууль нь шинээр хэрэгжүүлэх гэж буй төслүүд болон хэрэгжиж буй төслүүдийг өргөтгөхтэй холбоотойгоор Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх үйл явцыг нарийвчлан тодорхойлдог. Нөлөөллийн үнэлгээ нь Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ болон Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнээс бүрдэх ба төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын үнэлгээний тайлан, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (БОАЖЯ), эсхүл байгаль орчны албанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.

Аливаа шинээр байгуулах болон одоо ажиллаж байгаа үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг үнэлгээний шинжээч, дараах 3 төрлийн дүгнэлт гарах боломжтой:

- Төслийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэлгүйгээр тодорхой нөхцөл, болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх;
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэх.

Төслийг (i) хууль тогтоомжид нийцээгүй; (ii) байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө ихтэй; эсвэл (iii) мэдээлэл хангалтгүйтэйгээс төслийг хэрэгжүүлэхээс татгалзах, эсхүл буцаах.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх А-117 аргачлалын дагуу нийгмийн асуудлуудыг тодорхойлдог. Мөн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журмын дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангахтай холбогдсон харилцааг зохицуулах ба мэдээллийг түгээж, ил тод хүртээмжтэй байлгах, төслийн нөлөөлөлд шууд ба шууд бус хэлбэрээр өртсөн болон өртөж болзошгүй тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, орон нутгийн болон холбогдох бусад байгууллагын төлөөлөл багтсан өргөн хүрээтэй ойлголтыг хэлнэ. Мөн мэдээлэл солилцох, зөвлөлдөх, зөвшилцөх боломжийг хангах зорилготой юм.

Энэ хуулийн 9.9-д (9.10-т заасан *Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрээс бусад*) төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа **50-иас** доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх **байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд** төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.

Усны тухай хууль (2012) нь усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилготой гол хууль юм. Бохирдуулагч нь төлөх зарчим болон байгаль орчны аудитын тухай нэмэлт өөрчлөлтийг уг хуулийн 2012 оны нэмэлт өөрчлөлтөд оруулж өгсөн ба гол зарчим нь бохирдуулж буй бүхий л иргэн, аж ахуйн нэгж нь бохирдлын зэргээс хамаарч төлбөр төлөх зарчим юм. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд ус бохирдуулсны төлбөртэй холбоотой авч хэрэгжүүлэх үйл явц, хувь хэмжээг нарийвчлан тусгаагүй байдаг тул Усны тухай болон Ус бохирдуулсны төлбөрийн тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хуульд тус тус ус хэрэглэсний төлбөрийн тухай зохицуулалт орсон байдаг.

Газрын тухай хууль (1994, 2015) нь газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино. Уг хуулийн 42 болон 43 дугаар зүйлд эзэмшсэн газраа нүүлгэх, чөлөөлөхтэй холбоотой нөхөн олговор олгох талаар тодорхой дурдсан байдаг.

Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997) нь тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийг тогтоох, орчны бүсэд үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой. 9 дүгээр зүйлд орчны бүсэд усан сан байгуулах, далан, хаалт барих зэрэг үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллага нь зохих хууль тогтоомжийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэхийг шаарддаг.

Эрүүл ахуйн тухай хууль (1998, 2016) нь хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Галын аюулгүй байдлын тухай (1999, 2015) нь галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2001, 2014) нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах, өвлүүлэх, өмчлөх, эзэмших, ашиглах, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Гамшгаас хамгаалах тухай хууль (2003, 2012) нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон төр, орон нутгийн удирдлага, аж ахуйн нэгж, хуулийн этгээд, иргэдийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Химийн хорт болон аюултай бодисын тухай (2006) нь химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008, 2012) нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх төрийн бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, төрийн байгууллагын удирдлага, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хөдөлмөрийн тухай хууль (1999, 2008) нь хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж, талуудын харилцан эрх тэгш байдлыг хангах зорилготой.

Газрын төлбөрийн тухай хууль (2012) нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн өмчийн газрыг эзэмшиж, ашигласны төлөө төлбөр ногдуулах, уг төлбөрийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хог хаягдлын тухай хууль (2012) нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ЭРСДЭЛ НӨЛӨӨЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ

Монголын МСС-гийн хэрэгжүүлж буй бүхий л төслүүд, тэдгээрийн үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгэмд эрсдэл нөлөөлөл үзүүлэх боломжтой. МСК нь санал болгосон төсөл дээр дүн шинжилгээ хийж Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл болон Хаягдал ус дахин боловсруулах төслийн байгаль орчин, нийгмийн суурь судалгааг боловсруулах шийдвэр гаргасан. Энэ бүлэгт төсөл тус бүрийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлж, ангилах, Монголын МСС-гийн гүйцэтгэж буй үнэлгээний явцын талаар тайлбарласан болно⁶.

⁶ Төсөл, дэд төсөл тус бүрийн байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй эсвэл тодорхойлогдсон эрсдэл, нөлөөллийн талаар зөвлөхүүдийн боловсруулсан БОННУ, БОНМТ, ХХМТ болон бусад төслийн баримт бичгээс үзэх боломжтой.

3.1 Төслийн боломжит нөлөөлөл

3.1.1 Хүлээгдэж буй эерэг нөлөөлөл

Төслүүдийн байгаль орчин, нийгэмд олон янзын нөлөөлөл үзүүлэх бөгөөд эдгээрээс эерэг нөлөөллүүдийг дор нэгтгэсэн болно. Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаанаас гарах үр өгөөж:

- Монгол Улсад анх удаа баригдах Дэвшилтэт технологи бүхий ус цэвэршүүлэх байгууламж (ДТБУЦБ) нь чанарын өндөр түвшинд усыг цэвэршүүлэн Улаанбаатар хотын нийт ард иргэдийн амьдралын чанарыг тэтгэх ундны усаар хангах юм. Ус хангамжийг сайжруулах нь нийт иргэдийн амьдрал аж ахуй, эдийн засагт эерэг үр нөлөө авчрах ба шинээр баригдах худгуудаас жилдээ 50 сая хүртэлх шоо метр усыг ДТБУЦБ-д цэвэршүүлэн ард иргэдийн хэрэгцээнд нийлүүлнэ.
- Эдийн засгийн өсөлтийг хязгаарлах хүчин зүйл болж буй усны хязгаарлагдмал нөөц, Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй усны хэрэгцээг хангахад уг төсөл нь маш чухал үүрэг гүйцэтгэх юм.
- Биокомбинат болон Шувууны талбай дээрх худгуудаас газрын доорх ус олборлоход Туул голын урсац болон уст давхаргад ямар нэг нөлөөлөл үзүүлэхгүй гэсэн тооцоолол бий. Компактаас санхүүжүүлж буй төслүүдийн барилгын шатанд МСС-ийн гэрээт гүйцэтгэгчдийн нийт ажилчдын хамгийн багадаа 30% эмэгтэйчүүд байх зорилтыг биелүүлэхийг дэмждэг. Цаашлаад орон нутгийн иргэдийн санхүүгийн боломж, орон нутгийн бизнесийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг бий болгоно.
-

Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагааны үр ашиг:

- Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр баригдсанаар Туул голын газрын доорх усны нөөцийг тодорхой хэмжээгээр нөөцлөн авч үлдэн цаашлаад Улаанбаатар хотын нийт ус хангамжийн нэмэгдүүлэх боломж бүрдэх юм. Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр нь шинээр баригдах Төв Цэвэрлэх Байгууламж (ТЦБ)-аас хоногт 50.000 шоо метр хаягдал ус хүлээн авч боловсруулан 3 болон 4-р дулааны цахилгаан станцуудад техникийн ус болгон ашиглах болно. Одоогийн байдлаар дулааны цахилгаан станцууд нь газрын доорх усыг шууд олборлон хөргөлтийн зориулалтаар ашигладаг. .
- Шинэ ТЦБ нь байгальд шууд нийлүүлэгдэж буй хаягдал усны стандарт (MNS4943:2015)-д нийцсэн хаягдал усыг Туул голд нийлүүлснээр ирээдүйд Туул голын бохирдол багасах боломжтой юм.
- Монгол Улсад өнөөгийн байдлаар дахин ашиглах цэвэрлэгдсэн усны MNS6734:2018 стандартаас өөр хаягдал усыг дахин ашиглах хууль эрхзүйн орчин бүрэлдээгүй байна. Хэрэглэсэн усаа дахин боловсруулж ашиглах ойлголт нь нийт ард иргэдийн дунд түгээмэл биш учир шинээр хууль эрхзүйг боловсруулах нөхцөл бий болох юм.
- Төслийн талаар мэдээлэх, сурталчлах стратегийн ач холбогдол бүхий олон нийтийн оролцоотой кампанит ажил зохион байгуулснаар хаягдал ус дахин боловсруулах, хэрэглэх талаар ойлголтыг нэмэгдүүлж, ирээдүйд энэ салбарын төслүүдийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой юм.
- Хаягдал усны салбарын хөрөнгө оруулалт, боловсруулах үйлдвэр нь ирээдүйд урт болон богино хугацааны ажлын байрыг нэмэгдүүлэх давуу талтай.
- Шинэ технологи нэвтрүүлснээр бий болох ажлын байрны төрлүүд болон тухайн технологийг ашиглахтай холбоотойгоор сургалтад хамрагдах шаардлагатай

хүмүүсийн талаар УСУГ-ын тодорхойлсон. Энэхүү баримт бичиг нь УСУГ-т хамааралгүй болон УСУГ-ын өнөөгийн эмэгтэй ажилчдын орон тоог ялангуяа техникийн болон удирдах түвшний албан тушаалд ажиллуулах боломжийг илэрхийлдэг.

Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн үр ашиг:

- “Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагаа”- ны хувьд эдийн засгийн болон эдийн засгийн бус өгөөжтэй байх ба ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулж, цагийг уртасгах үүднээс энгийн ус түгээх байрыг «ухаалаг» буюу автомат горимд шилжүүлэх, зөөврийн ус хангамж бүхий ус түгээх байруудыг байнгын/төвлөрсөн ус хангамжийн сүлжээнд холбох зорилгоор ус хангамжийн шугам сүлжээг өргөтгөх, УСУГ-ын зөөврийн ус хангамжийн машины ус түгээхэд зарцуулдаг хугацаа, туулдаг зайг багасгах зорилгоор ачилтын худаг нэмж барих зэрэг ажлууд багтана. Ухаалаг системийн тусламжтайгаар ажлын ачаалал буурч операторууд зөвхөн ус түгээх байр (УТБ)-ыг цэвэрлэх, арчлах ажлыг хариуцах бөгөөд нэг оператор хэд хэдэн УТБ-ыг хариуцах боломжтой болно. Дүүргэлтийн худгийг ухаалаг худгуудад найдвартай ус дамжуулахаар тооцсон тул ус тасрах эрсдэл бага байх болно. Ухаалаг худаг нь 24/7 хугацаагаар үйл ажиллагаагаа явуулснаар хэрэглэгчид ажлын бус цагаар усаа авах боломжийг бүрдүүлдэг бөгөөд энгийн шугамын ус түгээх худаг ашигладаг хэрэглэгчдийн усны хэрэглээг хоногт 1 литрээр нэмэгдүүлэх боломж олгох юм.

3.1.2 Болзошгүй эрсдэл ба сөрөг нөлөөлөл

Төслийн барилгын болон хэрэгжүүлэлтийн шатанд гарч болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, сөрөг нөлөөллийг доор нэгтгэсэн ба ихэнх нөлөөлөл нь төслийн талбайгаар хязгаарлагдсан, богино хугацааны байх төлөвтэй байна. Үүсэж болзошгүй сөрөг нөлөөллүүдийн ихэнх нь төслийн барилгажилтын шатанд үүсэх магадлалтай байдаг бөгөөд төсөл хэрэгжиж буй бодит талбайд ажил хэрэгжих үед үүсдэг. Эдгээр эрсдэл, сөрөг нөлөөллийг Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, менежментийн төлөвлөгөө, Хог хаягдлын менежментийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн төлөвлөгөөнд илүү нарийн тусгах болно.

Дараах эрсдэл, нөлөөллүүд нь Компакт гэрээний төслийн хүрээнд хийгдэх бүхий л үйл ажиллагаанд хамаарна.

3.1.3 Зураг төслийн үе шатны нөлөөлөл

Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг (1) ерөнхий; (2) байгаль орчны; (3) нийгмийн гэсэн ангиллаар тодорхойлсон болно.

Ерөнхий эрсдэл:

- Барилга угсралтын ажлыг төлөвлөх зураг төслийн үе шатанд байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хангалтгүй тооцоолж, ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт, МСК-ын Байгаль орчны зааварчилгаа, дотоодын хууль тогтоомжийн үл нийцэл;
- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах бэлтгэл ажил хангалтгүй, холбогдох удирдамж, хууль тогтоомжийн үл нийцэл;
- Байгаль орчин, нийгмийн нөлөөлөлд хяналт тавих бэлтгэл хангалтгүй, холбогдох удирдамж, хууль тогтоомжийн үл нийцэл;
- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэмжээнүүдийн талаар дэд төслийн зураг төслийн зөвлөхүүдийн мэдлэг дутмаг байх зэрэг.

Байгаль орчны эрсдэл:

- Ландшафтын доройтол, хөрсний элэгдлийн нөлөөллийг зохих ёсоор тооцохгүй байх;
- Газар шорооны ажлаас үүссэн ухлага болон барилгын хог хаягдлыг зайлуулах арга хэмжээг тооцохдоо агаар, ус, хөрсний бохирдол, ландшафтын доройтол зэргийг хангалтгүй тооцоолох;
- Аюултай хог хаягдлыг зайлуулах арга хэмжээнд бохирдлыг хангалтгүй тооцох.

Нийгмийн эрсдэл:

- Төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүс болон төслийн талбайд амьдардаг иргэдтэй зөвлөлдөх буюу оролцогч талуудын оролцоо хангалтгүй байх;
- Төслийг хэрэгжүүлэх зорилгоор хувийн болон нийтийн эзэмшлийн газар, өмчийг түр хугацаагаар эсвэл байнгын зориулалтаар ашиглах болон нүүлгэн шилжүүлэлтийн бусад нөлөөллийг зохих ёсоор авч үзэхгүй байх;
- Ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулж, цагийг уртасгах үүднээс энгийн ус түгээх байрыг «ухаалаг» буюу автомат горимд шилжүүлснээр тодорхой тооны операторууд, ихэнхдээ эмэгтэй ажилчид ажлын байраа алдах эрсдэлтэй;
- УСУГ-ын ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг нөхөх үүднээс усны үнийг нэмснээр хамгийн эмзэг, ядуу өрхүүдийн ундны болон ариун цэврийн зориулалттай өдөр тутмын усны хэрэглээ буурах.

3.1.4 Барилгын ажлын үеийн нөлөөлөл

Барилгын ажлын үеэр гарч болзошгүй байгаль орчин, нийгмийн нөлөөлөл нь:

- Барилгын ажилтай холбоотойгоор ландшафтын доройтол, хөрсний элэгдэл үүсэх
- Хөрсний бохирдол
- Гадаргын болон газрын доорх усны бохирдол
- Туул голын доогуур сүвэлгээ хийх ажилтай холбоотойгоор гадаргын усанд бохирдуулагч бодис асгарах шууд нөлөөлөл
- Биологийн олон янз байдалд нөлөөлөх нөлөөлөл
- Барилгын ажилд ашиглагдаж буй бульдозер зэрэг техникээс гарах дуу чимээ, чичиргээ
- Агаарын бохирдол, газар шорооны ажлаас үүдэх тоос, тээврийн хэрэгслээс хортой бодис ялгаруулах
- Барилгын болон аюултай хог хаягдал бий болох
- Барилгын ажил, замын хөдөлгөөний үед нүүрлэж болзошгүй аюул осол
- Түүх соёл, археологийн дурсгалт зүйлд үзүүлэх нөлөө
- Туул голын доогуур сүвэлгээ хийх ажилтай холбоотойгоор голын голдиролд тур буюу бүр өөрчлөлт орох
- Нүүлгэн шилжүүлэх (орон байраа алдах) болон аж ахуйн үйл ажиллагааны саатал (амьжиргааны эх үүсвэрээ алдах)-аас үүдэн бий болж болзошгүй нөлөөлөл
- Бэлгийн замаар дамжих өвчний тархалттай холбоотой хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл
- Орон нутгийн бизнес эрхлэхэд бүртгэлгүй эсвэл түр оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэхэд дахин амьжиргаагаа сэргээхэд сөрөг нөлөө үзүүлдэг. Цаашилбал, нүүлгэн шилжүүлсэн бизнес нь одоо байгаа үйлчлүүлэгчдээ алдаж, бизнесээ дахин эхлүүлэхтэй холбоотой нэмэлт зардал гарах магадлалтай
- Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн аль алинд нь барилгын төслийн талбайн эргэн тойронд байгаа бэлчээр нутгийг ашигладаг малчид цөөнгүй байдаг. Барилга угсралтын үйл ажиллагаа нь малчдын амьдрал, санхүүгийн орлогод шууд нөлөөлж, нүүдэлчин ахуй соёлын өвийг устахад нөлөөлж болзошгүй юм.
- Сонгинохайрхан уулыг орон нутгийн иргэд шашны ач холбогдолтой ариун газар гэж үздэг. Дэвшилтэт технологи бүхий ус цэвэршүүлэх байгууламж, ус дамжуулах хоолой

барих үед орон нутгийн иргэдийн уул руу гардаг замыг хязгаарлаж, уулыг тахидаг зан үйлд саад болох эрсдэл үүсэж болзошгүй юм.

3.1.5 Хуримтлагдах нөлөөлөл

Ус, хөрс, агаарын чанарын нөөц, түүнчлэн барилгын үйл ажиллагааны өөрчлөлт нь хуримтлагдсан нөлөөлөл бий болгоход түлхэц болдог. Төслийн хуримтлагдсан нөлөөлөл нь төслийн талбайн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн төлөв байдалд богино хугацааны болон орон нутгийн өөрчлөлтийг бий болгож болзошгүй юм. Компакт гэрээний хүрээнд хэрэгжих төслүүдийн байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл, эрсдэлээс хуримтлагдах нөлөөлөл үүсэхээргүй төлөвтэй байна.

3.1.6 Байгаль орчин, нийгмийн нөлөөллөөс зайлсхийх, багасгах арга хэмжээ

Ус хангамжийн төсөл нь МСК-ын байгаль орчны удирдамж, ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

Ус хангамжийн төсөл нь нийгэм эдийн засгийн хувьд эерэг нөлөөтэй ба барилгын ажлын үед богино хугацаанд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг БОМТ, барилгын ажлын гэрээний байгаль орчин, нийгмийн зүйл заалт, ХАБЭА-н удирдамж, үйл ажиллагааны төлөвлөгөө, гэрээлэгчийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөө (ХАБЭАТ), Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө (ХХМТ), Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө болон холбогдох бусад холбогдох бичиг баримтад тусгасны дагуу багасгах боломжтой юм.

Түүнчлэн БОННУ-ний тайлан, БОНМТ дээр үндэслэн барилгын ажлын гэрээлэгчид төслийн талбайн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, хүн худалдаалах болон албадан хөдөлмөр эрхлэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг багтаана. Гүйцэтгэгч нь хүн дамлан худалдаалах, бэлгийн дарамт, албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар сургалт явуулж, эдгээр асуудлаар гомдол хүлээн авах гомдлын механизм, шууд утсыг ажиллуулна.

ГС-1 нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийж, зураг төслийн явцад сөрөг нөлөөллийг бууруулах, зайлсхийх мөн үлдэгдэл нөлөөллийг бууруулах зорилго бүхий төлөвлөгөөг боловсруулах үйл явцыг хамаарна.

Ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулж, цагийг уртасгах үүднээс энгийн ус түгээх байрыг «ухаалаг» буюу автомат горимд шилжүүлснээр тодорхой тооны операторууд, ихэнхдээ эмэгтэй ажилчид ажлын байраа алдах эрсдэлтэй ба энэ эрсдэлийг ГС-2-ын дагуу Нийгэм жендерийн нэгдсэн төлөвлөгөө⁷ болон Нийцлийн төлөвлөгөөнд тусган шийдэх боломжтой. Энэ стандарт нь ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамардаг бөгөөд Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл, Хаягдал ус дахин боловсруулах төслийн бүхий л үйл ажиллагааг хамаарна.

ГС-3-ын дагуу нөөцийн үр ашиг нь ус ба эрчим хүчний үр ашиг, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг харгалзан үзэх боломжтой.

ГС-4-ийн дагуу нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхдээ барилгын үйл ажиллагааны улмаас аливаа гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлэх үүднээс траншейг хааж, иргэдтэй уулзаж зөвлөлдөх байдлаар асуудлыг шийдвэрлэнэ.

ГС-5-ын дагуу нүүлгэн шилжүүлэлт, газар чөлөөлөлт нь иргэдэд сөргөөр нөлөөлөхгүй байхаар шийдвэрлэх шаардлагатай.

рөг⁷ 3 төслийн хүрээнд нийгэм, жендерийн талаар анализ хийж, түүнд суурилсан үйл ажиллагааны арга хэмжээг тусгасныг Монголын МСС-н Нийгэм жендерийн нэгдсэн төлөвлөгөөнөөс харна уу. Уг төлөвлөгөөнд барилгын салбарт ажиллах эмэгтэйчүүдийг дэмжих, чадавхжуулах талаар тусгасан ба орон нутгийн иргэдийн болон гэрээлэгчийн хөдөлмөрийн харилцааг ОУСК-н ГС болон МСК-н бодлогод нийцүүлэн боловсруулж барилгын ажлын худалдан авалтын багцад хавсаргах юм.

ГС-6-ын дагуу Биологийн олон янз байдлын асуудлыг устгах аюулд орсон (эсвэл ховордож болзошгүй) зүйл, амьдрах орчны талаар урьдчилан таамаглаж стандартад нийцсэн эдгээр болзошгүй нөлөөллөөс зайлсхийх, багасгах тодорхой заалтуудыг тодорхойлох юм.

ГС-8-ын соёлын өвийн шаардлагын дагуу Сонгинохайрхан уулын тахилгын овоо руу хүрэх замын тохижилт болон эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлыг тооцоолон БОНМТ-д тусган нийгмийн нөлөөллийг бууруулах боломжтой. Ерөнхийдөө төслийн

байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нөлөө нь их биш байхаар тооцогдож байна.

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭ

Энэ бүлэгт төслөөс үүдэн гарч болзошгүй эрсдэл, нөлөөллийг хэрхэн шийдвэрлэх, төслийн үе шат бүрт эрсдэл, нөлөөллийн үйл ажиллагааг хэн хариуцах, Монголын МСС-гаас байгаль орчин, нийгмийн менежментийг нэвтрүүлэхэд оролцож байгаа бүхий л талуудыг хэрхэн удирдах талаар тодорхой тайлбарласан болно.

4.1 Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээний тойм

Хүснэгт 4-т энэхүү БОНМС-ийн хүрээнд Монголын МСС-гийн хийх голлох ажлууд, төслийг хэрэгжүүлэх удирдлагын үе шат бүрийг товч хураангуйлан үзүүлсэн болно. Мөн хүснэгтэд үйл ажиллагаа бүрд хамаарах Монгол Улсын хууль тогтоомжийг тусгасан ба олон үйл ажиллагаа нь 3 төслийн хувьд адилхан байгааг харж болохоос гадна оролцогч бүрийн үүрэг хариуцлага зэргийг тусгасан болно.

Ү = Үндсэн үүрэгтэй оролцоно

Т = Туслалцаа үзүүлнэ

С = Санал шүүмж өгнө

Б = Батална

Х = Хянана

Хүснэгт 4: Байгаль орчин, нийгмийн удирдлагын үйл ажиллагаа

Үйл ажиллагаа	Хам аарах ГС	МСК-ын Байгаль орчны удирдамж ба ОУСК-ын ГС-ыг дагаж мөрдөх менежментийн арга хэмжээ	Монголын хууль тогтоомж	Хариуцагч тал*					
				Монголын	ПМС	АЕКМ	БОАЖЯ	Барилгын	МСК
Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл									
Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийлгэх	ГС-1-6, 8	<p>Төслийн байгаль орчин, нийгмийн байдалд үзүүлэх сөрөг эрсдэл, нөлөөллийг тодорхойлох зорилгоор БОННУ хийх нь зураг төслийн зөвлөхийн хамгийн эхний алхам юм. Энэхүү үнэлгээ нь бүх ГС-ыг хамарч Байгаль орчин, нийгмийн менежментийн хөтөлбөрүүдээр дамжуулан шийдвэрлэх шаардлагатай эрсдэл, нөлөөллийг тодорхойлох зорилготой.</p> <p>БОННУ-г хийхдээ одоо байгаа болон болзошгүй бохирдол, ажилтнуудын болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, газар чөлөөлөлтийн шаардлага, газар эзэмших зөвшөөрөл, нүүлгэн шилжүүлэх, эдийн засгийн үйл ажиллагааны нүүлгэн шилжүүлэх тохиолдол, биологийн олон янз байдал, соёлын өв зэргийг харгалзан үзэх ёстой.</p>	<p>БОНБУ-ний тухай хууль (2012)-д хоёр төрлийн нөлөөлөх байдлын үнэлгээг тусгасан байдаг. Үүнд:</p> <p>1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг БОАЖЯ хийнэ.</p> <p>2. БОНБ нарийвчилсан үнэлгээ нь тухайн төсөл хэрэгжих газар нутгийн байгаль орчны төлөв байдал, төслийн болзошгүй болон үндсэн сөрөг нөлөөлөл, эрчим, тархалт, үр дагавар, бохирдлыг бууруулах арга хэмжээ, бохирдлыг бууруулах байгаль орчинд ээлтэй техник, технологи, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчны эрсдэлийн үнэлгээ, түүх соёлын үнэт зүйлс, төсөл хэрэгжүүлэх газар, орон нутгийн засаг захиргаа, төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийн санал зэргийг харгалзан үзэх шаардлагатай гэж заасан байдаг. Байгаль орчны үнэлгээ хийх А-117 аргачлал нь газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтэд тавигдах шаардлага, оршин суугчдын эрүүл мэнд, биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг харгалзан үздэг байна.</p> <p>10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, энэ хуулийн 18.4-т заасан саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.</p> <p>18.4.Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцад төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна)</p> <p>11.1.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулж байгаа</p>	С, Т, Х	С, Т, Х	У	Б	Т	Б

			болон учруулсан бол үнэлгээний үнэн зөв хийгдсэн эсэхэд хянан магадалгаа хийнэ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах журам 2014, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөн олговор олгох журам 2018						
БОНМТ боловсруулах	ГС-1-6, 8	ГС-1-ийн дагуу зураг төслийн зөвлөх нь төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөлтэй холбоотой эрсдэлээс зайлсхийх, багасгах арга хэмжээг агуулсан БОНМТ болон бусад шаардлагатай төлөвлөгөөг боловсруулна.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам (2019) нь БОНМТ боловсруулж хэрэгжүүлэх үндсэн чиглэл юм. А-117 аргачлалын дагуу БОНМТ-г боловсруулах явцад нөлөөллийн үнэлгээний судалгаагаар тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах, багасгах, нөхөн сэргээх, хянах, арга хэмжээний талаар төсөл хэрэгжүүлэгч, шийдвэр гаргах, хянах болон бусад оролцогч талуудтай нэгдсэн ойлголтод хүрсний үндсэн дээр төлөвлөхийг зөвлөдөг. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.3-т Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн БОМТ-г батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгох, 14.1.2-т БОМТ-ий биелэлтийг нутгийн оршин суугчид, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнахаар тус тус заасан байдаг. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.9-д (9.10-т заасан Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрээс бусад) төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.	С, Т, Х	С, Т, Х	У	Б	Т	Б
Хог хаягдлын болон ХАБЭА төлөвлөгөө боловсруулах	ГС-2, 3, 4	Барилгын талбар бүрт тохирсон менежментийн төлөвлөгөө нь Хог хаягдлын болон ХАБЭАМТ-г багтаасан байх ба эдгээр төлөвлөгөө нь ГС-2, 4-т нийцүүлэн ажилчдын аюулгүй байдлыг хангах, оршин суугчдын эрүүл мэнд зэрэг заалтуудыг багтаасан байх ёстой.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө нь БОМТ-ний салшгүй хэсэг бөгөөд хатуу, шингэн, хий хэлбэртэй хог хаягдлыг Хог хаягдлын тухай хууль, стандартад нийцүүлэн бууруулах, устгах, зайлуулах арга хэмжээг тусгадаг. БОМТ-нд ДТБУЦБ, дамжуулах хоолой болон холбогдох дэд бүтэц, авто зам, барилгын ажлын үеэр мөрдөх ёстой ХАБЭА, аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг боловсруулж тусгана.	С, Т, Х	С, Т, Х	У	Б	Т	Б

Гэрээ	ГС-2	ГС-2-ын дагуу Монголын МСС-гийн зүгээс Хүний нөөцийн бодлогыг боловсруулж, ажилтнууд болон гэрээлэгч компаниудын ижил төстэй харилцааг зохицуулдаг. Төслийн зураг төсөл, хяналтын гэрээт ажилтнууд нь Монголын МСС-гийн хүний нөөцийн бодлогыг дагаж мөрдөх шаардлагатай.	Ажлын байран дахь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт, хөдөлмөрийн харилцаанд орж буй ажилтан болон ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хувь хүний болон хамтын хөдөлмөрийн маргааныг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008, 2012) болон Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулдаг.	Y	X	T	T	T	B
Гомдол барагдуулах механизм	ГС-1, 2, 4	Монголын МСС-гийн болон гүйцэтгэгч байгууллагуудын хооронд үүссэн гомдлыг ГС-1 ба 2-ын дагуу боловсруулж, Монголын МСС-гийн гомдлыг бууруулах механизмаар шийдвэрлэх бөгөөд мөн ГС-4-т хамаарах боломжтой (Хавсралт 6-ыг үзнэ үү).	Төслийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, саналыг БОМТ-нд тусгаж, Гомдол барагдуулах механизмаар шийдвэрлэх юм. Ажлын байр болон ажил үүрэгтэй холбоотой гомдол санал гарч болно. Хөдөлмөрийн тухай хууль (1995, 2008 он) нь хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийн үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцож байгаа ажилчид ба ажил олгогчдын нийтлэг эрх, үүргийг зохицуулж, хувь хүний болон хамтын хөдөлмөрийн маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт, өр төлбөртэй холбоотой дүрэм журмыг зохицуулдаг.	T	X	Y	T	Y	T
Талуудын хамтын ажиллагаа	ГС-1, 4, 5	Төслийн зураг төсөл боловсруулахаас өмнөх болон боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжүүлсний дараах үе шатуудад оролцогч талуудын хамтын ажиллагааг 6-р хавсралтад заасны дагуу тодорхойлсон ба уг төлөвлөгөөг ГС-1, 2, 4 болон 5-н дагуу боловсруулсан болно.	Усны төслүүдэд олон нийтийн болон оролцогч талуудын оролцоог хангахад зориулагдсан тусгай хууль тогтоомж байдаггүй. 2012 оны БОННУ2-ний тухай хуульд БОННУ2-ний үйл явцад төслийн талаарх мэдээллийг нээлттэй болгох, нөлөөллийн цар хүрээг зөвлөлдөх, болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлж, төслийн үр дүнгийн талаар бүрэн мэдээлэл авах шаардлагатай байдаг тул олон нийтийн оролцоог хангах, төслийн нөлөөлөлд өртсөн иргэд, орон нутгийн засаг захиргаанаас санал авах шаардлагатай гэж заасан байдаг. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журам”-д төсөл хэрэгжүүлэгч нь нөлөөллийн үнэлгээний үйл явцад олон нийтийн оролцоог хангаж, БОМТ боловсруулж, хэрэгжүүлэлтийг жилд дор хаяж нэг удаа орон нутгийн иргэд, олон нийтэд мэдээлэх заалт оруулсан байдаг.	Y	T	T	T	T	T
Нүүлгэн шилжүүлэлт ийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	ГС-5	Барилгын ажил эхлэхээс өмнө талбайг бэлэн болгох шаардлагатай ба НШТ-г боловсруулж, хувь хүний нөхөн олговор, амьжиргааг нөхөн сэргээлтийн төлөвлөгөө бүрийг тусгаж өгсөн байх шаардлагатай.		C, T, X	C, T, X	Y	B	T	B
Нийгмийн асуудлыг тусгах	ГС-1	ГС-1-т тодорхойлсны дагуу хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн иргэдэд төслийн үр ашгийг хүртэхэд саадгүй байхаар тухайн иргэдэд тохирсон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг Монголын МСС нь санал болгох ёстой.	БОННУ2-ний А-117 аргачлалын (3.4.4) хэсэгт нийгмийн нөлөөллийн үнэлгээний хүрээнд нийгэм, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллөөр нь харьцуулан шинжилж оршин суугчдын ахуй амьжиргааны тухайн үеийн нөхцөл байдал нь дордохгүй байх хувилбарыг	Y	X	T	T	T	T

			тодорхойлох шаардлагатай хэмээн заасан. Мөн төслүүдийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн бүс нутгийн нийгмийн бүлэг, нутгийн иргэдийг тодорхойлсон байхыг шаарддаг.						
Монголын МСС-гийн мониторинг үнэлгээ	ГС-1, 2	Монголын МСС-гийн зүгээс зөвлөх, гүйцэтгэгч байгууллагуудын ажлын явцыг хянах ба ирүүлсэн тайланг хянах, төслийн талбай дээр очиж шалгах боломжтой. Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн баг нь тайлангийн үйл ажиллагаа, ахиц дэвшил, үнэн зөв эсэхийг хянах зорилгоор үе үе төслийн талбай дээр очиж ажил явдалтай биечлэн танилцаж болно.	Орон нутгийн байгаль орчны байцаагч, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны төрийн бус байгууллагууд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй.	Y	X	T	T	T	T
Хаягдал ус дахин боловсруулах төсөл									
Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийлгэх	ГС-1 – 6, 8	<p>Төслийн байгаль орчин, нийгмийн байдалд үзүүлэх сөрөг эрсдэл, нөлөөллийг тодорхойлох зорилгоор БОННУ хийх нь зураг төслийн зөвлөхийн хамгийн эхний алхам юм. Энэхүү үнэлгээ нь бүх ГС-ыг хамарч Байгаль орчин, нийгмийн менежментийн хөтөлбөрүүдээр дамжуулан шийдвэрлэх шаардлагатай эрсдэл, нөлөөллийг тодорхойлох зорилготой.</p> <p>БОННУ хийхдээ одоо байгаа болон болзошгүй бохирдол, ажилтнууд болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, газар чөлөөлөлтийн шаардлага, газар эзэмших зөвшөөрөл, албадан нүүлгэн шилжүүлэх, эдийн засгийн үйл ажиллагааны нүүлгэн шилжүүлэх тохиолдол, биологийн олон янз байдал, соёлын өв зэргийг харгалзан үзэх ёстой.</p>	<p>БОННУ2-ний тухай хууль (2012)-д хоёр төрлийн нөлөөлөх байдлын үнэлгээг тусгасан байдаг. Үүнд: 1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг БОАЖЯ хийнэ.</p> <p>2. БОНБ нарийвчилсан үнэлгээ нь тухайн төсөл хэрэгжих газар нутгийн байгаль орчны төлөв байдал, төслийн болзошгүй болон үндсэн сөрөг нөлөөлөл, эрчим, тархалт, үр дагавар, бохирдлыг бууруулах арга хэмжээ, бохирдлыг бууруулах байгаль орчинд ээлтэй техник, технологи, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчны эрсдэлийн үнэлгээ, түүх соёлын үнэт зүйлс, төсөл хэрэгжүүлэх газар, орон нутгийн засаг захиргаа, төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийн санал зэргийг харгалзан үзэх шаардлагатай гэж заасан байдаг. Байгаль орчны үнэлгээ хийх А-117 аргачлал нь газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтэд тавигдах шаардлага, оршин суугчдын эрүүл мэнд, биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг харгалзан үздэг байна.</p> <p>10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, энэ хуулийн 18.4-т заасан саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.</p> <p>18.4.Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцад төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.</p>	C, T, X	C, T, X	Y	B	T	B

боловсруулах		аюулгүй байдлыг хангах, оршин суугчдын эрүүл мэнд зэрэг заалтуудыг багтаасан байх ёстой.	стандартад нийцүүлэн бууруулах, устгах, зайлуулах арга хэмжээг тусгадаг. БОМТ-д ДТБУЦБ, дамжуулах хоолой болон холбогдох дэд бүтэц, авто зам, барилгын ажлын үеэр мөрдөх ёстой ХАБЭА, аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг боловсруулж тусгана.						
Үйл ажиллагааны гарын авлага									
Гэрээ	ГС-2	ГС-2-н дагуу Монголын МСС-гийн зүгээс Хүний нөөцийн бодлогыг боловсруулж, өөрийн ажилтнууд болон гэрээлэгч компаниудын ижил төстэй харилцааг зохицуулдаг. Төслийн зураг төсөл, хяналтын гэрээт ажилтнууд нь Монголын МСС-гийн хүний нөөцийн бодлогыг дагаж мөрдөх шаардлагатай.	Ажлын байран дахь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт, хөдөлмөрийн харилцаанд орж буй ажилчид болон ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хувь хүний болон хамтын хөдөлмөрийн маргааныг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008, 2012) болон Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулдаг.	Y	X	T	T	T	Б
Талуудын хамтын ажиллагаа	ГС-1, 4, 5	Төслийн зураг төсөл боловсруулахаас өмнөх болон боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжүүлсний дараах үе шатуудад оролцогч талуудын хамтын ажиллагааг 6-р хавсралтад заасны дагуу тодорхойлсон ба уг төлөвлөгөөг ГС-1, 2, 4 болон 5-н дагуу боловсруулсан болно.	Усны төслүүдэд олон нийтийн болон оролцогч талуудын оролцоог хангахад зориулагдсан тусгай хууль тогтоомж байдаггүй. 2012 оны БОНБУ-ний тухай хуульд БОНБУ-ний үйл явцад төслийн талаарх мэдээллийг нээлттэй болгох, нөлөөллийн цар хүрээг зөвлөлдөх, болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлж, төслийн үр дүнгийн талаар бүрэн мэдээлэл авах шаардлагатай байдаг тул олон нийтийн оролцоог хангах, төслийн нөлөөлөлд өртсөн иргэд, орон нутгийн засаг захиргаанаас санал авах шаардлагатай гэж заасан байдаг. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журам”-д төсөл хэрэгжүүлэгч нь нөлөөллийн үнэлгээний үйл явцад олон нийтийн оролцоог хангаж, БОМТ боловсруулж, хэрэгжүүлэлтийг жилд дор хаяж нэг удаа орон нутгийн иргэд, олон нийтэд мэдээлэх заалт оруулсан байдаг.	Y	T	T	T	T	T
Гомдол барагдуулах	ГС-1, 2	Монголын МСС-гийн болон гүйцэтгэгч байгууллагуудын хооронд үүссэн гомдлыг ГС 1 ба 2-ийн дагуу боловсруулж, Монголын МСС-ийн гомдлыг бууруулах механизмаар шийдвэрлэх бөгөөд мөн ГС 4-т хамаарах боломжтой (Хавсралт 6-ыг үзнэ үү).	Төслийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, саналыг БОМТ-д тусгаж, Гомдол барагдуулах механизмаар шийдвэрлэх юм. Ажлын байр болон ажил үүрэгтэй холбоотой гомдол санал гарч болно. Хөдөлмөрийн тухай хууль (1995, 2008 он) нь хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийн үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцож байгаа ажилчид ба ажил олгогчдын нийтлэг эрх, үүргийг зохицуулж, хувь хүний болон хамтын хөдөлмөрийн маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт, өр төлбөртэй холбоотой дүрэм журмыг зохицуулдаг.	T	X	Y	T	Y	T

Монголын МСС-гийн мониторинг үнэлгээ	ГС-1	Монголын МСС-гийн зүгээс зөвлөх, гүйцэтгэгч байгууллагуудын ажлын явцыг хянах ба ирүүлсэн тайланг хянах, төслийн талбай дээр очиж шалгах боломжтой. Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн баг нь тайлангийн үйл ажиллагаа, ахиц дэвшил, үнэн зөв эсэхийг хянах зорилгоор үе үе төслийн талбай дээр очиж ажил явдалтай биечлэн танилцаж болно.	Орон нутгийн байгаль орчны байцаагч, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны төрийн бус байгууллагууд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй.	Y	X	T	T	T	T
Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл									
Талуудын хамтын ажиллагаа	ГС-1, ГС-2	Энэхүү үйл ажиллагаанд институтын шинэчлэл болон олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа багтаж байгаа ба оролцогч талуудын оролцоо маш чухал үүрэгтэй юм. Оролцогч талуудын хамтын ажиллагааг 6-р хавсралтад заасны дагуу тодорхойлсон ба уг төлөвлөгөөг ГС-1, 2, 4 болон 5-ын дагуу боловсруулсан болно. Зураг төсөл болон барилгын ажил энэ төслийн үйл ажиллагаанд хамаарахгүй учраас бусад ГС төдийлөн хамааралгүй. Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагааны хүрээнд энгийн ус түгээх байрыг «ухаалаг» буюу автомат горимд шилжүүлэх замаар шууд зардлыг бууруулах олон ажлууд хийгдэх ба УСУГ нь ажилчдаа халахгүй байх бодлогыг тусгасан төлөвлөгөө боловсруулах үүрэг хүлээсэн. Тухайн ажилтнуудын эрх, үүрэг, хөдөлмөрийн нөхцөлийг ГС-2-оор зохицуулна.	Усны төслүүдэд олон нийтийн болон оролцогч талуудын оролцоог хангахад зориулагдсан тусгай хууль тогтоомж байдаггүй. 2012 оны БОННУ2-ний тухай хуульд БОНН2У-ний үйл явцад төслийн талаарх мэдээллийг нээлттэй болгох, нөлөөллийн цар хүрээг зөвлөлдөх, болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлж, төслийн үр дүнгийн талаар бүрэн мэдээлэл авах шаардлагатай байдаг тул олон нийтийн оролцоог хангах, төслийн нөлөөлөлд өртсөн иргэд, орон нутгийн засаг захиргаанаас санал авах шаардлагатай гэж заасан байдаг.	Y	T	T	T	T	T
Монголын МСС-гийн мониторинг үнэлгээ		Монголын МСС-гийн зүгээс зөвлөх, гүйцэтгэгч байгууллагуудын ажлын явцыг хянах ба ирүүлсэн тайланг хянах, төслийн талбай дээр очиж шалгах боломжтой. Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн баг нь тайлангийн үйл ажиллагаа, ахиц дэвшил, үнэн зөв эсэхийг хянах зорилгоор үе үе төслийн талбай дээр очиж ажил явдалтай биечлэн танилцаж болно.	Орон нутгийн байгаль орчны байцаагч, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны төрийн бус байгууллагууд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй.	Y	X	T	T	T	T

*Тэмдэглэгээ: Y = Үндсэн үүрэгтэй оролцоно

Д = Дэмжлэг үзүүлнэ

С = Санал шүүмж өгнө

2..1.1.1 Б = Батална

X = Хянана

4.2 Байгаль орчин, нийгмийн менежментийн үе шатууд

Энэхүү БОНМС-д тодорхойлсон байгаль орчны болон нийгмийн үйл ажиллагаа нь, анхан шатны болон эрсдэлийн үнэлгээ хийх, болзошгүй нөлөөллийг тодорхойлох, нөхөн сэргээлтийн арга

хэмжээ авах, бүх үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн нийцлийг хангахаас эхлээд төслийн хэрэгжилтийн бүх үе шатуудыг хамарна (Хүснэгт 5).

Хүснэгт 5: Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үйл ажиллагаа

Төсөл	Хэрэгжүүлэх явцад ашиглах менежментийн хэрэгслүүд	Хэрэгжүүлэгч	Хяналт шинжилгээг хариуцах этгээд	Монголын МСС-гийн үүрэг
Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл, Хаягдал ус дахин боловсруулах төсөл	- БОНМТ - Онцгой байдлын үеийн арга хэмжээ төлөвлөгөө; - ХАБЭА төлөвлөгөө; - Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө; - Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө; - Байгаль орчны аудитын төлөвлөгөө; - Археологи палеонтологийн судалгаа	Барилгын ажил гүйцэтгэгч Барилгын ажил гүйцэтгэгч нь талбай тус бүрд тохирсон төлөвлөгөө, сургалтын материал (шаардлагатай бол) боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг хариуцаж, бүх бичиг баримтыг Хяналтын зөвлөхтэй тохиролцсон эсэхийг баталгаажуулна. Барилгын ажил гүйцэтгэгчийн боловсруулсан бүх баримт бичиг нь БОМТ, ХАБЭАМТ болон холбогдох хууль тогтоомж, стандартад нийцэж байх ёстой. Байгаль орчин болон нийгмийн төлөвлөгөөний хэрэгжилт, дотоод хяналтын журам, нөлөөллийг бууруулах арга хэмжээг хариуцах үүрэг гүйцэтгэгч (байгаль орчны менежер, нийгмийн менежер, аюулгүй байдал эрүүл ахуйн менежер)-ийг Барилгын ажлын гэрээлэгч хуваарилна; Барилгын ажлын гүйцэтгэгч Хяналтын зөвлөхөд тайлангаа хүргүүлж тайлагнана.	Хяналтын зөвлөх Хяналтын зөвлөх нь барилгын ажлын өдөр тутмын явц болон барилгын ажил гүйцэтгэгчийн боловсруулсан байгаль орчин нийгмийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Хяналтын зөвлөх нь байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулж, байгаль орчны болон нийгмийн менежерүүд, барилгын талбайн байцаагчаар дамжуулан хэрэгжүүлнэ.	Монголын МСС, БОН баг Байгаль орчин, нийгмийн асуудлаар компактын санхүүжилтээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны журам, удирдамж боловсруулж, БОНМС-ийг боловсруулж, баримт бичгийг тогтмол шинэчилж байх. Төслийн талбай руу тогтмол очиж барилгын ажлын явцтай танилцах ба удирдлагуудад танилцуулна. Барилгын ажлын гүйцэтгэгч болон Зөвлөхийн ирүүлсэн бичиг баримтыг хянах, зөвшөөрөл өгөх ба Монгол улсын засгийн газрыг төлөөлж МСК-тай харилцана. Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал, мэргэжилтнүүд нь барилгын ажлын байгаль орчин болон нийгмийн шаардлагын ГС болон дотоодын хууль тогтоомжийг нийцэж байгаа эсэхэд хяналт тавина.
Усны салбарын ТБ		Барилгын ажлын гэрээлэгч	Хяналтын зөвлөх	Монголын МСС, БОНГ баг

4.2.1 1-р үе шат - Үнэлгээ

2..1.1.1.1 Хариуцагч этгээд: Байгаль орчны чиглэлийн мэргэжилтнүүдийн хамтаар АЕКОН

Анхан шатны үнэлгээ хийж төслийг ангилснаар цаашид ямар төрлийн байгаль орчны үнэлгээг хэр цар хүрээг хамарсан байдлаар хийх шаардлагатай болохыг тодорхойлж гаргана. Төслийн хувьд Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ1), Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОННУ2) хийлгэж МСК-ын зөвшөөрлийг авах шаардлагатай байна. Энэхүү үнэлгээний явцад Монголын МСС-гийн БОНМС, МСК-ын Байгаль орчны удирдамж, ОУСК-ын ГС, Монгол улсын байгаль орчин болон нийгмийн хууль тогтоомжийг харгалзан үзэх шаардлагатай болно.

Монголын МСС нь МСК-ыг урьдчилсан үнэлгээний ажлын эхэн үеэс холбогдох мэдээллээр хангах ба БОННУ1-ний тайлан, Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө, БОНМТ болон бусад байгаль орчны үнэлгээтэй холбоотой баримт бичгийг МСК-д хянуулахаар илгээж, зөвшөөрөл авах үүрэгтэй.

4.2.2 2-р үе шат – Байгаль орчны бичиг баримт боловсруулах

2..1.1.1.2 Хариуцагч этгээд: АЕКОМ , Монголын МСС-гийн БОНГ-ийн захирал болон ПМС

Үнэлгээний ажлын дараа төслийн зураг төсөл, түүний хэрэгжилтэд байгаль орчин, нийгмийн асуудлыг тусгасан төсөл тус бүрт тохирох байгаль орчин, нийгмийн хамгааллын баримт бичиг боловсруулна.

Баримт бичигт заасан шаардлагыг (ялангуяа БОНМТ) тендерийн баримт бичигт тусгах тул боломжит тендерт оролцогч нь байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзэж, холбогдох ажилтнуудын оролцоог хангаж, шаардлагыг хэрэгжүүлэхэд зориулж төсөв хуваарилна.

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ

Хариуцагч этгээд: АЕКОМ , Монголын МСС-гийн БОНГ-ийн захирал болон ПМС, Байгал орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл

МСК-ын Байгаль орчны зааварчилгаанд: БОННУ1-ний цар хүрээ, нарийвчлал нь тухайн төслийн боломжит нөлөөлөлд тохирсон байх ёстой гэж заасан байдаг.

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайлан нь доорх агуулгаас бүрдэх ба үзүүлсэн дэс дарааллаар байх шаардлагагүй:

- **Товчилсон агуулга:** Үнэлгээний ажлын гол үр дүн, цаашид авах санал болгож буй арга хэмжээ.
- **Хамрах хүрээ:** Голлох асуудал, нөлөөллийг тодорхойлж, БОННУ-ний хүрээнд хийгдэх ажлын даалгаврыг тодорхойлно.
- **Бодлого, хууль тогтоомж:** Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдэх үед дагаж мөрдөх хууль тогтоомж, бодлого, дүрэм журмыг тусгасан байна.
- **Төслийн тодорхойлолт:** Төслийн газарзүй, экологи, нийгмийн болон түр зуурын төлөв байдлыг тодорхойлно. Мөн нийгмийн болон нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө, төслийн байршлын зураг зэргийг оруулна.
- **Суурь мэдээлэл:** төслийн судалгаа хийх талбайн хэмжээ, төсөл эхлэхээс өмнө хүлээгдэж буй өөрчлөлтийг багтаасан холбогдох физик, биологи, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг тодорхойлно. Нэмээд төслийн талбайтай ойр орчимд одоогийн явагдаж байгаа болон цаашид хийгдэхээр санал болгож буй бүтээн байгуулалтын ажлуудыг харгалзан үзэх ёстой.
- **Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл:** Уг төслийн байгаль орчин болон тухайн нутагт оршин сууж буй иргэдэд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөлөл, соёлын үнэт зүйл, албадан нүүлгэн шилжүүлэлт, хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцоолж гаргана. Мөн шууд, шууд бус болон хуримтлагдах нөлөөг тооцоолж болно. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ, багасгах боломжгүй аливаа сөрөг нөлөөлөл, байгаль орчныг сайжруулах боломжийг судалж үзэх ба суурь мэдээллийн чанар, хэмжээ, судлагдаагүй үлдсэн мэдээллийн зөрүү болон цаашид анхаарал хандуулах шаардлагагүй хэсгийг бас үнэлгээний ажлаар тодорхойлж гаргана.
- **Хувилбаруудын судалгаа:** Төслийн талбай, технологи, зураг төсөл, ашиглалтын боломжит хувилбаруудыг, түүний дотор байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, түүнийг бууруулах боломжит хувилбар, шаардлагатай хөрөнгө, мөнгөн дүн, хууль эрхзүйн болон сургалт, орон нутгийн нөхцөлд тохирсон байдал, хяналт тавих шаардлагыг харгалзан “төсөл хэрэгжихгүй байх” нөхцөл байдлыг оруулан харьцуулсан судалгаа хийнэ. Хувилбар бүрийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, эдийн засгийн үндэслэлийг боломжтой хэмжээгээр нь тооцож гаргана. Энэ судалгаа нь санал болгож буй төслийн тодорхой хувилбарыг сонгох үндэслэл

болох ба төслийн үйл ажиллагаанаас үүдэн ялгаруулах хэмжээ, бохирдлоос урьдчилан сэргийлэх, багасгах арга замыг тодорхойлж өгнө.

- Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (доор харна уу)
- **Зөвлөх:** Төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүс, орон нутгийн төрийн бус болон засаг захиргааны байгууллагуудын санал бодлогыг авах зорилго бүхий зөвлөлдөх уулзалт зохион байгуулагдах ба төслийн түвшний уулзалтууд төслийн хамрах хүрээг тодорхойлсон үеэс эхлэн төслийн хэрэгжилтийн хугацаанд үргэлжлэх ёстой⁸.

2.1.1.1.2.1 Байгаль орчин, нийгмийн аудит

Хариуцагч этгээд: *Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал мэргэжилтнүүдийн хамт*

“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах А/618 журам”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10.1-р зүйл, 2014 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тухай А-117 удирдамж зэрэгт “Байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа төсөл хэрэгжүүлэгч 2 жил тутамд байгаль орчны хуваарьт аудит хийлгэн, аудитын тайлан болон аудитын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны газарт ирүүлж, уг аудитын тайлан, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланд менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн талаар бодит мэдээлэл, дүгнэлтийг тусгасан байх бөгөөд хугацааны хувьд давхцаж байвал тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага дүгнэх нөхцөл болгож болно” хэмээн заасны дагуу Монголын МСС нь байгаль орчны аудитыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар төсөл эхэлсэн 2 дахь жилээс хийлгэх шаардлагатай хэмээн заасны дагуу хуваарьт аудитыг хийлгэх үүрэгтэй.

Аудитын тайлан нь доорх мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- (i) Хураангуй;
- (ii) Төслийн үйл ажиллагааг багтаасан тодорхойлолт;
- (iii) Дотоодын болон олон улсын хууль, дүрэм, журам;
- (iv) Аудит хийх процесс;
- (v) Илрүүлсэн мэдээлэл;
- (vi) Өртөг, хуваарь, асуудал тус бүрт тохирох залруулах арга хэмжээ зэргийг багтаасан залруулах ажиллагааны төлөвлөгөө.

Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө

Хариуцагч этгээд: *Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал болон Байгаль орчны газрын зөвшөөрөлтэйгөөр АЕКОМ*

БОНМТ нь төслийн барилгын ажлыг гүйцэтгэх үеийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

БОНМТ-д сөрөг нөлөөллийг бууруулах, хянах, хуваарь, төсөв боловсруулах үүрэг бүхий хариуцагч бүрийг тодорхой тусгаж, төслийн зураг төсөл, барилга угсралт, ашиглалтад орох үе шатанд үзүүлж болзошгүй нөлөөллийг тодорхойлно.

Бүх гэрээ нь байгаль орчин, нийгмийн хамгааллын холбогдох шаардлага, хүлээсэн үүргийг агуулсан байна.

4.2.3 3-р үе шат – Барилгын ажлын үеийн сөрөг нөлөөллийг бууруулах

Хариуцагч этгээд: *Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал болон Байгаль орчны газрын зөвшөөрөлтэйгөөр ПМС*

Барилгын ажлын гүйцэтгэгч нь байгаль орчин, нийгмийн журам, ялангуяа төсөл бүрийн

⁸ МСК-ын Байгаль орчны зааварчилгаа, 2012.06.28

БОНМТ-г хэрэгжүүлэх үүрэгтэй. Мөн төслийн талбайд зориулсан Хог хаягдлын, Онцгой байдлын үеийн, ХАБЭА төлөвлөгөө бүхий БОНМТ-г боловсруулах шаардлагатай.

4.2.4 4-р үе шат – Мониторинг үнэлгээ

Хариуцагч этгээд: Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал болон ПМС

Төслийг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлагыг хангах үүднээс Байгаль орчин, нийгмийн мониторингийг Монголын МСС нь төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч ПМС компанийн хамт хийж гүйцэтгэнэ. Уг баримт бичгийн 6.2-т заасны дагуу мониторинг үнэлгээний тайланг гаргана. Мониторинг үнэлгээ нь БОНМТ болон бусад байгаль орчин, нийгмийн шаардлагын дагуу зайлшгүй хийх нэмэлт өөрчлөлтийг олж тогтоох боломжтой юм.

4.2.5 5-р үе шат– Төслийн хаалт

Хариуцагч этгээд: Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал, ПМС болон Монголын МСС-гийн баг хамт олон

Төсөл хэрэгжих үе шат дууссаны дараа төслийн тогтвортой байдлыг хангах зорилгоор байгаль орчин, нийгэм, жендэр, эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх арга замыг агуулсан Монголын МСС-гийн хаалтын төлөвлөгөө боловсруулна. Компакт гэрээ дуусахаас өмнө Монголын МСС-гийн зүгээс байгаль орчин, нийгэм, жендэр, эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал, бусад аливаа төсөл хөтөлбөртэй холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэнэ. Үүнийг энэ баримт бичгийн 4.8 хэсэгт тайлбарласан байгаа бөгөөд үүнд төсөл дууссаны дараа хүлээлгэн өгөх Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн үйл ажиллагааг багтаасан болно.

4.3 Төслийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Хариуцагч этгээд: Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирлын хяналт, ПМС

4.2.3 дугаар хэсэгт дурдсанчлан төсөл тус бүрийн зураг төсөл, барилгын ажлын үед гарах сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг тусгах зорилгоор БОНМТ-г боловсруулах шаардлагатай. Монголын МСС нь төслийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох явцад гарах асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ, гарах үр дүнг тодорхойлсон Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө⁹ боловсруулах замаар менежментийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой хугацааны турш гарах гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилт, эсвэл хүлээн авах шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх нөөц, хариуцлагын тооцоог тусгасан байх ёстой.

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд жендэрийн хэсгийг гүйцэтгэлийн үзүүлэлт, бусад шаардлагууд, Жендэрийн төлөвлөгөөнөөс гарч буй үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах шаардлагатай хэсгийг боловсруулж, оруулна. Шаардлагатай тохиолдолд менежментийн хөтөлбөр нь тодорхойлогдсон эрсдэл, нөлөөллийг, түүний дотор хуримтлагдсан нөлөөллийг арилгахын тулд Засгийн газар болон гурав дахь этгээдийн удирдлага дор тодорхой үйл ажиллагаа, арга хэмжээ авах үүрэг хүлээнэ. Удирдлагын хөтөлбөр нь тухайн үеийн нөхцөл байдал, төлөвлөөгүй үйл явдлууд, хяналт, шалгалтын үр дүнд дасан зохицон, хариу арга хэмжээ авдаг байх ёстой.

4.4 Оролцогч талуудын оролцоог хангах

Хариуцагч этгээд: Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирлын хяналт, ПМС

Дараах хэсэг нь Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөөний хураангуйлсан хэлбэр бөгөөд 6-р хавсралтаас үзнэ үү.

⁹ Үйл ажиллагааны төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний цогц ажлыг багтаасан Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө, эсвэл нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө, биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг орж болно.

4.4.1 Төслийн нөлөөлөлд өртсөн иргэдтэй уулзах

Олон нийтийн оролцоо гэдэг нь төслүүдийн үйл ажиллагаанд олон нийтийг оролцуулах, Монголын МСС-гийн болон гэрээт байгууллагуудад мэдээллийг ил тод хүргэх тасралтгүй явагдах үйл явц бөгөөд орон нутгийн иргэдтэй хамтын харилцаа холбоог бий болгох, хадгалах зорилготой юм. Орон нутгийн иргэдийн оролцооны шинж чанар, давтамж нь төсөл тус бүрийн иргэдэд үзүүлэх эрсдэл, нөлөөллөөс хамаарах ба залилах, хөндлөнгөөс оролцох, шахалт үзүүлэх, айлган сүрдүүлэх зэрэг зүйлээс ангид байж, цаг үеэ олсон, ач холбогдолтой, ойлгомжтой, мэдээллийг хүргэх замаар зохион байгуулагдах ёстой. БОНБУ-ний үйл явцад олон нийтийн оролцоог хангахаар заасан Монголын хууль эрх зүйн шаардлага бий. Орон нутгийн иргэд төслийн байгаль орчны үнэлгээний үйл явцад оролцох өөрсдийн үүргээ сайн мэддэг байх нь чухал юм.

4.4.2 Эмзэг бүлгийн иргэд болон эмэгтэйчүүдийн мэдлэгийг дээшлүүлэх

МСК-ын Жендэрийн бодлогын баримт бичгийн дагуу Монголын МСС нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн зөвлөлдөх үйл явц, уулзалтад эрх тэгш оролцох боломжийг хангаж, орон нутгийн иргэдийн оролцоонд эдгээр эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн идэвх чухал болохыг онцлох ёстой. Байгаль орчин, нийгмийн талын (жендэрийг оруулаад) мэдлэгийг дээшлүүлэх нь олон нийтийн оролцооны үйл явцын нэг хэсэг байх ёстой ба эмэгтэйчүүдийн бүлгийг чадавхжуулахдаа тосгоны эмэгтэйчүүдийн (хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд) хувьд нэн чухал байдаг өмчлөлийн болон хууль эрхзүйн бүртгэлтэй байх асуудлыг зайлшгүй бодолцох ёстой.

Мэдлэгийг сайжруулах, хангалттай мэдээлэл өгөх нь төслийн нөлөөлөлд өртсөн иргэд төслийн талаар ойлголт сайтай болох, бүх гишүүд түүний төслийн ашиг тусыг хүртэх, байгаль орчин, нийгмийн янз бүрийн асуудлаар иргэд гомдол гаргах механизмыг мэддэг болоход тустай юм.

4.4.3 Мэдээлэх

Төслийн нөлөөлөлд өртсөн иргэдэд холбогдох мэдээлэл өгснөөр иргэд төслийн эрсдэл, нөлөөлөл боломжийн талаар ойлголттой болох юм. Төслийн талбайд ойрхон амьдардаг иргэд нь төслийн эрсдэл, нөлөөнд өртөж болзошгүй тохиолдолд Монголын МСС болон гүйцэтгэгч байгууллагууд нь тухайн иргэдэд төслийн зорилго, шинж чанар, хамрах цар хүрээ, төлөвлөж буй үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа, аливаа эрсдэлийн талаарх мэдээллийг олж авах боломжийг олгох ёстой ба энэхүү мэдээлэх үйл явц нь барилгын ажил эхлэхээс өмнө эхлэх ёстой.

4.4.4 Хэлэлцүүлэг хийх

Монголын МСС-гийн зүгээс болон гүйцэтгэгч байгууллагууд нь төслийн нөлөөлөлд өртсөн иргэдэд төслийн эрсдэл, нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний талаар өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх боломж олгож, хариу арга хэмжээ авах байдлаар хэлэлцүүлэг зохион байгуулах ёстой ба хамгийн үр нөлөө бүхий хэлэлцүүлэг нь:

- (i) шаардлагатай мэдээллийг урьдчилан хүргүүлэх төлөвлөгөө болон баримт бичиг боловсруулах;
- (ii) төслийн үйл ажиллагаа хэрэгжилтээс өмнө эхлэх;
- (iii) иргэд болон эмэгтэйчүүд, нутгийн уугуул иргэдэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэл түүнийг бууруулах арга хэмжээнд төвлөрөх
- (iv) тасралтгүй явагдах зэрэг шалгуурыг хангадаг байна.

Хэлэлцүүлэг нь олон нийтэд хүртээмжтэй, тухайн нутаг орны соёлд нийцэж явагдах ёстой ба Монголын МСС-гийн зүгээс болон тэдгээрийн гэрээт байгууллагууд нь төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийн нутгийн аялга, тэдний шийдвэр гаргах явц, эмзэг бүлгийн хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлэн хэлэлцүүлгийг зохион байгуулна.

4.4.5 Оролцооны арга хэрэглэх

Монголын МСС-гийн зүгээс болон гүйцэтгэгч байгууллагууд нь мэдээллийн оролцооны аргыг ашиглан нөлөөлөлд өртсөн иргэдийн нөлөөлөл болон бууруулах арга хэмжээний талаар илэрхийлсэн үзэл бодлыг өөрсдийн шийдвэр гаргах үйл явцад тусгах замаар зохион байгуулалттай, давтамжтайгаар хэлэлцүүлгийг явуулах ба бүхий л үйл явцыг, ялангуяа

нөлөөлөлд өртсөн орон нутагт үзүүлэх эрсдэлийг бууруулах, багасгах чиглэлээр авсан арга хэмжээг баримтжуулна.

4.5 Санал, гомдол барагдуулах механизм

Хариуцагч этгээд: Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал, гэрээт компаниуд

Төслийн үйл ажиллагаа, хэрэгжилттэй холбоотой гарах санал гомдлыг Монголын МСС нь өөрсдийн боловсруулсан Гомдол барагдуулах механизм (ГБМ) буюу гомдол хүлээн авч шийдвэрлэх аргачлалаар зохицуулна (Хавсралт 6 болон Зураг 8-аас Гомдол барагдуулах үе шатыг харна уу). Энэхүү ГБМ нь бүх шатны гомдлыг шийдвэрлэх орон нутгийн түвшний уламжлалт механизм¹⁰, тухайн гарсан гомдлыг шийдвэрлэх хууль, засаг захиргааны арга хэлбэрийг дэмжих зорилготой. Олон нийт болон бусад оролцогч талуудын гаргасан гомдол, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар баримтжуулах ба төслийн үйл ажиллагаатай холбоотой байсан ч дараах гомдлуудад хамаарахгүй. Үүнд:

- (i) Монголын МСС-гийн Хүний нөөцийн бодлогын дагуу шийдвэрлэгдэх захиргааны үйл ажиллагаатай холбоотой гомдол;
- (ii) Монголын МСС-гийн Хуулийн зөвлөхийн тушаалаар шийдэгдэх ханган нийлүүлэгч, гэрээт байгууллагуудын хооронд хийсэн худалдан авалт, гэрээтэй холбоотой гомдол;
- (iii) Хуулийн зөвлөхийн бүрэн эрхийн хүрээнд хамрах хууль тогтоомжтой холбоотой гомдол зэрэг болно.

4.5.1 Гомдол хүлээн авах

Гомдол шийдвэрлэхэд Гомдлын маягт бөглөн, гэрээлэгч компанид хүргүүлэх бөгөөд Гүйцэтгэгч энэ журмын дагуу өргөдөл гомдлын маягт дээр ирүүлээгүй аливаа гомдлыг авч хэлэлцэхгүй. Нүүлгэн шилжүүлэлт болон газар чөлөөлөх үйл ажиллагаатай холбоотой гомдлыг Улаанбаатар хотын Газрын алба хариуцах ба бусад гомдлыг гүйцэтгэгч компанийн тухайн ажлыг хариуцсан захирал болон хэлтэс рүү илгээх хэрэгтэй. Гомдол гаргагчид бөглөсөн өргөдлийн маягтын хуулбарыг өгч, гомдлын хуудсыг бүртгэсэн огноог мэдэгдэх болно.

Хүлээн авсан гомдолд дүн шинжилгээ хийх

Гомдлыг холбогдох ажилтнууд бүртгэн, хянасны дараа гомдлын маягтыг бүрэн дүүрэн бөглөсөн эсэхийг хянуулахаар ажил гүйцэтгэгч компанийн холбогдох захирлууд/багуудад хүргүүлнэ. Энэхүү хяналтын ажилд ажилтнууд болон дээд удирдлагууд хамрагдах ба урьдчилсан зөвлөмжийн хүрээнд МСК-ын Байгаль орчны удирдамж Жендэр ба нүүлгэн шилжүүлэлт, Эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлого болон туршлага, өнөөгийн асуудал, цаашид гарч болох үр дүнг бүгдийг нь харгалзан үзнэ.

4.5.2 Гомдол саналд хариу өгөх

Ажил гүйцэтгэгч компани гомдол гаргагчид өргөдөл гомдлын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор тухайн гомдлыг шийдвэрлэхэд шаардлагатай авах алхмыг багтаасан албан бичгийг хариу болгон хүргүүлэх ёстой.

¹⁰ Нийгэм, жендэрийн багийн захирал нь зөрчил маргааныг шийдвэрлэх уламжлалт механизмыг хэр зэрэг ашиглаж байгааг анхааралтай авч үзээд энэ арга нь тосгоны эмэгтэйчүүд, уугуул иргэд болон бусад эмзэг бүлгийн эмэгтэйчүүдэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхад анхаарах ёстой ба шүүхийн албан бус тогтолцоо нь эмэгтэйчүүд болон бусад эмзэг бүлгийн хүмүүст шударга ёсны хүртээмжтэй байхад туслах эсэхийг нарийвчлан үнэлэх хэрэгтэй.

2..1.1.1.3 Гомдол гаргагчид хариу хүргүүлэх

Гомдол гаргагчид тухайн гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тайлбарласан тайлбар бүхий хариуг амаар болон бичгээр хүргүүлнэ. Гомдол гаргагч нь шийдвэрийг албан ёсоор хүлээж авбал гомдлын хариуг бөглөх маягтад гомдол гаргагчийн гарын үсгийг зуруулж баримтжуулна. Энэ тохиолдолд гомдлын хариу өгөх маягтыг бүртгүүлэхээр холбогдох хэлтэст хүргүүлнэ. Хэрэв гомдол гаргагч нь гомдлын шийдвэрийг албан ёсоор хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал гомдол барагдуулах процесс нь дараагийн алхамд шилжинэ.

2..1.1.1.4 Гомдол гаргагч нь хариу шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах

Хэрэв гомдол гаргагч нь албан ёсны хариу шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал, татгалзаж буй шалтгааныг судлах, гомдлыг шийдвэрлэхээр гуравдагч этгээдийг татан оролцуулах, олон нийттэй зөвлөлдөх гэх мэт бусад арга зам байж болох эсэхийг тодорхойлохоор гомдлыг дараагийн буюу гомдлыг хянах хоёр дахь шатанд шилжүүлэх болно. Энэхүү хоёр дахь хяналтын явцад 30 хоногийн дотор албан ёсны бичгээр хариу өгнө, эсвэл ажил гүйцэтгэгч компанийн төлөөлөл нь гомдол гаргагчтай уулзалт хийхээр шийдвэрлэх боломжтой. Уулзалтад оролцсон хүн бүрийн гарын үсэг бүхий албан ёсны тэмдэглэл хөтлөх бөгөөд хэрэв ажил гүйцэтгэгч компани болон гомдол гаргагч нар хоорондын тохиролцоонд хүрсэн бол уг тохиролцсон гэрээг гомдол гаргагчийн гарын үсэгтэйгээр гомдлын маягтад хавсаргана. Хэрэв тохиролцоонд хүрч чадаагүй бол гомдол гаргагч нь дараагийн бусад арга замыг (захиргааны болон хууль эрхзүйн гэх мэт) сонгож болно.

4.5.3 Гомдол, саналыг хаах

Ажил гүйцэтгэгч компани гомдол, саналыг хаахдаа өргөдөл гомдлын талаарх дэлгэрэнгүй бүртгэлийг бүрдүүлж, гомдлын хариуг бөглөх маягтад заасан арга хэмжээний дагуу хэрхэн шийдвэрлэсэн зэрэг нотлох баримтыг цуглуулах ёстой. Албан бичгээр өгсөн хариу нь тухайн гомдлыг барагдуулахад шаардлагатай арга хэмжээг дурдсан болон шийдвэрлэсэн тохиолдолд гомдол гаргагч нь гомдлын хариуг бөглөх маягт дээр гарын үсэг зурснаар тухайн гомдлыг барагдуулсан болохыг баталгаажуулна. Ажил гүйцэтгэгч нь бүх үйлдлийг бүртгэн хөтөлж гомдол гаргагчийн гарын үсэг зурсан огноог гомдлын бүртгэлд тэмдэглэнэ. Гомдол шийдвэрлэхтэй холбоотой ямар нэгэн тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд Гомдлын маягтад гомдлыг хаах үндэслэлийг багтаан гүйцэтгэгч гарын үсэг зурж, шийдвэрийг гомдлын бүртгэлд бүртгэнэ.

4.6 Гамшгийн болон онцгой байдлын үед авах арга хэмжээ

Хариуцагч этгээд: Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал, ПМС болон гэрээт компани

Онцгой байдал, гамшгийн үед бэлэн байх арга хэмжээний төлөвлөгөө (ОБГТ) нь төслийг хэрэгжүүлэх бүхий л үе шатанд гарч болзошгүй аюул, осол, онцгой нөхцөл байдлыг тодорхойлж, хөтөлбөрийг үе шаттай шалгаж шаардлагатай бол шинэчлэх, өөрчлөгдөж буй нөхцөл байдлыг тусгасан болно.

Энэхүү төлөвлөгөө нь Монголын МСС-гийн ажилтан, зөвлөх болон гэрээт байгууллагуудад онцгой байдлын үеийн төлөвлөлт, бэлэн байдлын журам зэргийг боловсруулахад ерөнхий зааварчилгаа өгөх зорилготой юм. Төслийн зураг төсөл боловсруулж буй зөвлөх нь төслийн үйл ажиллагаанд учирч буй эрсдэл, нөлөөллийг тооцон Онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна (БОННУ тайланд хавсарган ирүүлнэ). Түүнчлэн, барилгын гэрээт гүйцэтгэгчийг байгаль орчин, нийгмийн шаардлагыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавихад Хяналтын зөвлөхөд удирдамж болох баримт бичиг юм. ОБГТ-г хавсралт 4-с үзнэ үү.

Энэ нь төслийг хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй гол аюулыг тодорхойлж, онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний талаар онцолсон загвар төлөвлөгөө юм.

4.7 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон Хог хаягдлын менежмент

Хариуцагч этгээд: БОНГ баг нь ПМС болон гэрээлэгч нарын туслалцаатай боловсруулж, хэрэгжүүлнэ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон хог хаягдлын менежментийн (ХАБЭА, ХХМ) хүрээ нь Компактын санхүүжилтээр хэрэгжих төслүүдийн барилгын ажлын болон нөхөн сэргээлтийн үе шатанд гарах хог хаягдал болон аюул ослыг бууруулах зорилго бүхий Монголын МСС-гийн Байгаль орчин, нийгмийн системийн бүрэлдэхүүн хэсэг юм. Энэхүү менежментийн хүрээ нь Компактыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож буй Монголын МСС, түүний ажилтан, албан хаагчид, зөвлөх болон гэрээт байгууллагуудад хамаатай ба барилга угсралт, хяналтын үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг удирдах зааварчилгаа өгөх, аюул, эрсдэлийг тодорхойлох, хувийн хамгаалалтын түвшин, аюулгүй ажиллагааг тодорхойлох, хувийн хамгааллын стандарт, аюулгүй ажиллагааны заавал дагаж мөрдөх журмыг тогтоож өгөх зорилготой юм.

Ажлын байран дахь аюулгүй байдал, эрүүл ахуй

Монголын МСС нь бүхий л ажилтан албан хаагч, зөвлөхүүд, гэрээт байгууллагууд болон зочин төлөөлөгчийг эрүүл, аюулгүй ажлын байраар хангах үүрэгтэй ба төслийн оффис болон төслийн талбай дахь эрсдэлийг тооцон, аюул ослыг багасгах замаар хөдөлмөрийн осол, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Оффисын аюулгүй байдал, эрүүл ахуй

Ажлын байран дахь осол, гэмтлийн ихээхэн хувь нь оффист тохиолддог ба гол шалтгаан нь:

- Ажлын нөхцөл байдал болон хүрээлэн буй орчин (уртасгасан цагаар ажиллах, шөнийн ажил, сэтгэлийн болон бие махбодын ядаргаа гэх мэт);
- Шатах, огтлох, чимхэх гэх мэт аюул;
- Аливаа зүйлийг буруу өргөх, эд зүйлстэй буруу хэрэглэх;
- Гулсах, гишгэх, унах аюул;
- Аливаа зүйлийг үл тоомсорлож, хайхрамжгүй ханддагаас ажилчид аюулд орох;
- Зохион байгуулалт муутай, оффис нь гэрэлгүй, бохир байх гэх мэт;
- Аюултай цахилгаан утас; хортой бодис (химийн, физик, биологийн)-т өртөх
- Тоглоом наргиан хийн, гэмтэх;

Монголын МСС-гийн зүгээс аюулгүй, эрүүл орчныг бүрдүүлэхийн тулд дараах урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай. Үүнд:

- Халтиргаа үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд цэвэрлэгээг маш сайн хийх;
- Аюултай зүйл, материалыг ашиглахдаа урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах;
- Таслах, цоолох болон оффис дахь аливаа техник хэрэгслийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зөв хэрэглэх зааварчилгаа өгөх;
- Хувилагч машин, богино долгионы зуух, ширээ, сандал, тавиур, шат, гишгүүр, бичгийн машин, бусад албан тасалгааны хэрэгслийг зөв ашиглах аюулгүй ажиллагааны тусгай зааварчилгааг ажилчдадаа өгөх;

Төслийн талбай дээрх аюулгүй байдал, эрүүл ахуй

Төсөл хэрэгжих талбай дээр тогтмол очиж ажлын үйл явцтай танилцаж байх нь төсөл хэрэгжүүлэх үед нэн чухал юм. Эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага нь Монголын МСС-гийн ажилтнууд, гүйцэтгэгч байгууллагууд, дэд гэрээлэгч, зочдод барилга угсралтын ажил, хяналт, шалгалт, аудитын зорилгоор төслийн талбайд зорчих үеийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах бодит заавар болох юм.

Аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Монголын МСС-гийн ажилтнууд, гүйцэтгэгч байгууллагууд, дэд гэрээлэгч, зочид нь төслийн талбайтай танилцахаар явахаас өмнө Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багаас аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, зааварчилгааны хуудсыг уншиж танилцан, гарын үсэг зурж, хүлээлгэн өгсөн байх шаардлагатай. Тус зааварчилгаанд хувь хүний хамгаалалтын эд

хэрэгслийн шаардлага, гал түймэр, аврах ажиллагаа, гарч болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээ зэргийг багтаасан болно.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шалгах хуудас

Эрүүл мэнд, аюулгүй байдлын хяналтын хуудсыг ашиглах нь барилга угсралтын болон ашиглалтын үед төслийн талбай дээрх ажлын байран дахь эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны дадлыг бэхжүүлэх, ажилтай холбоотой осол, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх чухал хэрэгсэл юм. Монголын МСС-гийн ажилтнууд төслийн талбайтай танилцах үеэр энэхүү хуудсыг ашиглах ёстой.

Хувийн бэлтгэл

Төслийн талбай руу явахдаа зорчиж буй хэн боловч гэмтэл бэртэл авах, гар хөлөө урах, хорт бодист хүрэх зэргээс зайлсхийхийн тулд биед эвтэйхэн, зузаан хувцас өмсөн (урт өмд, ханцуй), хувийн бэлтгэлээ хангах ёстой.

Барилгын ажлын үеийн төслийн талбай дээрх аюулгүй байдал

Барилгын ажил гүйцэтгэгч нь илрүүлсэн аюулыг цаг тухайд нь, үр дүнтэй шийдвэрлэх арга хэмжээг авах замаар орон нутгийн иргэд, зочид болон ажилчдаа аюулгүй, эрүүл ажлын байраар хангана. Барилгын ажлын гүйцэтгэгч нь эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэхийн өмнө эрсдэлийн үнэлгээг маш сайн хийх ёстой.

Эрсдэлийн үнэлгээ нь дараах хэсгээс бүрдэнэ:

- Аюулын шинж чанар;
- Тухайн аюул нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг тооцох (нөлөөллийн хэлбэр, хэмжээ);
- Ажилчид аюулд хэрхэн өртөж байгаа эсэх;
- Ажилчид аюулд хэр их, хэдэн удаа, хэр удаан өртөж байгаа эсэх;
- Аюул тохиолдсон байршил зэргийг тооцно.

Эрсдэлийн үнэлгээнд барилга угсралтын болон нөхөн сэргээлтийн ажил, барилгын талбай тус бүрийн байршил, нөхцөл байдал, ажилчдад шаардлагатай сургалт, мэдлэг, боломжтой хяналтын арга хэмжээ, хэлбэр зэргийг харгалзан үздэг.

Мөн барилгын ажлын гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч нар нь төслийн талбай бүрд тохирсон хог хаягдлын менежментийн төлөвлөгөө (ХХМТ), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн төлөвлөгөө (ХАБЭАМТ)-г Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) болон холбогдох хууль тогтоомж, стандартад үндэслэн боловсруулж, хэрэгжүүлнэ.

КОВИД-19 Аюулгүй байдлын төлөвлөгөө

2.2 Эрсдэл

КОВИД-19 нь агаар дуслын замаар болон аливаа биетийн гадаргуугаар дамжин халдварлах өндөр эрсдэлтэй вирус бөгөөд урьд өмнө нь үзэгдээгүй эрсдэлийг бий болгож байна. Халдвар дамжих гол зам нь агаар дахь вирус болон вирусээр бохирлогдсон гадаргууд хүрсний дараа нүд, ам хамартаа хүргэх явдал юм. Халдвараас урьдчилан сэргийлэхдээ вирусийн амьсгалын зам, салст бүрхэвч рүү орох замыг хаах зайлшгүй шаардлагатай ч халдвар нүд рүү орох эрсдэл байна. Вирус нь шинж тэмдэг илрэхээс өмнө халдварлах боломжтой ба эдгээр вирус тээгчид нь халдварын түвшинг хурдасгаж байж болзошгүй юм. Өвчний шинж тэмдэг илрээгүй хүмүүсийн дунд халдвар дамжих эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх нь чухал байгаа юм. Суурь өвчтэй (дархлаа султай, астма, чихрийн шижин, зүрхний өвчин гэх мэт) болон өндөр настай хүмүүс халдварт өртөх, ноцтой хүндрэл гарах эрсдэлтэй байна.

Монголын МСС, ПМС, зөвлөх компаниуд нь КОВИД-19 холбоотой эрсдэлийг бууруулах (боломжтой бол), зайлсхийх журам болон протокол боловсруулна.

Хэрэгжүүлэгч байгууллагын хяналт дор ажилладаг эрх бүхий хүмүүс, туслан гүйцэтгэгч, компанийн ажилтнуудад хамаарах КОВИД-19 тархалтыг багасгах зорилгоор төлөвлөгөө боловсруулна (жишээ нь барилгын ажил гүйцэтгэгчийн төлөвлөгөө нь ажилчид болон зочдод хамаарна).

Уг төлөвлөгөө нь МСК¹¹ болон Монголын хууль эрхзүйн шаардлагыг хангах (аль хатуу шаардлагыг дагах¹²) ёстой ба эрүүл мэнд, аюулгүй байдал, онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний нэг хэсэг байх юм.

Ажилтнууд, албан хаагч болон ард иргэдийг хамгаалах хамгийн сайн арга бол вирусийн халдвар авахаас урьдчилан сэргийлэх явдал юм. Халдвар авахаас бүрэн урьдчилан сэргийлэх боломжгүй тохиолдолд хамгийн үр дүнтэйгээс бага үр дүн хүртэлх хянах шатлалыг дагаж мөрдөх ёстой. Үүнд:

- Аюулыг арилгах. Аюулыг арилгахдаа шаардлагагүй уулзалтыг цуцлах, уулзалт зохион байгуулахдаа онлайн хэрэгслийг ашиглах явдал нь аюулыг бүрэн устгаж буй жишээ юм.
- Аюулаас тусгаарлах инженерийн арга хэмжээ. Олон нийтийг ажлын талбараас (хашаа, нэвтрэх аюулгүй байдал) тусгаарлах, зөөврийн болон химийн жорлонг төслийн талбайд ашиглах зэрэг нь ажилчид нийтийн ариун цэврийн өрөө ашиглах шаардлагагүй болгодог.
- Захиргааны арга хэмжээ. Аюулыг бууруулах ажлын арга барилыг өөрчлөх, бодлого, журам болон сургалт багтана. Эдгээр нь ихэвчлэн хувь хүний үйлдэл дээр тулгуурладаг учир дээр дурдсан инженерийн арга хэмжээг бодвол үр дүн бага байдаг. Харин хувь хүний хамгаалах хэрэгслийг ашиглаж байгаа тохиолдолд үр дүнтэй байна.
- Аюулгүй ажлын байр нь захиргааны арга хэмжээний нэг төрөл бөгөөд хувь хүн халдвар авах эрсдэлийн эрчим, хугацаа болон давтамжийг бууруулах боломжтой юм. Жишээ нь хувийн ариун цэвэр сахих, зай барих зэргээр КОВИД-19-ийн эрсдэлээс хамгаалах боломжтой.
- Хувийн хамгаалах хэрэгсэл өмссөнөөр хувь хүнийг эрсдэлээс хамгаалах юм. Дээр дурдсан инженерийн, захиргааны арга хэмжээ болон аюулгүй ажлын байр нь эрсдэлийг бууруулах хамгийн үр дүнтэй арга хэмжээ бөгөөд хүмүүс хоорондын зай барих нь вирусийн халдварыг бууруулж чадахгүй тул хувийн хамгаалах хэрэгслийг өргөнөөр хэрэглэх нь халдварын эрсдэлийг зогсоох боломжит арга юм.

Цаашид МСК нь КОВИД-19 аюулгүй ажиллагааны төлөвлөгөөний талаарх нэмэлт зааварчилгааг тусдаа баримт бичиг болгон боловсруулна.

Хог хаягдлын менежмент

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал нь хүний эрүүл мэнд, бүс нутгийн дэд бүтэц, гүний ус, хөрс, гадаргын ус зэрэг байгаль экологид сөргөөр нөлөөлөхөөс зайлсхийх үүднээс хог хаягдлыг ухаалгаар зохицуулах шаардлага тулгардаг. Энэхүү хог хаягдлын менежмент нь төслийн барилга угсралтын үед үүсэх хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг хамрах бөгөөд төслийн бүх Гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч байгууллагуудад хамаарна. Мөн төслийн барилга угсралтын болон барилгын дараах нөхөн


¹¹ ОУСК-ын ГС-2 ба 4-т ажилтнууд болон олон нийтийг хамгаалах эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагуудыг багтаасан байдаг.

¹² Гэрээт компаниуд нь энэхүү **төлөвлөгөөнд** хамгийн наад захын эрсдэлийг бууруулах арга хэмжээг тусгах ба засгийн газраас гаргасан удирдамж, гэрээсээ ажиллах зааварчилгаа болон тухайн нөхцөл байдлаас шалтгаалан төлөвлөгөөнд **тусгагдах арга хэмжээ** нь эдгээр хамгийн бага шаардлагуудаас илүү байж болох юм.

сэргээлтийн явцад болон төсөлтэй холбоотой бусад үйл ажиллагаанаас гарсан бүх хог хаягдал (аюултай) материалыг зохих журмаар цуглуулах, хадгалах, тээвэрлэх, хаяхыг хариуцна.

Хог хаягдлын шатлал

Үр дүнтэй хог хаягдлын менежментийг бий болгохын тулд төслийн зүгээс хог хаягдлыг багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах болон устгах дараалал бүхий “хог хаягдлын менежментийн шатлал” (Зураг 2-ыг үзэх)-ыг хэрэгжүүлэх шаардлагатай. Барилга угсралтын гэрээт ажил гүйцэтгэгч байгууллагууд энэхүү шатлалыг дагаж мөрдөх ёстой бөгөөд хог хаягдлыг багасгах ажлыг энэ аргаар хэрэгжүүлнэ.



Зураг 2: Хог хаягдлын менежментийн шатлал

2.2.1.1.1 Аюултай барилгын хог хаягдал

Барилгын ажил гүйцэтгэгчид нь химийн бүтээгдэхүүн, будаг, уусгагч зэргийг агуулсан аюултай, барилгын хог хаягдлыг зохих журмын дагуу ялгаж ангилах, цуглуулах, устгах үүрэг хүлээнэ. Хэрэв үүссэн хог хаягдлыг аюултай гэж үзвэл (шөрмөсөн чулуу агуулсан материал, хар тугалгатай будаг, полихлорт бифенил, мөнгөн ус бүхий өдрийн гэрэл, хар тос агуулсан материал) тухайн хог хаягдлыг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн, байгаль орчинд ээлтэй, аюулгүйгээр устгах арга хэмжээ авна.

Аюултай хог хаягдал эсвэл аюултай материалыг цуглуулах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цуглуулж тусад нь арга хэмжээ авна. Аюултай хог хаягдлыг төслийн талбай дээр шатаахгүй ба зөвхөн зохих тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслээр мэргэшсэн ажилтнууд зөөж, шилжүүлнэ. Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулах байршлыг найдвартай, “Аюултай хог хаягдал” гэж тэмдэглэж, хог хаягдлын төрөл, хогоо саванд хийсэн огноо зэргийг нарийвчлан тэмдэглэж, ус үл нэвтрэх гадаргуу дээр байрлуулж, зохих ёсоор нь хадгалах ёстой.

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ1) хийгдэж дууссаны дараа Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) боловсруулах ба барилгын ажлыг гүйцэтгэх гэрээт байгууллагууд болон туслан гүйцэтгэгч байгууллагуудад төслийн талбайд зориулсан ХХМТ болон ХАБЭАМТ-г боловсруулж хэрэгжүүлэхэд чухал баримт бичиг болно.

4.8 Хаалтын төлөвлөгөө

Хариуцагч этгээд: Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал, Монголын МСС-гийн программын баг болон ПМС

“Хаалтын төлөвлөгөө”-г 2025 оны сүүлээр боловсруулж эхлэх ба Компакт хэрэгжүүлэх явцад бүрэн боловсруулж дуусна.

Монголын МСС нь Байгаль орчин, нийгэм, жендэр, аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг тусган хэрэгжүүлж буй төслүүдийн цаашдын тогтвортой байдлыг хангах зорилгоор хаалтын төлөвлөгөө боловсруулна.

Энэ үе шатанд Монголын МСС-гийн зүгээс Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны асуудал, болон аливаа бусад асуудлыг Компакт гэрээ дуусахаас өмнө (ихэвчлэн Компакт гэрээний эцсийн өдрөөс 120 хоногийн дараа) шийдвэрлэнэ.

Монголын МСС-гийн зүгээс Компакт гэрээг хаах хугацаанд дараах ажлуудыг хийх болно. Үүнд:

- **Төслүүдийг тодорхойлох** (ерөнхийдөө барилгын ажлын гэрээгээр тодорхойлсон дэд төслүүд);
- **Төсөл бүрийн эзэмшигчийг тодорхойлох:** “Эзэмшигч” нь хэрэгжүүлэгч байгууллага бөгөөд төсөл бүрийн цаашдын хэрэгжилт, үйл ажиллагааг хариуцаж ажиллах болно; Монголын МСС-гийн зүгээс эзэмшигч бүрийн хувьд хаалтын хугацаа дууссаны дараа үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх чадвар, нөөцийг тодорхойлох чадавхын үнэлгээг явуулна; Хэрэв шаардлагатай бол хаах хугацаа дуусахаас өмнө Монголын МСС нь эзэмшигчид шаардлагатай чадавхыг бий болгох, сургалт явуулах;
- **Байгаль орчин, нийгэм, нүүлгэн шилжүүлэлт, аюулгүй байдал, эрүүл ахуйн аудит оруулах:** Монголын МСС-гийн зүгээс Компакт гэрээний хэрэгжилтийн байгаль орчин, нийгэм, нүүлгэн шилжүүлэх, эрүүл ахуй, аюулгүй байдлын асуудлыг хамарсан аудит хийх ба Компакт гэрээний хугацаа дуусахаас 45 хоногийн өмнө байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой асуудлыг Гүйцэтгэгчээс ирүүлсэн тогтмол тайлангаас, мөн төслийн талбайгаас цуглуулсан мэдээлэл дээр үндэслэн тодорхойлно. Монголын МСС-гийн Аудитын төлөвлөгөөнд аудит хийх талаар тодорхой мэдээлэл оруулсан байна.
- **Хүлээлгэн өгөх:** Монголын МСС нь хүлээлгэн өгөх үйл ажиллагаанд оролцох ба баримтжуулна.
- **Хаалтын үйл ажиллагааг зохион байгуулах:** Хаалтын ажиллагаанд төслийн эзэмшигчээс эхлээд бүхий л талууд, орон нутгийн засаг захиргааны төлөөлөл, нутгийн иргэд, төслийн нөлөөлөлд өртсөн иргэд, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийнхэн оролцоно.
- **Ялгаатай байдлын анализ буюу дүгнэлт хийх:** Засгийн газар болон бусад байгууллагууд үргэлжлүүлэн хийхийг эсвэл хамтрахыг хүсэж байгаа Компакттай холбоотой салбарыг тодорхойлох, Хаалтын үйл ажиллагааны тайланд орсон Хандивлагчид, олон улсын байгууллагууд ба/эсвэл засгийн газрын үйл ажиллагааны талаарх анхны дүгнэлтийг бэлтгэх, Бүхий л үйл ажиллагаа хэрхэн хамтарч байгаа, эсвэл хандлага, үр дүн нь давхцаж байгаа тухай харуулах “харилцааны матриц” ба “ялгаатай байдлын дүн шинжилгээ”-г боловсруулж, Засгийн газар болон хандивлагчдын үйл ажиллагааг Компакттай холбоотой салбаруудтай цаашид уялдуулах зөвлөмж танилцуулах;
- **Иргэний өргөдөл гомдлыг бууруулах журмыг боловсронгуй болгож, гэрээ болон Компакт гэрээг нарийвчлан боловсруулж, цаашид Компакттай холбоотой гомдол, маргааныг шийдвэрлэх боломжтой болно.** Энэхүү журам нь Монголын МСС-гийн төслүүдтэй холбоотой аливаа талуудын гаргасан бүх санал, гомдлыг авч үздэг. Монголын МСС-гийн оролцогч талуудын оролцоо, зөвлөлдөх төлөвлөгөө, өргөдөл гомдлыг бууруулах механизм нь тодорхой журмын талаар дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулж байна.
- **Гомдол барагдуулах механизмыг боловсронгуй болгох:** Ирээдүйд гарч болзошгүй Компакттай холбоотой гомдол, маргааныг шийдвэрлэх зорилго бүхий журам нь Монголын МСС-гийн төслүүдтэй холбоотой аливаа талуудын гаргасан

захирлууд, зөвлөхүүд ба/эсвэл гүйцэтгэгчид ОУСК-ын ГС, МСК-ын Байгаль орчны удирдамж, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу энэхүү тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлнэ. Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн баг нь “Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө” боловсруулж, Байгаль орчин болон нүүлгэн шилжүүлэлтийн шаардлагуудыг тендерийн баримт бичигт тусган, БОННУ1, БОННУ2, БОНМТ нь МСК-ын Байгаль орчны удирдамж, ОУСК-ын ГС, Монголын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянах үүрэгтэй. Мөн НШТ боловсруулах, хэрэгжүүлэх, Компакт гэрээг хэрэгжүүлэхэд Монгол улсын Засгийн газрын хүлээх нэмэлт үүргийн хэрэгжилтэд хувь нэмрээ оруулахад идэвхи зүтгэлтэй оролцож, төслийн талбай дээр ажиллах үед Монголын МСС-гийн ажилтнууд болон зочдод хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах хяналт тавина.

5.2 Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн оролцоо

Монголын МСС-гийн Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн баг Компактын хүрээнд хэрэгжих төслүүдийн багуудтай нягт хамтран ажиллаж, заавар зөвлөгөөг хүргэх болно.

5.2.1 Төслийн үйл ажиллагаа

Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн баг нь БОННУ, БОНМТ, ХАБЭА-ны зааварчилгаа боловсруулах, хэрэгжүүлэх, Бохирдуулагч нь төлөх зарчим бүхий Засгийн газрын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, ПМС, АЕКОМ болон бусад гэрээт байгууллагууд, оролцогч талуудтай хамтын ажиллагаатай байх зэрэг Компактын бүхий л үйл ажиллагаанд оролцоно. Мөн худалдан авах ажиллагааны материалд байгаль орчин, нийгмийн болон нүүлгэн шилжүүлэлтийн шаардлагуудыг оруулан, Хаягдал ус дахин боловсруулах төслийн үйл ажиллагааны захиалагчийн шаардлагыг хянах, Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн дэд үйл ажиллагаанууд зэрэг төслийн үйл ажиллагааг эхлэхээс хаах хүртэл төлөвлөх, гүйцэтгэх, хянах бүхий л үе шатанд идэвхтэй оролцоно.

5.3 Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн баг

Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал нь байгууллагын удирдлага болон мэргэжилтнүүдийн туслалцаатай ажилладаг ба шаардлагатай тохиолдолд богино хугацааны зөвлөхийн дэмжлэг авах боломжтой юм.

БОНМС-ийн ажлыг хэрэгжүүлэх Монголын МСС-гийн гурван гол ажилтан бол Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн багийн захирал, Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын мэргэжилтэн, Нүүлгэн шилжүүлэлт, нийгмийн мэргэжилтэн юм. БОНМС-ийн хэрэгжилтэд Монголын МСС-гийн бүх ажилтан, албан хаагчдыг тал бүрийн хүчин чадлаар оролцуулах шаардлагатай болно.

2.2.1.1.2 Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал:

Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал нь Монголын МСС-гийн БОНУТ-г удирдан хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд төслийн хувьд нөхцөл байдал өөрчлөгдөхтэй холбоотой хяналт, шалгалт, шинэчлэлт, өөрчлөлт хийхэд оролцох үүрэгтэй. Мөн Компакт гэрээний гүйцэтгэлийг зохих ёсоор биелүүлэхийн тулд шаардлагатай үед БОХАБЭА болон Нүүлгэн шилжүүлэлт, нийгмийн мэргэжилтнүүдэд удирдлагын дэмжлэг үзүүлнэ.

Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал (эсвэл томилсон ажилтан) нь энэхүү БОНМС-ийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлэхийн тулд Монголын МСС-гийн удирдлагатай хамтран ажиллана. Үүний адилаар ПМС болон гэрээлэгч нар Байгаль орчин болон нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, боловсон хүчний нөөцөө хуваарилах шаардлагатай болно (ОУСК-ын үйл ажиллагааны стандартад нийцсэн БОНМТ, НШТ, бусад шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөө).

Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн: БОХАБЭА мэргэжилтэн нь төслийн үйл ажиллагаанууд БОНУТ-ний дагуу хэрэгжиж байгаа эсэхийг хянах үүрэгтэй.

Төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийлгэх, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежментийн төлөвлөгөө, байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүрэгтэй. Түүнээс гадна, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчинтой холбоотой, баримт бичгийг боловсруулан хөтөлж, төслийн баг болон холбогдох талуудад шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх, тайлагнах үүрэгтэй.

БОХАБЭА мэргэжилтэн нь орон нутгийн болон төрийн захиргааны холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах, оролцогч талуудад төслийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, нийгмийн асуудлаар хангалттай, хүртээмжтэй мэдээллээр хангаж, тэдний оролцоог дэмжин ажиллана.

Нүүлгэн шилжүүлэлт, нийгмийн мэргэжилтэн: Нүүлгэн шилжүүлэлт, нийгмийн мэргэжилтэн нь төсөлтэй холбоотой нүүлгэн шилжүүлэлт, газар чөлөөлөх асуудлыг зохицуулах, НШТ-г боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцдаг. Түүнчлэн Нүүлгэн шилжүүлэлт, нийгмийн мэргэжилтэн нь олон нийтийн хэлэлцүүлэг, оролцогч талуудын оролцоог хангах ажлыг зохион байгуулж, оролцогч талуудад санал болгож буй төсөл, түүний нөлөөллийн талаар хангалттай, хүртээмжтэй мэдээлэл өгөх, тэдний оролцоог дэмжиж ажиллана.

Монголын МСС-гийн зүгээс энэхүү Байгаль орчин, нийгмийн менежментийн системд нийцүүлэн байгаль орчны болон нийгмийн чиглэлээр мэргэшсэн зөвлөхүүд, жендэрийн тэгш эрхийг хангах асуудал хариуцсан зөвлөхүүдийг томилох ба зөвлөхүүдийн ажлын хамрах хүрээ байгаль орчны болон нийгмийн асуудлын нарийн төвөгтэй судалгааг хамрах юм.

Зөвлөхүүд нь төслийн хөрөнгө оруулагчдын оруулсан байгаль орчны баримт бичгийг үнэлэх, хяналтын хуудас бөглөх, төслийн талбайтай танилцах, байгаль орчны гүйцэтгэлийг хянах, ялангуяа байгаль орчин, нийгмийн ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй төслүүдийн байгаль орчны гүйцэтгэлийг хянах үүрэгтэй.

5.4 Сургалт

2.2.1.1.3 Хариуцах этгээд: Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн баг болон Зөвлөхүүд

Энэхүү Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг чадварыг эзэмшиж, хадгалахын тулд Монголын МСС-гаас бүх ажилчдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулна. Энэхүү бодлогын баримт бичгийг хавсралтын хамтаар Монголын МСС-гийн менежментийн багт сургалтын материал болгон ашиглаж сургалтыг танхимын, ажлын байран дээр болон семинар хэлбэрээр явуулна.

Ажилчдын мэдлэг, чадварын зохих түвшинг хангахын тулд сургалтуудыг үе үе зохион байгуулж, шинэ ажилчдад байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн талаар мэдээлэл өгч байх ёстой. Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн гишүүд нь МСК-ын урилгаар байгаль орчин, нийгмийн хамгааллын чиглэлээр зохион байгуулагдах сургалтад хамрагдах ба энэ чиглэлийн олон улсын хурал, семинар ялангуяа ОУСК-ын сургалтад хамрагдах нь Компакт гэрээний гүйцэтгэл, Байгаль орчин, нийгмийн менежментийн системийг хэрэгжүүлэхэд туслах ур чадварын түвшинг дээшлүүлэх боломж олгох юм. Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал нь Монголын МСС-гийн Гүйцэтгэх захиралтай хамтарч ажиллах бөгөөд оролцох хурлыг тодорхойлох, шаардлагатай төсвийг бүрдүүлэх юм.

5.4.1 Ажилчдад зориулсан байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт

2.2.1.1.4 Хариуцах этгээд: ПМС болон Зөвлөхүүд

Байгаль орчин, нийгмийн удирдлага, эрүүл ахуй, аюулгүй байдлын талаарх сургалт, чиглэлийг Барилга угсралтын ажилд оролцох бүх ажилтнуудад барилгын ажил эхлэхээс өмнө төслийн талбай дээр өгөх болно. Энэхүү сургалтыг Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч эсвэл Хяналтын

зөвлөх (Байгаль орчин, нийгмийн менежер/ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежер, эсвэл сургалт явуулах чиглэлээр мэргэшсэн байгууллагаас) зохион байгуулах ба Монголын МСС-гийн болон бусад төлөөлөгчид оролцоход нээлттэй байдлаар зохион байгуулна.

Сургалтын материалыг сургалт явуулахаас өмнө Хяналтын зөвлөхөд хянуулж, батлуулахаар илгээнэ (Монголын МСС-гийн зүгээс сургалтын материалыг Хяналтын зөвлөхөөс зөвшөөрөл авахаас өмнө хянуулах хүсэлт гаргаж болно). Ерөнхий танхимын сургалтаас гадна машин, тоног төхөөрөмжтэй холбоотой, аюултай материал, хог хаягдалтай ажилладаг ажилчид, жолооч нар, хязгаарлагдмал орон зайд ажилладаг хүмүүст зориулсан гэх мэт тусгай сургалтыг бүлэгчлэн зохион байгуулна. Түүнээс гадна төслийн талбай дээрх зааварчилгааг барилгын ажил гүйцэтгэгч компанийн талбайн хяналтын ажилтнууд төлөвлөсөн ажлын онцлогоос хамааран өдөр бүр өгөх үүрэгтэй. Хяналтын зөвлөх нь сургалтын төлөвлөгөөг Монголын МСС-д танилцуулахаар бэлтгэж боловсруулна.

5.4.2 Суурилуулсан тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний талаар үзүүлэх сургалт

Хариуцах этгээд: ПМС болон гэрээт компаниуд

Барилга байгууламж, дэд бүтцийн ашиглалт, засвар үйлчилгээ хариуцсан захирал, техникийн ажилтнууд Барилгын ажил гүйцэтгэгч байгууллагаас зохион байгуулах барилгын талбай дээрх үзүүлэн, сургалтад оролцоно. Үзүүлэх сургалт нь тоног төхөөрөмжийг хэрхэн ажиллуулах, суурилуулсан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний хуваарь, тоног төхөөрөмжийг ажиллуулахаар хүлээгдэж буй зардал, ашиглалт, засвар үйлчилгээний удирдамжийн шаардлагын тайлбар зэргийг багтаасан сэдвүүдийг хамарна.

МОНИТОРИНГ ҮНЭЛГЭЭ ХИЙХ

6.1 Байгаль орчин, нийгмийн шаардлагын нийцлийг шалгах

Монголын МСС-гийн зүгээс өөрийн төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэл тухайлбал МСК болон Монгол Улсын талаас тавигдах шаардлага, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн талаар тайлагнах үүрэгтэй.

Байгаль орчин, нийгмийн хяналт үнэлгээ хийх, тайлагнах нь байгаль орчин, нийгмийн менежментийн маш чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Төслийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны үе шатанд байгаль орчны болон нийгмийн төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний үр нөлөөг шалгадаг ба “Хяналт, үнэлгээ хийх, тайлагнах төлөвлөгөө”-нд хяналт хийхэд шаардагдах үзүүлэлтүүд, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хяналт шинжилгээний үйл ажиллагааны байршил, хугацаа, давтамж зэргийг тодорхойлно. Хяналт буюу мониторинг үнэлгээ хийх мэргэжилтэн/туслан гүйцэтгэгч нь гэрээний шаардлагын дагуу байгаль орчин, нийгмийн төлөвлөгөө боловсруулж, шаардлагатай үед шинэчлэн боловсруулж, зохих ёсоор хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэнэ.

6.2 Байгаль орчин, нийгмийн мониторинг хийж гүйцэтгэх этгээд

Барилгын ажил гүйцэтгэгч/туслан гүйцэтгэгч нь холбогдох ажилтнуудаар дамжуулан (Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан захирал, БОХАБЭА мэргэжилтэн, НШН мэргэжилтэн) Байгаль орчин, нийгмийн холбогдох зааварчилгаа, хууль тогтоомж, БОНМС, БОНМХ, ХАБЭАМТ, ХХМТ, НШТ-нд тодорхойлсон байгаль орчин, нийгмийн шаардлагыг дагаж мөрдөх дотоод хяналтын журам/системийг хэрэгжүүлэх, Компакт гэрээний бүх төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг цаг тухайд нь биелүүлэх үүрэгтэй.

ПМС нь байгаль орчны болон нийгмийн баримт бичгүүдэд (БОНМХ-р тодорхойлсон төлөвлөгөө, журам, ялангуяа төслийн талбайн БОНМТ) тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг цаг тухайд нь, зохих ёсоор биелүүлж байгаа эсэхэд өдөр тутмын, төслийн талбай дээрх хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэх үүрэгтэй. Зөвлөхүүд нь урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг үр нөлөөтэй байгааг баталгаажуулах зорилго бүхий “Байгаль орчин, аюулгүй байдал, эрүүл ахуйн, хяналт шинжилгээний хөтөлбөр”-ийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

ПМС нь барилгын ажлын бүх үе шатанд байгаль орчин, нийгмийн хяналт шинжилгээг явуулах ба үүнд дотоодын хууль тогтоомж, ОУСК-ын ГС, БОНМТ, төслийн талбайн ХАБЭАТ, ХХМТ-ний шаардлагыг дагаж мөрдөж буйг шалгах үүрэгтэй.

Монголын МСС-гийн Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн болон Нийгэм, жендэрийн багууд нь төсөл хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэж байгаа аливаа барилга угсралт, ашиглалтын үйл ажиллагаанд МСК-ын удирдамж, ОУСК-ын ГС, Монгол Улсын хууль тогтоомжид заасан байгаль орчин, нийгмийн шаардлагад нийцүүлэн хяналт тавина. Хяналтын үйл ажиллагааны давтамж нь төслийн үйл ажиллагааны онцлогоос хамаарна.

МСК нь хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх үе шатанд боловсруулсан байгаль орчны болон нийгмийн хяналт үнэлгээ, явцын тайланг шалгаж, цаг тухайд нь зөвшөөрөл өгөх үүрэгтэй.

6.3 Тайлагнах шаардлага

Барилгын ажил гүйцэтгэгч нь төслийн талбайн БОНМТ болон бусад холбогдох баримт бичгийг боловсруулж, Хяналтын зөвлөх рүү батлуулахаар илгээх ба мөн сургалтын үйл ажиллагаа, ажиглагдсан осол, эртний олдворын талаар тайлагнах үүрэгтэй. Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан “Сар бүрийн явцын тайлан”-г Хяналтын зөвлөхөд хянуулж, батлуулахаар хүргүүлэх ёстой.

Хяналтын зөвлөх нь барилгын ажил гүйцэтгэгчийн боловсруулсан бүх тайланг нягтлан шалгаж, холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвшөөрөл олгохоос өмнө гарын үсэг зурж баталгаажуулна. Хяналтын зөвлөх нь тайлангийн хугацаанд хийсэн байгаль орчны болон нийгмийн үйл ажиллагааны хураангуй, талбайн хяналт шалгалт, баримт бичиг, тайланг нарийвчлан хянасан зэрэг явцын тайланг Монголын МСС-д сар бүр боловсруулан, хүлээлгэн өгч байх болно.

6.4 МСК болон Монголын МСС-гийн удирдлагад хагас жилээр болон жилийн эцсээр тайлагнах

Хариуцагч этгээд: Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал

Монголын МСС-гийн зүгээс Байгаль орчны болон нийгмийн үйл ажиллагааны хяналт шинжилгээ, тайлангийн үр дүнг нэгтгэн улирлын тайланг Удирдах зөвлөл болон МСК-д танилцуулна. Эдгээр тайлангууд дараах агуулгаас бүрдэнэ. Үүнд:

а. Дээрх хэсэгт дурдсан тайлант хугацааны байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн тойм;

б. Байгаль орчин, нийгмийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний хуудас;

в. БОНУТ нийцээгүй залруулах арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй тайлбар

Монголын МСС-гаас жил бүр “Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа”-ны тайланг нарийвчлан боловсруулах ба хураангуйд нь МСК-ын санхүүжилтээр жилийн туршид хэрэгжүүлсэн бүх төслийг хамруулж, тэдгээрийн байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдал, БОНМС болон удирдлагын хүрээтэй нийцэж буй эсэхийг үндэслэн үнэлгээг багтаана.

БОНМС-ИЙГ ШИНЭЧЛЭН САЙЖРУУЛАХ

Хариуцагч этгээд: Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн багийн захирал болон удирдлагын баг

Нөхцөл байдал өөрчлөгдөх, хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлт, төсөл хэрэгжих үед үүсч болзошгүй асуудлыг шийдвэрлэх шаардлагатай ба үүний тулд БОНМС-ийн бодлогын баримт бичгийг шинэчилж, сайжруулах шаардлагатай болно үзэж байна. Удирдлагын зүгээс жилийн эцсийн тайланд орсон мэдээллийг ашиглан шаардлагатай нэмэлт өөрчлөлт, шинэчлэлт хийхийг шийдэж, БОНН-ийн багийг энэхүү удирдлагын системийг хэрэгжүүлэхэд чиглүүлнэ.

Хавсралт 1 – Монгол Улсын хууль тогтоомж, ОУСК-ын Гүйцэтгэлийн стандартын харьцуулалт

Хүснэгт 6: Монгол Улсын хууль тогтоомж, ОУСК-ын Гүйцэтгэлийн стандартын харьцуулах нь

Төсөл/Үйл ажиллагаа	МСК Байгаль орчны зааварчилгаа	Холбогдох стандарт	Монголын хууль тогтоомж	Хууль эрхзүйн ялгаатай байдал
Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл	А ангилал: Тухайн төсөл нь байгаль орчин, нийгэмд их хэмжээний сөрөг нөлөөг үзүүлэх боломжтой мөн эдгээр нөлөөлөл нь төслийн барилга байгууламж болон төслийн талбайгаас илүү өргөн хүрээг хамарч байгаа бол	ГС-1: Төслийн зураг төсөл боловсруулах, байгууламжийг барих, ашиглалтад оруулах үеийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл	ГС-1-Байгаль орчныг хамгаалах тухай хууль (2012) Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012) Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх А-117 аргачлал (2014) Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журам (2014), Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх журам (2013)	Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд ус, агаар, хөрс, хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, түүх соёлын өвийн асуудал зэрэг байгаль орчин, нийгмийн талын асуудлыг аль алиныг нь хамруулж авч үздэг тул олон улсын болон дотоодын тавигдах шаардлагын хувьд ялгаатай зүйл байхгүй байна.
		ГС-2: Гаднаас болон гэрээт ажилтнууд ажлын нөхцөл, ажилд авах	ГС-2-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 2008, Барилын тухай хууль (2016), Барилгын ажил захиалагчийн норм (2017), Барилгын ажлын эрүүл мэнд, аюулгүй байдлын хэм хэмжээ - БНБД 12-03-04 (2013),	
		ГС-3: Барилгын болон аюултай хог хаягдал	ГС3 Хог хаягдлын тухай хууль (2017) Усны тухай хууль (2012) Байгалийн нөөц ашиглах тухай хууль (2012), Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль (2012), Хот суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хууль (2011) ГС4-Хог хаягдлын тухай хууль 2017, Онц байдлын тухай хууль 1995, Гамшгаас хамгаалах тухай хууль 2017,	
		ГС-4: Барилгын ажлын болон ашиглалтын үеийн аюулгүй байдал, эрүүл ахуй	ГС-5 Газрын тухай хууль (2002)- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003), Газрын төлбөрийн тухай хууль (1997)- pertaining to use of state-owned land Газар чөлөөлөх, нөхөн олговор олгох журам (2018)	
		ГС-5: Газар чөлөөлөлт (түр болон урт хугацааны), нүүлгэн шилжүүлэлт		

Төсөл/Үйл ажиллагаа	МСК Байгаль орчны зааварчилгаа	Холбогдох стандарт	Монголын хууль тогтоомж	Хууль эрхзүйн ялгаатай байдал
		<p>ГС-6: Биологийн олон янз байдлыг хамгаалах</p> <p>ГС-8: Археологийн ач холбогдолтой байршил зэрэг соёлын өвд нөлөөлж болзошгүй малтлага, нуралт</p>	<p>ГС-6 Биологийн олон янз байдлын конвенц Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр 1995</p> <p>ГС-8 Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2014),</p>	
Хаягдал ус дахин боловсруулах төсөл	Б ангилал: Байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөлөл нь А ангиллын төслүүдийнхээс бага, мөн сөрөг нөлөөлөл нь тухайн төслийн талбайгаар хязгаарлагдах, зарим сөрөг нөлөөлөл нь их ч бууруулах арга хэмжээ авах боломжтой тохиолдолд	<p>ГС-1-6 болон 8</p> <p><i>ГС-7-Уугуул иргэд гүйцэтгэлийн стандартаас бусад стандарт бүрийг Хаягдал ус дахин боловсруулах төслийн хувьд харгалзан үзэх шаардлагатай юм. (БОНСС)</i></p>	Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн шаардлагыг харна уу.	Монгол Улсад өнөөгийн байдлаар дахин ашиглах цэвэрлэгдсэн усны 6734:2018 стандартаас өөр хаягдал усыг дахин ашиглах хууль эрхзүйн орчин бүрэлдээгүй байна. Хэрэглэсэн усаа дахин ашиглах ойлголт нь нийт ард иргэдийн дунд түгээмэл биш шинэ тулгам учир шинээр хууль эрхзүйг боловсруулах нөхцөл бий болох юм.
Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл	<p>В ангилал: Сөрөг нөлөөлөл төдийлөн байхгүй тохиолдолд</p> <p>МСК нь В ангиллын төслүүдэд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийхийг шаарддаггүй боловч байгаль орчин, нийгмийн нөлөөллийг сайжруулах боломжтой тодорхой хэмжээний үнэлгээ, тайлан эсвэл сургалт шаардах эрхтэй.</p>	<p>ГС-1: Энэхүү үйл ажиллагаанд институтийн шинэчлэл болон олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа багтаж байгаа ба оролцогч талуудын оролцоо маш чухал үүрэгтэй юм. Зураг төсөл болон барилгын ажил энэ төслийн үйл ажиллагаанд хамаарахгүй учраас бусад ГС төдийлөн хамааралгүй.</p> <p>ГС-2: Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд-үйл ажиллагааны хүрээнд энгийн ус түгээх байрыг «ухаалаг» буюу автомат горимд шилжүүлэх замаар шууд зардлыг бууруулах олон ажлууд хийгдэх ба УСҮГ нь ажилчдаа халахгүй байх бодлогыг тусгасан төлөвлөгөө боловсруулах</p>	Аливаа төслийн үйл ажиллагаанд олон нийтийн болон оролцогч талуудын оролцоог хангахад зориулагдсан тусгай хууль тогтоомж байдаггүй. 2012 оны Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуульд үнэлгээний үйл явцад төслийн талаарх мэдээллийг нээлттэй болгох, нөлөөллийн цар хүрээг зөвлөлдөх, болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлж, төслийн үр дүнгийн талаар бүрэн мэдээлэл авах шаардлагатай байдаг тул олон нийтийн оролцоог хангах, төслийн нөлөөлөлд өртсөн иргэд, орон нутгийн засаг захиргаанаас санал авах шаардлагатай гэж заасан байдаг.	Аливаа төслийн үйл ажиллагаанд олон нийтийн болон оролцогч талуудын оролцоог хангахад зориулагдсан тусгай хууль тогтоомж байдаггүй тул цаашид энэ талын бодлого дүрэм журмыг боловсруулах шаардлагатай.

Төсөл/Үйл ажиллагаа	МСК Байгаль орчны зааварчилгаа	Холбогдох стандарт	Монголын хууль тогтоомж	Хууль эрхзүйн ялгаатай байдал
		үүрэг хүлээсэн. Тухайн ажилчдын эрх, үүрэг, хөдөлмөрийн нөхцөлийг ГС-2-р зохицуулна.		

Хавсралт 2—Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Хүснэгт 7: Монголын МСС-гийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө			
	Үйл ажиллагаа	Үзүүлэлт	Цаг хугацаа
Гүйцэтгэлийн стандарт 1. Нийгэм, байгаль орчны эрсдэл, нөлөөллийн үнэлгээ ба удирдлага			
БОНМС	Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар баримтлах бодлого бүхий Байгаль орчин, нийгмийн менежментийн систем баримт бичгийг боловсруулж, уг системийг бий болгох	Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцооны баримт бичиг	Баримт бичгийг Монголын МСС-гийн Удирдах зөвлөлд 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлж, батлуулсан. Бодлогын баримт бичиг нь Компакт гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө батлагдах ёстой ба баримт бичгийг байнга сайжруулан шинэчлэх ажил үргэлжилж байх юм.
Эрсдэл нөлөөллийн үнэлгээ	Зураг төслийн зөвлөхийн боловсруулсан төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох үнэлгээ нь ОУСК-ын ГС, МСК-ын Байгаль орчны талаарх удирдамж, Монгол Улсын шаардлагад нийцэж буй эсэхийг хянах. Бүх төслүүдийн байгаль орчин, нийгмийн талыг төсөл хэрэгжих цаг хугацаанд буюу ашиглалтаас гарах хүртэл цаг үед нь тохируулан шинэчлэн удирдаж, хэрэгжүүлэх.	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын болон Монголын шаардлага, хууль тогтоомжид нийцүүлэн хийх БОННУ тайлан (барилгын ажлаас үүсэх төслийн талбайгаар хязгаарлагдсан, түр зуурын байгаль орчны эрсдэл гэх мэт гол эрсдэлүүдийг тодорхойлох)	БОННУ болон БОНБУ тайлан нь 2020 оны 9 дүгээр сард бэлэн болох ба уг үнэлгээний дагуу боловсруулсан БОНМТ-г барилга угсралт, ашиглалт, ашиглалтаас гарах үе шатанд хэрэгжүүлнэ.
Төслийн менежмент	Төслийн зураг төслийн үе шатанд буюу байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний явцад БОНМТ, ХАБЭАМТ, ХХМТ зэргийг барилгын ажлын багц бүрт тохируулан боловсруулж буй эсэх, нийцэлд хяналт тавих, Баримт бичгүүдийг сайжруулах зорилгоор санал өгөх, туслалцаа үзүүлэх БОНМТ-г Барилгын ажил гүйцэтгэх тендерийн баримт бичигт тусгах тул тендерт оролцогч нь уг төлөвлөгөөг үндэслэн төслийн талбайн БОНМТ боловсруулж, хэрэгжүүлнэ.	БОНМТ, ХАБЭАМТ, ХХМТ	Барилгын ажил эхлэхийн өмнө барилгын ажлын гүйцэтгэгч төслийн талбайн БОНМТ боловсруулж, барилгын ажлын шатанд хэрэгжүүлнэ.
Байгууллагын чадамж	Монголын МСС-гийн Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн баг нь төслийн байгаль орчин, нийгмийн талын асуудал, БОНУАТ-ний хэрэгжилтийг бүрэн хариуцна. Шаардлагатай байгаа сургалтыг тодорхойлж, хөтөлбөр боловсруулна (Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн журам нь бүх ажилтнууд, зочдыг бэртэл гэмтэл авах, ослоос урьдчилан сэргийлэх зорилготой) Байгаль орчин, нийгмийн асуудалд хяналт тавих, дотоод нөөцийг хуваарилах	Ус хангамжийн төслийн үйл ажиллагаанд тавигдах байгаль орчин, нийгмийн асуудлын талаар болон ажлын байрны аюулгүй байдал эрүүл ахуйн журмын танилцуулга	БОНМС-д шаардлагатай чадавхыг дээшлүүлэх сургалт нь Компакт гэрээ хэрэгжих хугацаанд үргэлжлэн явагдах үйл явц юм.

<i>Онцгой байдлын үеийн бэлтгэл</i>	Онцгой байдал, гамшгийн үед бэлэн байх арга хэмжээний төлөвлөгөө (ОБГТ) боловсруулах ГС-2 болон 4-т тусгасны дагуу Онцгой болон гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг шинэчлэх, сайжруулах	Онцгой байдлын үед бэлэн байх арга хэмжээний төлөвлөгөө	Компакт гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө боловсруулах
<i>Хяналт үнэлгээ</i>	Эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, нийгмийн хяналт шалгалтыг барилгын талбай, ажилчдын байр зэрэгт хийж гүйцэтгэх (Монголын МСС-ийн зүгээс зөвлөх, гүйцэтгэгч байгууллагуудын ажлын явцыг хянах ба ирүүлсэн тайланг хянах, төслийн талбай дээр очиж шалгах боломжтой. Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн болон жендерийн багийнхан тайлангийн үйл ажиллагаа, ахиц дэвшил, үнэн зөв эсэхийг хянах зорилгоор үе үе төслийн талбай дээр очиж ажил явдалтай биечлэн танилцаж болно.) Төслийн байгаль орчин, нийгмийн хяналт үнэлгээг Монгол Улсын хууль журамд нийцүүлэн хийж, анхны хяналт шинжилгээний тайланг гаргана. Тайлан гарсны дараа төслийн талбайд арга хэмжээ авах хяналт шалгалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох	БОНМС-ийн баримт бичгийг сайжруулан боловсруулж, байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн хяналт, тайлангийн материал боловсруулах	
<i>Талуудын оролцоог хангах</i>	Оролцогч талууд болон сонирхогч талуудын зураглалыг гаргах, сонирхогч талуудын оролцооны үйл ажиллагааг хэрхэн тусгасан “Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө” боловсруулах	Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө	Оролцогч талуудын оролцоо нь төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, ашиглалтад оруулах, ашиглалт, засварын үе шатуудад тасралтгүй явагдах ёстой.
<i>Гомдол барагдуулах механизм</i>	ГС-1-ийн дагуу хөндлөнгийн оролцогч талуудын харилцаа холбоог зохицуулах журмыг хэрэгжүүлэх, хадгалах. Нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн гомдлыг барагдуулах одоо байгаа механизмыг (ГБМ)-г ГС-1-ийн дагуу шинэчлэх.	БОНМС-д тусгасан гомдол барагдуулах механизм	ГБМ нь төслийн зураг төсөл боловсруулахаас эхлээд хэрэгжилт, ашиглалт, засвар үйлчилгээний үе шатуудад тасралтгүй үргэлжлэх процесс юм.
Гүйцэтгэлийн стандарт 2. Ажиллах хүч ба ажлын байрны нөхцөл			
<i>Ажлын байрны нөхцөл</i>	Монголын МСС нь Хүний нөөцийн бодлого, ажилд сонгон шалгаруулах журам боловсруулж хэрэгжүүлэх, ГС-2-ын дагуу ажилтнуудыг удирдан чиглүүлэх арга барилыг тодорхойлох, холбогдох шинэчлэлтийг хийх үүрэгтэй Хүний нөөцийн бодлогод ГС-2 ба Монголын хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн ажлын харилцааг удирдах арга барил, түүний дотор хөдөлмөрийн нөхцөл, гомдол барагдуулах механизмыг тусгах Зөвлөх/гэрээлэгч нь өөрсдийн хүний нөөцийн бодлогын дагуу гуравдагч этгээдээр ажиллуулж буй ажилчдыг хариуцна.	Хүний нөөцийн бодлого, журам	Монголын МСС-гийн хүний нөөцийн бодлого, журам нь төслийн зураг төсөл боловсруулахаас эхлээд хэрэгжилт, ашиглалт, засвар үйлчилгээний үе шатуудад тасралтгүй үргэлжлэх процесс юм. Энэ журам нь 2020 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн Монголын МСС-гийн УЗ-өөр батлагдсан.
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	Монголын МСС нь бүх ажилтан, албан хаагч, зочдыг гэмтэл бэртэл, ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс ‘Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн журам’ боловсруулах үүрэгтэй. Ажилчдын эрүүл, аюулгүй ажиллах нөхцөл, ажилчдын байр, замын аюулгүй байдал, аваар ослын талаар мэдээлэхтэй холбоотой бодлого, журмыг сайжруулах. Мөн эдгээр бодлого, журам нь ГС-2 болон Монгол Улсын хууль тогтоомжийн аль алиных нь шаардлагад нийцсэн байх ёстой.	Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн журам	Монголын МСС-гийн Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн журам нь төслийн зураг төсөл боловсруулахаас эхлээд хэрэгжилт, ашиглалт, засвар үйлчилгээний үе шатуудад тасралтгүй үргэлжлэх процесс юм. Энэ журмыг Компакт гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө боловсруулах ёстой.
Гүйцэтгэлийн стандарт 3. Нөөцийг үр ашигтай ашиглаж, бохирдлоос сэргийлэх			
<i>Нөөцийг үр ашигтай ашиглах</i>	БОНМС нь эрчим хүч, усны хэрэглээг багасгах зэрэг (техникийн, санхүүгийн хувьд боломжийн, зардал багатай) нөөцийг үр ашигтай ашиглах хамгийн наад захын арга хэмжээг багтаах.	Монголын МСС-гийн байгаль орчны бодлогод нөөцийг үр ашигтай ашиглах тухай орсон байх	
<i>Бохирдлоос сэргийлэх</i>	БОНМС нь бохирдлоос сэргийлэх, хог хаягдлын хүрээ, хог хаягдлын төрлийг тодорхойлж, хог хаягдлыг зайлуулах хариуцах этгээдийн үүрэг, хариуцлагыг тогтоох, хог хаягдлын шатлал, авах арга хэмжээг багтаах.	Монголын МСС-гийн байгаль орчны бодлогод бохирдлоос сэргийлэх тухай орсон байх	

	Монголын МСС-гийн байгаль орчны бодлого нь оршин суугчдын эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөг тооцоолох, бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг гэрээт байгууллагууд төслийн менежментийн төлөвлөгөөнд тусгаж буй эсэхэд хяналт тавих.		
Гүйцэтгэлийн стандарт 4. Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал			
Өвдөх	БОНМС нь түр зуурын болон байнгын ажиллах хүчний бөөгнөрлөөс болж тархаж болзошгүй халдварт өвчин, усаар дамжин халдвар тархах, олон нийтийг хамрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, багасгах шаардлагуудыг багтаасан байх.	БОНМС-д тусган оруулах	
Гүйцэтгэлийн стандарт 5. Газар чөлөөлөх болон нүүлгэн шилжүүлэх			
Засгийн газрын оролцоотой нүүлгэн шилжүүлэлтийг удирдан зохион байгуулах	Засгийн газрын оролцоотой газар чөлөөлөх, амьжиргааг сэргээх, үүрэг, хариуцлагын талаарх заалтуудыг тусгасан Хэрэгжүүлэгч байгууллагын гэрээг (IEA) боловсруулж, хэрэгжүүлэх Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний хэрэгжилт, ОУСК-ын ГС-5 ба МСК-ын нүүлгэн шилжүүлэх бодлого, Монгол Улсын шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих	Монголын МСС болон Хотын газар чөлөөлөх албаны хамтарсан Хэрэгжүүлэгч байгууллагын гэрээ	2021 оны 5-10 сарын хооронд хэрэгжинэ.
Газар чөлөөлөх	Нүүлгэн шилжүүлэх, газар түр хугацаагаар эсвэл бүрмөсөн чөлөөлөхтэй холбогдсон асуудлыг Зураг төслийн зөвлөхийн боловсруулсан НШТ-д тусгасан эсэхэд хяналт тавих. ГС-5 болон Монголын хууль тогтоомжийн шаардлагын биелэлтэд хяналт тавих НШТ-ний дагуу нөхөн төлбөр олгох, зөвлөлдөх (эсвэл шаардлагатай тохиолдолд амьжиргааг сэргээх) үйл явцын ил тод явагдаж буй эсэхэд хяналт тавих	Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө	2020 оны 9 дүгээр сар
Гүйцэтгэлийн стандарт 6. Биологийн олон янз байдлын хамгаалал, амьд байгалийн нөөцийн тогтвортой удирдлага			
Биологийн олон янз байдлын хамгаалал	Дэд бүтцийн гурван төсөл тус бүртэй холбоотой байгалийн амьдрах орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хяналт тавих Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг зохих ёсоор боловсруулахад хяналт тавих.	Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө	Барилгын ажил эхлэхээс өмнө
Амьд байгалийн нөөцийн тогтвортой удирдлага	Бүх дэд төслүүдэд экосистемийн үйлчилгээний үнэлгээ хийлгэх		
Гүйцэтгэлийн стандарт 8. Соёлын өв			
Соёлын өв	Археологи болон соёлын өвийг хамгаалах журам боловсруулж, төслийн вэб хуудаст нийтлэх, төслийн бүх талуудад мэдээлэх Археологи, палеонтологийн судалгаа нь ГС-8 болон Монголын хууль тогтоомжийн дагуу хийгдэж буй эсэхэд хяналт тавих.	Зөвлөхийн боловсруулж буй Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд археологи болон палеонтологийн судалгааны талаар орох ёстой.	2020 оны 9 дүгээр сар

Хүснэгт 3-- Нүүлгэн шилжүүлэх, амьжиргааг сэргээх бодлогын хүрээ

Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ нь Компакт гэрээний дагуу хэрэгжиж буй төслүүдийн нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой нөлөөллийн цар хүрээ, болзошгүй сөрөг нөлөөг тодорхойлоход оршино. Энэхүү бодлогын хүрээ нь төслөөс үүдэн иргэдийн амьжиргаа, амьдралын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээ авах зорилготой юм. Төслийн улмаас нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн аливаа иргэний амьдрах нөхцөлийг сайжруулахад туслах зорилготой ба үүний тулд нөлөөлөлд өртсөн аж ахуйн нэгжүүдэд төслийн талаар мэдээлэх, зөвлөгөө өгөх, нөхөн төлбөр өгөх зэрэг арга хэмжээ авна. Мөн төслийн зураг төсөл боловсруулах шатанд байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, хил хязгаарыг уялдуулах боломж олгох юм. Нэмж дурдахад, байгаль орчин, нийгмийн суурь болон нөлөөллийн судалгааг хяналт, үнэлгээний зохих төлөвлөгөө боловсруулж төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийн амьдралыг тогтвортой байлгахын тулд ашиглана. Нөлөөлөлд өртсөн хүмүүст туслах нь тэдний амьдралаа босгох, аж ахуй эрхлэх зорилгоор газар эзэмших, өмчлөхөд нь дэмжлэг болдог. Монголын МСС-гийн зорилго нь нөлөөлөлд өртсөн хүмүүс болон аж ахуйн нэгжүүдэд нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргахад оролцох боломжийг олгох явдал юм.

Хавсралт 4 -- Онцгой байдал, гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөний төсөл

2.3 Онцгой байдал, гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөө

Онцгой байдалд бэлэн байх нь гамшиг, аюулт нөхцөл байдлаас болж учирч болзошгүй бэрхшээл болон санхүүгийн алдагдалд орох эрсдэлийг бууруулдаг. Аливаа төслийн хэмжээ, бүтэц, байршил болон нэвтрэх орц, гарц зэрэг нь гамшгийн төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлдог.

Онцгой байдал, гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөө нь ихэвчлэн онц нөхцөл байдал үүссэний дараа хэрэгждэг бөгөөд энэ төлөвлөгөөний гол зорилго нь хүмүүсийн амь насыг хамгаалах, гамшгийн нөхцөл байдлыг тогтворжуулах болон гарах үр нөлөөг багасгах юм.

Зураг төсөл боловсруулах зөвлөх болон Барилгын ажил гүйцэтгэгч нар нь төслийн талбайд зориулсан Гамшиг, онцгой байдлын төлөвлөгөөг боловсруулах бөгөөд холбогдох арга хэмжээг авах юм. Үүнд:

- Онцгой байдал, гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөний бичиг баримтыг боловсруулан, холбогдох мэдээллийг нөлөөлөлд өртсөн иргэд болон төрийн байгууллагуудад мэдээлэх;
- Төслийн үйл ажиллагаа болон төсөл хэрэгжиж буй орон нутагт суурилсан эрсдэл болон нөлөөллийг тодорхойлох (байгалийн гамшиг, геополитикийн эрсдэл гэх мэт);
- Нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдэд болзошгүй гамшгийн эрсдэлийн талаар мэдээлэл өгөх (ёс, заншил соёлын зөв зохистой байдлаар);
- Орон нутгийн иргэд болон төрийн байгууллагуудад гамшиг тохиолдсон үед авах арга хэмжээг үр дүнтэй байлгах зорилгоор туслах, хамтран ажиллах;
- Хэрэв тухайн орон нутгийн төрийн байгууллагууд гамшгийн эсрэг арга хэмжээ авах хангалттай нөөц бололцоо байхгүй тохиолдолд орон нутгийн иргэдэд туслалцаа үзүүлэхэд идэвхтэй оролцох.

Гамшгийн төлөвлөлт нь дараах зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

- Аюулыг тодорхойлох болон үнэлэх (тээвэрлэлт, ачилт, өргөх, тоног төхөөрөмж эсвэл бүтээгдэхүүн суурилуулах, түр зуурын байгууламжууд, түүхий эд хадгалах агуулах, ашиглалтад оруулах гэх мэт);
- Харилцаа холбооны бүтэц (Онцгой байдлын ерөнхий газар 18001105, Эрүүл мэндийн түргэн тусламж 103, Гал унтраах анги 101, Цагдаа 102);
- Гамшгийн үед авах арга хэмжээ (тайван байх, нөхцөл байдлыг үнэлэх, тушаал хүлээн авах, хамгаалалт бий болгох, тусламж үзүүлэх, харилцаа холбоо тогтоох);

- Тайлагнах болон ослын дараах стрессийн үед авах арга хэмжээ (орон нутгийн эмнэлэг, түргэн тусламжийн үйлчилгээ, мөн эмнэлгийн мэргэжлийн хүмүүс туслах боломжтой).

Онцгой байдал, гамшгийн тодорхойлолт

Онцгой байдал гэдэг нь Ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд шууд заналхийлэх өндөр магадлал үүсэх, хүний амь нас хохирсон, эрүүл мэндэд нөлөөлсөн, эд хөрөнгө болон байгаль орчинд хохирол учирсан, эсвэл яаралтай арга хэмжээ авах шаардлагатай нөхцөл байдал болон тохиолдол үүссэнийг хэлнэ.

2.3.1.1.1 Онц байдлын төрөл

- Эрүүл мэндийн онц байдал – Жишээ нь: ажилтан гэмтэх, зүрхний шигдээс болох гэх мэт;
- Хорт бодис алдагдсан үеийн онц байдал – Жишээ нь: Химийн бодис алдагдсан, гидравлик хоолой гэмтсэн гэх мэт;
- Сүйрлийн үеийн онц байдал – Жишээ нь: газар хөдлөлт, хар салхи, хуй салхи эсвэл маш хүчтэй салхилалт гэх мэт;
- Аюулгүй байдалд заналхийлсэн онц байдал – Хүн болон эд хөрөнгө аюулд өртөх.

Эрсдэлийн төрөл

- Байгалийн аюулт үзэгдэл: Үер, газар хөдлөлт, ган гачиг зэрэг цаг уурын хүндрэлтэй нөхцөл зэрэг нь Баруун эх үүсвэрийн худгууд, Дэвшилтэт технологи бүхий ус цэвэршүүлэх байгууламж, цахилгааны шугамууд, ус дамжуулах шугам хоолой болон Ус дахин боловсруулах үйлдвэр байгуулах төслийн үйл ажиллагаанд хүндрэл учруулах нөхцөл байдал үүсгэх;
- Хүний үйл ажиллагаатай холбоотой эрсдэл: Төсөл хэрэгжих хугацаанд бий болж болохуйц нийгмийн эмх замбараагүй байдал, хүчирхийлэл, терроризм эсвэл дэлбэрэлт болон гал түймэр, барилгын осол, хөрс болон усанд техникийн тос болон түлш алдагдах гэх мэт;
- Техник, технологитой холбоотой эрсдэл: химийн эсвэл атомын цахилгаан станцад санамсаргүй дэлбэрэлт болох аюултай бодис тээвэрлэх үед гарах осол гэх мэт;
- Дэд бүтэцтэй холбоотой: зам, ус, цахилгаан, ариутгах татуурга, харилцаа холбоо нурах эвдрэх;
- Эрүүл мэнд: Цар тахал (Ковид-19), голомтот халдвараас үүдэн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний үйл явцад олон нийтийн хэлэлцүүлэг болон оролцогч талуудын уулзалт явагдах боломжгүй болох гэх мэт.

Ажлын талбар дээр онцгой байдал үүссэн тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?

А. “А” зэрэглэлийн онцгой байдал – Эрүүл мэнд

1. Хамгийн ойр буй удирдах ажилтанд нэн даруй мэдэгдэх. Өөрийн нэр, байршил, өвдсөн эсвэл эрүүл мэнд нь эрсдэлд орсон хүний нэр болон үүссэн нөхцөл байдлын талаарх товч мэдээлэл, шинж тэмдэг, осол болон гэмтлийн талаарх мэдээлэл өгөхөд бэлэн байх;
2. Оффис руу мэдээ хүргэхээс бусад тохиолдолд гэмтсэн хүнийг орхихгүй байх, хэрэв орхисон бол яаралтай буцаж ирэх;
3. Гэмтсэн хүнийг хөдөлгөхгүй байх.


В. “Б” зэрэглэлийн онцгой байдал – Хорт бодис агуулсан материал алдагдах

1. Хамгийн ойр буй удирдах ажилтанд нэн даруй мэдэгдэх. Өөрийн нэр, байршил, онцгой байдлын талаарх товч мэдээлэл, алдагдсан эсвэл асгаралтын талаарх нөхцөл байдал болон шалтгаан, гэмтэл болон бусад хорт хаягдал талаарх мэдээллийг өгөхөд бэлэн байх;
2. Тухайн газар дээр байгаа тоног төхөөрөмж нь тус нөхцөл байдалд яаралтай тусламж үзүүлж чадах эсэхийг үнэлэх;
3. Хэрэв тийм бол, зөвхөн өөрт болон бусад аюул учрахгүй, хорт бодис агуулсан материал дахин асгарахгүй нөхцөл байдалд л хэрэглэнэ.

С. “В” зэрэглэлийн онцгой байдал – Сүйрлийн хэмжээний онц аюултай нөхцөл байдал

1. Хамгийн ойр буй удирдах ажилтанд нэн даруй мэдэгдэх. Өөрийн нэр, байршил, өвдсөн эсвэл эрүүл мэнд нь эрсдэл орсон хүний нэр болон үүссэн нөхцөл байдлын талаарх товч мэдээлэл өгөхөд бэлэн байх;
2. Томилогдсон удирдах ажилтан ажлын талбар дээр байгаа хүмүүсийн тоог нэн даруй гаргана;
3. Төслийн талбайн менежер эсвэл Оффис менежер Онцгой байдлын ерөнхий газарт нэн даруй мэдэгдэн, нөхцөл байдлыг үнэлнэ.

Зураг 4-т Онцгой байдлын нөхцөл байдал үүсгэж болзошгүй эрсдэл болон аюулыг дүрслэв. Зураг 5-д онцгой байдлын үед авах арга хэмжээний алхам бүрийг тайлбарлав.



Зураг 4, Онцгой байдлын нөхцөл байдал үүсгэж болзошгүй эрсдэл болон аюулууд Төлөвлөгөөг хэрэгжүүлэх

Идэвхжүүлэлт

Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө нь дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэрэгжиж эхэлнэ. Үүнд:

- Хэн нэгэн төслийн талбар дээр гарсан ослын талаар мэдэгдсэн тохиолдолд;
- Орон нутгийн байгууллагууд болон эрх баригчдаас тухайн орон нутагт болон төслийн талбарт нөлөөлж болохуйц болон болж буй онцгой байдлын талаар

мэдэгдсэн тохиолдолд;

- Утаа мэдрэгч ажиллаж эхэлсэн тохиолдолд.

Мэдэгдэл

Төлөвлөгөө идэвхэжсэнээс нэн даруйд дараах газарт мэдэгдэл хүргүүлэх шаардлагатай. Үүнд:

- Монголын МСС-гийн Оффис менежер эсвэл Хүний нөөцийн менежер (77111710)
- Яаралтай тусламж авах талаар (18001105, Түргэн тусламж 1038 Гал унтраах анги 101, Цагдаа 102)
- Ажилтнуудад
- Эрүүл мэндийн яам (цар тахлын дэгдэлт 119, 100, 103) эсвэл Байгаль орчин, аялал жуулчлалын яам (хорт бодис асгарах гэх мэт).

Нүүлгэн шилжүүлэлт

- Ажилчид ажлын талбарын аюулгүй байдлыг хангах ёстой;
- Тухайн талбарыг нүүлгэн шилжүүлэх (олон цэгүүдэд);
- Зөвхөн аюулгүй тохиолдолд гэмтсэн хүмүүст туслах;
- Цугларах цэг рүү явах;
- Хүмүүсийг тоолох;
- Нүүлгэн шилжүүлэх гарц бүхий төслийн талбайн төлөвлөгөө.

Онцгой байдлын багтай хамтрах

- ОБЕГ-ын холбогдох ажилтанд нөхцөл байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэх, нөөц бололцоогоор хангах;
- Төслийн талбар дээрх эд зүйлсийн талаарх мэдээллээр хангах;
- ОБЕГ-ын галын ослын үеийн ахлагчид алга болсон хүмүүс болон тэдний ойролцоох байршлын талаар мэдэгдэх;
- Аюулгүй байдлын талаар ОБЕГ-ын холбогдох ажилтан болон цагдаа нартай хамтрах;
- Гэмтсэн хүмүүсийн талаарх ОБЕГ-ын холбогдох ажилтан болон Түргэн тусламжийнхантай хамтрах.

Хавсралт 5 – Археологийн болон соёлын өвийн журам

Археологийн болон соёлын өвийн журам нь урьд өмнө мэдэгдэж байгаагүй өвийн нөөц, ялангуяа археологийн нөөцийг төслийн бүтээн байгуулалт, ашиглалтын явцад олох тохиолдолд шаардлагатай арга хэмжээг тодорхой заасан төслийн нарийн үйл ажиллагаа юм. ОУСК-ын ГС-8 болон Монгол Улсын “Соёлын өвийн тухай хууль”-д заасны дагуу Археологийн болон соёлын өвийн журам нь чадварлаг мэргэжилтний үнэлгээ, шаардлагад нийцсэн арга хэмжээ авах хүртэл ховор олдворыг эвдэрч, сүйдэхээс урьдчилан сэргийлэх үйл явц юм.

2.1 Зорилго

Энэхүү журмын зорилго нь Шувуун, Биокомбинат, Сонгинохайрхан уулын орчим хэрэгжих төслийн хүрээнд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний явцад археологийн орд газрууд ил болох магадлалтай холбоотой асуудлыг шийдвэрлэх, археологийн дурсгалт газруудыг баримтжуулж, археологийн олдворыг олж илрүүлэх тохиолдолд протокол хөтлөх, шаардлагатай тохиолдолд хамгаалахад оршино.

2.1 Археологийн дурсгалт газруудад үзүүлэх нөлөөлөл

Газар ухах, хөрс эвдлэх, малтлага зэргийг хамарсан бүтээн байгуулалт нь археологийн материал, олдворт нөлөөлөх боломжтой. Зам барих, газар цэвэрлэх, малталт хийх зэрэг үйл ажиллагаа нь археологийн ордод сөргөөр нөлөөлж болзошгүй үйл ажиллагааны тод жишээ юм.

Шинжлэх ухааны академийн Түүх, археологийн хүрээлэнгийн археологичид 2019 оны 6 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Шувуун, Биокомбинатын ойролцоо Газрын доорх баруун эх үүсвэрийн төслийн талбайд археологийн судалгааг хийж гүйцэтгэсэн ба энэхүү хээрийн судалгааны үеэр Хүрэл зэвсгийн үеийн 10 гаруй булш олж илрүүлсэн байна.

Судалгааны үр дүнд нийт 16 дурсгалыг (эртний хүрэл зэвсгийн үеийн 7 булш, 9 монгол булш) тодорхойлж, төслийн талбайд баримтжуулсан бөгөөд эдгээр дурсгалыг Сонгинохайрхан уулын зүүн энгэр, Туул голын дэнж дээрээс илрүүлсэн. Цаг тооллын хувьд эдгээр дурсгал нь МЭӨ 3-1 мянган, МЭӨ 13-14-р зууны үеийн дурсгалт хөшөөнүүд юм.

Төслийн барилгын бүтээн байгуулалтын ажлын явцад хөшөө дурсгал нь өртөх магадлалтай бөгөөд үүнийг БОНМТ-д тусгах болно.

2.1 Холбогдох хууль тогтоомж

Бүх нийтийн, төрийн болон хувийн газарт байгаа бүх археологийн дурсгалуудыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар хамгаалдаг ба он жил үл хамааран булш, хадны сүг зургууд хамгаалагддаг. Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийхэд зөвшөөрөл авах шаардлагатай ба Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх, соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг хөтлөх, хадгалах үүрэгтэй юм. Мөн Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухаан, спортын яамны харьяа Соёлын өвийн үндэсний төв нь Соёлын биет өв болох түүх, соёлын хөдлөх дурсгалыг хамгаалах үүрэгтэй. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Хавсралт 6 – Талуудын оролцоог хангах төлөвлөгөө

2.1 Талуудын оролцоог хангах төлөвлөгөө

Сонирхогч талуудын оролцоог хангах нь нутгийн иргэдтэй хамтран ажиллах, төслийн үйл ажиллагааг амжилттай эрхлэн явуулахад төдийгүй төслийг улам чанартай хэрэгжүүлэхэд чухал гэж үздэг. Монголын МСС-гийн зүгээс төслийг хэрэгжүүлэх бүх үе шатанд хамаарах оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх бөгөөд үүнд нөлөөлөлд өртсөн иргэдийн онцлог шинж чанарууд болон сонирхол, талуудын өргөн цар хүрээг харгалзан үзэх шаардлагатай байдаг. Үр дүнтэй төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг сонирхож буй, мөн шууд болон шууд бусаар төслийн нөлөөнд өртөж буй оролцогч талуудыг тодорхойлж, оролцогч талуудтай харилцах харилцааг хэрхэн удирдах талаар тусгасан байдаг (Зураг 6-г үзнэ үү).

Зорилго:

- Төсөл хэрэгжиж буй орон нутаг болон, ялангуяа төслийн нөлөөлөлд өртсөн иргэдтэй үр дүнтэй, нээлттэй, ил тод харилцааг тогтоох, хадгалах;
- Нөлөөлөлд өртсөн иргэд, холбогдох талуудад ил тод, бодитой, утга учиртай, хялбар хүртээмжтэй, ойлгомжтой мэдээллийг цаг тухайд нь хүргэх, үнэлгээний ажилд идэвхтэй оролцоход туслах;
- Төсөлд өртсөн орон нутгийн иргэд болон бусад оролцогч талуудыг тасралтгүй оролцуулах замаар төслийн талаарх үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангах;
- Нутгийн оршин суугчдын үзэл бодол, оруулсан хувь нэмрийг төслийн төлөвлөлт болон үйл ажиллагаанд хэрхэн тусгасан талаар эргэн мэдэгдэх механизмыг бүрдүүлэх;
- Төслийн үйл ажиллагаанд шууд өртөж буй иргэд эрчүүд, эмэгтэйчүүд, ахмад настан, залуучууд, нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүс, эмзэг бүлгийн иргэдэд анхаарал хандуулах, хамтарсан оролцоог хангах.

Хууль эрхзүйн шаардлага

Компакт гэрээний дагуу төсөл хэрэгжүүлж буй орнуудад тавигддаг ОУСК-ын ГС болон МСК-ын Байгаль орчны удирдамжийн шаардлагын дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ажилд олон нийтийн оролцоог хангах нь бүхий л эерэг болон сөрөг нөлөөллийг тодорхойлох, тодорхойлсон эрсдэл, нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээг тогтооход тусалдаг ба Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу (Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он) олон нийтийн хэлэлцүүлгийг хийхдээ төслийн талаарх мэдээллийг түгээх, нөлөөллийн цар хүрээ, учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлох зорилгоор төслийн нөлөөлөлд өртсөн иргэд, орон нутгийн засаг захиргаа болон олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэг хийж, саналыг нь авах шаардлагатай байдаг.

Төсөл боловсруулах үе шатнаас оролцогч талуудтай зөвлөлдөх, үйл ажиллагааг эрт эхлүүлэх нь төслийн нөлөөлөл, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар төслийн нөлөөлөлд өртсөн иргэдтэй ярилцаж ойлголцоход эерэг хандлагыг бий болгоход тусална. Олон нийтийн оролцоог БОАЖЯ-аас 2014 онд баталсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журмаар зохицуулдаг. Уг журмын дагуу иргэдийн санал хүсэлтийг нийслэл, сум дүүргийн ИТХ, хорооны иргэдийн нийтийн хуралд тус тус танилцуулж санал авахаар тусгасан.

Иргэдэд тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг шийдвэрлэх, эсвэл татгалзсан байдлаар эргээд ойлгомжтой харилцаатайгаар тусгагдах ёстой.

2014 онд батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх А-117 аргачлалд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа төслийг хэрэгжүүлэх явцад үл ойлголцол бий болох, нэмэлт зардал гарахаас урьдчилан сэргийлж байгаль орчны нарийвчилсан нөлөөллийн үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээлт, хяналт шинжилгээ хийх талаар олон нийтэд танилцуулж санал авсны үндсэн дээр боловсруулах тухай тусгасан байдаг.

Эрсдэл, нөлөөллийг бууруулах, орон нутгийн нийгэм, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор оролцогч талуудын санал хүсэлтийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үр дүн, сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах ёстой ба хэлэлцүүлгийг дараа иргэд, олон нийтэд тэдний үзэл бодол, санал хүсэлт нь төслийн зураг төсөл, шийдвэрт хэрхэн нөлөөлсөн болохыг эргэн мэдэгдэх нь төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх гол алхам юм.



Зураг 5: Талуудын оролцоог хангах үйл явц

Оролцогч талуудыг тодорхойлох

Компакт гэрээний хүрээнд хэрэгжиж буй Ус хангамжийн төслийн оролцогч талуудыг төслийн үйл ажиллагаанд оролцох эрх, сонирхол, төслийн үйл ажиллагааны улмаас эерэг болон сөрөг нөлөөнд автаж байгаа зэргээр нь ангилан тодорхойлно. Эдгээр ангилалд засгийн газрын холбогдох байгууллагууд, гэрээт ажил гүйцэтгэгчид, дэд гэрээлэгч, эрдэм шинжилгээний байгууллагууд, нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд, хэвлэл мэдээллийнхэн, хувийн хэвшил, иргэний нийгэм, төрийн бус байгууллагууд, олон улсын төрийн бус байгууллагууд болон олон нийтийн бүлгүүд багтана.

2.1.1.1.1 Оролцогч талуудын зураглал

Оролцогч талуудын зураглал/ангилал гэдэг нь тухайн оролцогч талуудын төлөөлөл, тэдний ашиг сонирхол, тухайн байгууллагыг зорилгоо хэрэгжүүлэхэд саад болж буй эсвэл дэмжиж буй хүчин зүйл, эсвэл тэдгээрийг шийдвэрлэх арга хэлбэрүүдийн талаар дүрслэн зураглах замаар оролцогч талуудыг тодруулах, ангилах үйл явц, алсын харааны хэрэгсэл юм. Уг зураглалаар тухайн байгууллагын хувьд оролцогч талууд нь хэн болохыг ойлгох боломжийг олгодог ба гол оролцогч талуудыг тодорхойлохын тулд олон талаас нь харуулсан дүн шинжилгээ, хэлэлцүүлгийг хийх үйл явц юм. 8-р хүснэгтэд оролцогч талуудын зураглалыг харуулсан болно.

Оролцооны арга сонгох

Талуудын оролцоог хангах төлөвлөгөөнд Монголын МСС-гийн гэрээлэгч, Засгийн газрын байгууллагууд, төслийн нөлөөлөлд өртсөн орон нутагт амьдардаг оршин суугчид (Шувуун, Биокомбинат, Сонгинохайрхан дүүрэг гэх мэт төсөл хэрэгжих бүсүүд) болон төслийн хүрээнд шууд нөлөөлөлд өртөж буй бусад талуудтай харилцах аргуудыг тодорхойлсон ба байгаль орчин, нийгмийн талын мэдээллийг хамгийн боломжит арга замаар хүргэх талаар тусгасан байна.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга замууд

Талуудын оролцоо нь орон нутгийн засаг захиргаа болон холбогдох Засгийн газрын төлөөлөгчдийн идэвхтэй оролцоо бүхий харилцааны тогтолцоо, бүтэц дээр үндэслэн бий болох ба цаашид хийхээр төлөвлөсөн ажлууд нь хэлэлцэх, мэдээллийг түгээх, мэдээллийн сан бүрдүүлэх илүү системчилсэн арга хэлбэрийг бий болгоно.

Талуудын оролцоо нь дараах мэдээллийг агуулна. Үүнд:

- Мэдээллийн хэлбэр, хугацаа, хуваарилах суваг;

- Нөлөөлөлд өртсөн хүмүүстэй зохион байгуулсан уулзалтын тэмдэглэл, оролцогчдын жагсаалт, уулзалтын байршил;
- Хэлэлцүүлэгт оролцсон газар өмчлөгч, газар ашиглагч, эмзэг бүлгийн иргэд, нутгийн иргэд (төслийн талбайд ойрхон амьдардаг хүмүүс) ба байгууллагууд;
- Төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийн санал, бодол, хөндсөн гол асуудлууд;
- Эргэн харилцах, санал хүсэлтийн мөрөөр авах арга хэмжээ;
- Үйл ажиллагаа, үйл явцыг баримтжуулах, оролцогч талуудад хариу өгөх.

Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө боловсруулахад Монголын МСС нь 7-р зургийн дагуу оролцооны түвшин нэмэгдэж буй чиглэл бүхий оролцооны бүх төрлийг авч үзнэ. Оролцогч талуудын оролцоо нь ил тод, мэдээллийг цаг тухайд нь авах боломжийг бүрдүүлж байх ёстой.



Зураг 6: Талуудын оролцооны хүрээ, Эх сурвалж: Олон нийтийн оролцооны олон улсын холбоо

Олон нийтийн оролцооны хандлагын хүрээ:

- Мэдээлэх - Олон нийтэд тэнцвэртэй, бодитой мэдээлэл хүргэх, тэдэнд тулгарч буй асуудал, хувилбар, боломж, шийдлийг ойлгоход нь туслах явдал юм.
- Зөвлөлдөх - Олон нийтийн санаа бодлыг шийдвэр гаргах түвшинд авч үзэх ба мэдээлэл 2 чиглэлд хэлэлцэгдэх боловч шийдвэр гаргагчид хүлээн авсан саналыг тусгах үүрэг хүлээдэггүй.
- Хамтрах/оролцуулах - Олон нийтийн төлөөлөгчид шийдлийг боловсруулж, шийдвэр гаргахад шууд нөлөөлөх ба энэ нь ихэвчлэн хэлэлцүүлгийн давтамж, харилцан ойлголцол, хамтарсан үүрэг хариуцлагад тулгуурлана.
- Эцсийн шийдвэрийг сонирхогч тал буюу олон нийтийн төлөөлөгчдөд үлдээх буюу шийдвэр гаргах боломжийг олгох явдал юм.

Хүснэгт 8: Гол оролцогч талуудын оролцооны төрөл болон харилцах төлөвлөгөө

Бүлэг	Оролцогч талууд	Сонирхол, нөлөөлөл	Оролцооны төрөл	Арга техник	Хариуцах этгээд
	БОАЖЯ	Их/их	мэдээлэх/зөвлөх/хамтрах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах, тайлан	Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл болон жендэрийн баг, дэд бүтцийн хоёр төслийн баг

Засгийн газар	БХБЯ	Их/их	Мэдээлэх/хам трах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах, тайлан	Дэд бүтцийн хоёр төслийн баг болон жендерийн баг
	ЭХЯ	Их/их	Мэдээлэх/хам трах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах, тайлан	Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн баг
	УСУГ	Их/их	Мэдээлэх/хам трах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах, тайлан	Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл болон жендерийн баг, дэд бүтцийн хоёр төслийн баг
	ОСНААУГ	Их/их	Мэдээлэх/хам трах		Тогтвортой байдлыг хангах төслийн болон жендерийн баг
	ХСУХАТУЗЗ	Их/их	Мэдээлэх/хам трах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах, тайлан	Тогтвортой байдлыг хангах төслийн болон жендерийн баг
	Улаанбаатар хотын захиргаа (дүүрэг, агентлаг)	Их/их	Мэдээлэх/хам трах	Уулзалт, илтгэл, ярилцах болон тайлан	Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, дэд бүтцийн хоёр төслийн баг
	ХУДТГ	Их/их	Мэдээлэх/хам трах	Уулзалт, илтгэл, ярилцах болон тайлан	Байгаль орчин, нийгэм, жендэр, Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн баг
	СХДТГ	Их/их	Мэдээлэх/хам трах	Уулзалт, илтгэл, ярилцах болон тайлан	Байгаль орчин, нийгэм, жендэр, Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн баг
	БХТ	Их/их	Мэдээлэх/хам трах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах,	Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн баг

				тайлан	
	УНЗ	Их/их	Хамтрах/зөвлөх/ шийдвэр гаргах боломжийг олгох	Уулзалт, илтгэл, ярилцах болон тайлан	Байгаль орчин, нийгэм, Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн баг
	МХЕГ	Бага/бага	Мэдээлэх		Байгаль орчин, нийгэм,
	ТГСГЗ	Бага/их	Мэдээлэх/хамтрах	Уулзалт, илтгэл, ярилцах болон тайлан	Байгаль орчин, нийгэм, жендэр, Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн баг болон АЕКМ
	УУХҮЯ	Бага/бага	Мэдээлэх/хамтрах	Уулзалт, цахим шуудан	
	ОБЕГ	Бага/бага	Мэдээлэх	Уулзалт, цахим шуудан	
	ҮХА	Бага/бага	Мэдээлэх	Уулзалт	
	Монгол-ус ТӨҮГ	Бага/бага	Мэдээлэх	Уулзалт	
	Дулааны цахилгаан станц III болон IV	Их/их	Мэдээлэх/хамтрах	Уулзалт, цахим шуудан	Байгаль орчин, нийгэм, жендэр, Хаягдал ус дахин боловсруулах төслийн баг
	ЭкЦА	Бага/бага	Мэдээлэх	Уулзалт	Байгаль орчин
	ҮСХ	Их/их	Мэдээлэх/хамтрах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах, тайлан	Нийгэм, жендэр
	ЖҮХ	Их/их	Мэдээлэх/хамтрах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах, тайлан	Нийгэм, жендэр
	ХХААХҮЯ	Бага/бага	Мэдээлэх/зөвлөх	Уулзалт, цахим шуудан	Хаягдал ус дахин боловсруулах төсөл, Тогтвортой байдлыг хангах төсөл


	Сангийн яам	Бага/бага	Мэдээлэх/зөвлөх	Уулзалт, цахим шуудан	Хаягдал ус дахин боловсруулах төсөл, Тогтвортой байдлыг хангах төсөл
Гэрээлэгч/зөвлөхүүд	АЕКОН	Их/их	Мэдээлэх/хамтрах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах, тайлан	Байгаль орчин, нийгэм, жендэр, Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн баг
	Тетра тек	Их/их	Мэдээлэх/хамтрах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах, тайлан	Байгаль орчин, нийгэм, жендэр, Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн баг
	Би жи эм	Их/их	Мэдээлэх/хамтрах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах, тайлан	Байгаль орчин, нийгэм, жендэр, Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн баг
	ЖЭМР	Их/их	Мэдээлэх/хамтрах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах, тайлан	Байгаль орчин, нийгэм, жендэр, Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн баг
	Монконсалт	Их/их	Мэдээлэх/хамтрах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах, тайлан	Байгаль орчин, нийгэм, жендэр, дэд бүтцийн хоёр төсөл болон тогтвортой байдлыг хангах төсөл
	Коватер Сожема	Их/их	Мэдээлэх/хамтрах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах, тайлан	Нийгэм, жендэр
	Сика	Их/их	Мэдээлэх/хамтрах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт бичиг хянах, тайлан	Нийгэм жендэр
	Чарльз Кендалл	Их/их	Мэдээлэх/зөвлөх/хамтрах	Тогтмол уулзалт, цахим шуудан, баримт	Байгаль орчин, нийгэм, жендэр, дэд бүтцийн хоёр

				бичиг хянах, тайлан	төсөл болон тогтвортой байдлыг хангах төсөл
	Кардно	Их/их	Мэдээлэх/зөвлөх/хамтрах	Тогтмол уулзалт, цахим иуудан, баримт бичиг хянах, тайлан	Байгаль орчин, нийгэм, жендэр, дэд бүтцийн хоёр төсөл болон тогтвортой байдлыг хангах төсөл
Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд	Хан-уул дүүргийн 10, 12 болон 13-р хорооны иргэд СХД-ийн 20, 22 болон 32-р хорооны иргэд Төслийн талбайд ойрхон амьдардаг болон төслийн шууд нөлөөлөлд өртөх, иргэд аж ахуйн нэгж	Их/их	Мэдээлэх/зөвлөх/хамтрах	Бүтцийн ярилцлага Олон нийтийн уулзалт, илтгэл, Өрхийн санал асуулга, судалгаа, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг	Байгаль орчин, нийгэм, жендэр, Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл
Төрийн бус байгууллагууд	Монголын усны форум	Бага/бага	Мэдээлэх	Монголын МСС вэб хуудас/ярилцлага, нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон баримтат нэвтрүүлэг	Олон нийттэй харилцах алба
Олон улсын	Олон улсын усны ассоциаци	Их/их	Мэдээлэх/хамтрах	Монголын МСС вэб хуудас/ярилцлага, нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон	Хаягдал ус дахин боловсруулах төсөл, Байгаль орчин, Тогтвортой байдлыг хангах төсөл

төрийн бус байгууллагууд				<i>баримтат нэвтрүүлэг</i>	
	Жайка	Бага/бага	<i>Мэдээлэх</i>	<i>Монголын МСС вэб хуудас/ярилцлага, нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон баримтат нэвтрүүлэг</i>	Олон нийттэй харилцах баг
	Азийн хөгжлийн банк	Бага/бага	<i>Мэдээлэх</i>	<i>Монголын МСС вэб хуудас/ярилцлага, нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон баримтат нэвтрүүлэг</i>	Олон нийттэй харилцах баг
	Дэлхийн банк	Бага/бага	<i>Мэдээлэх</i>	<i>Монголын МСС вэб хуудас/ярилцлага, нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон баримтат нэвтрүүлэг</i>	Олон нийттэй харилцах баг
	2030 Усны нөөцийн групп	Бага/их	<i>Мэдээлэх</i>	<i>Монголын МСС вэб хуудас/ярилцлага, нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон баримтат нэвтрүүлэг</i>	Хаягдал ус дахин боловсруулах төсөл, Байгаль орчин, Тогвортой байдлыг хангах төсөл
Хэвлэл мэдээлэл	Зурагт	Бага/бага	<i>Мэдээлэх</i>	<i>Монголын МСС вэб хуудас/ярилцлага, нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон баримтат нэвтрүүлэг</i>	Олон нийттэй харилцах баг
	Радио	Бага/бага	<i>Мэдээлэх</i>	<i>Монголын МСС вэб хуудас/ярилцлага, нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон баримтат нэвтрүүлэг</i>	Олон нийттэй харилцах баг

	Сонин хэвлэл	Бага/бага	Мэдээлэх	Монголын МСС вэб хуудас/ярилцлага , нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон баримтат нэвтрүүлэг	Олон нийттэй харилцах баг
	Вэб хуудас	Бага/бага	Мэдээлэх	Монголын МСС вэб хуудас/ярилцлага , нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон баримтат нэвтрүүлэг	Олон нийттэй харилцах баг
Их сургууль	ШУТИС	Бага/бага	Мэдээлэх	Монголын МСС вэб хуудас/ярилцлага , нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон баримтат нэвтрүүлэг	Олон нийттэй харилцах баг
	МУИС	Бага/бага	Мэдээлэх	Монголын МСС вэб хуудас/ярилцлага , нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон баримтат нэвтрүүлэг	Олон нийттэй харилцах баг
Иргэдийн бүлэглэл	Эмнэлэг	Бага/бага	Мэдээлэх	Монголын МСС вэб хуудас/ярилцлага , нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон баримтат нэвтрүүлэг	Олон нийттэй харилцах баг
	Сургууль	Бага/бага	Мэдээлэх	Монголын МСС вэб хуудас/ярилцлага , нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон баримтат нэвтрүүлэг	Олон нийттэй харилцах баг
	Соёлын	Бага/бага	Мэдээлэх	Монголын МСС вэб	Олон нийттэй харилцах баг

	өвийн хүрээлэн			хуудас/ярилцлага , нийтлэл, Зурагтын хөтөлбөр болон баримтат нэвтрүүлэг	
--	-------------------	--	--	--	--



Зураг 7: Гомдол барагдуулах үе шат